ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Монгол Улс, 17032, Улаанбаатар хот,
Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө,
Утас: 77135051,
E-mail: www.emd.gov.mn

2025.04.30 № 80

танай ______________-ны № ______________-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА Л.ЭНХНАСАН ТАНАА

Тайлан хүргүүлэх тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн $14^1$.2-т заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан болон системчилсэн үнэлгээний тайлан, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг хүргүүлж байна.

Хавсралт 134 хуудастай.

ДАРГА Т.МӨНХСАЙХАН

1117149846
ТУ30345 Я 5284708

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2025 он

## АГУУЛГА


**НЭГ.ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

1.1. ЭМДҮЗ-ийн бүтэц, зохион байгуулалт

1.2. ЭМДҮЗ-ийн үндсэн үйл ажиллагаа

**ХОЁР. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ, ТӨСВИЙН БОДЛОГЫН ЗОРИЛТ**

2.1. ДНБ-д эрүүл мэндийн салбарын зардлын эзлэх хувь

2.2. Эрүүл мэндийн салбарын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр

2.3. Хувь хүний халаасны төлбөр

**ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

3.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл

3.2. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ

3.3. Эрүүл мэндийн даатгалын хамралт

3.4. Даатгуулагчийн шимтгэлийн орлого бүрдүүлэлт, зардлын харьцаа

3.5. Эрүүл мэндийн даатгалын гэрээтэй байгууллагууд

**ДӨРӨВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

4.1. ЭМДҮЗ-ийн баталсан тогтоол, онцлох шийдвэрүүд

4.2.Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар

4.3.ЭМДҮЗ-ийн тогтоолын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийсэн талаар

4.4. УИХ-ын Тамгын газраас ЭМДҮЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээний дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар

**ТАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ 2024 ОНЫ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ**

5.1.Эрүүл мэндийн даатгалын гэрээтэй байгууллагууд

5.2. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ

5.3. Анхан шатлалын /ӨСТЭМТ/ тусламж, үйлчилгээ

5.4. Эмийн үнийн хөнгөлөлт

5.5. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ

**ЗУРГАА. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЯНАЛТ, ЦАХИМЖИЛТ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА**

6.1. Эрүүл мэндийн даатгалын хяналт

6.2. Цахимжилт

6.3. Сургалт, сурталчилгаа

**ДОЛОО. ДҮГНЭЛТ, САНАЛ**

7.1.Дүгнэлт

7.2.Анхаарах асуудал, санал

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| УИХ | Улсын Их Хурал |
| НББСШУБХ | Нийгмийн Бодлого,Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Байнгын Хороо |
| НББХ | Нийгмийн Бодлогын Байнгын Хороо |
| ЗГ | Засгийн газар |
| ЭМДҮЗ | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| СЯ | Сангийн яам |
| ДЭМБ | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага |
| ЭМДЕГ | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар |
| НДЕГ | Нийгмийн даатгалын ерөнхий газар |
| ЭМД | Эрүүл мэндийн даатгал |
| ЭМДБ | Эрүүл мэндийн даатгалын байгууллага |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |
| ЭМБ | Эрүүл мэндийн байгууллага |
| ЭМТҮ | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ |
| ТҮ | Тусламж, үйлчилгээ |
| ОХБ | Оношийн хамааралтай бүлэг |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |
| ӨЭМТ | Өрхийн эрүүл мэндийн төв |
| СТЭМТ | Сум, тосгоны эрүүл мэндийн төв |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| ЗХХАУБ | Захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэл |
| ХХДХ | Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ |

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 ЭМДҮЗ-ийн хуралдааны тойм, гишүүдийн ирц 2022-2024 он .................... 6
Хүснэгт 2 ЭМДҮЗ-ийн хуралдааны үйл ажиллагаа, баталсан шийдвэр .................... 7
Хүснэгт 3 ЭМДҮЗ-ийн хуралдааны үйл ажиллагаа, баталсан шийдвэр .................... 7
Хүснэгт 4 ЭМДҮЗ-ийн гишүүдийн албан томилолтоор ажилласан байдал .................... 9
Хүснэгт 5 ЭМДС-ийн сангийн орлогын гүйцэтгэл, 2021-2024 он, мян.төгрөг .......... 13
Хүснэгт 6 ЭМДС-ийн зарлагын гүйцэтгэл, 2021-2024 он, мян.төгрөг .................... 15
Хүснэгт 7 ЭМДС-ийн мөнгөн хөрөнгийн 2023-2024 оны үлдэгдэл, сая.төгрөг ........ 16
Хүснэгт 8 ЭМДС-аас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд 2023-2024 онд .......... 17
Хүснэгт 9 Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ, 2019-2024 он ..... 18
Хүснэгт 10 Эрүүл мэндийн даатгалын хамралт, даатгуулагчийн төрлөөр, ........... 19
Хүснэгт 11 Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн ......... 23
Хүснэгт 12 Эмзэг бүлгийн хүн амыг хамтын төлбөрөөс чөлөөлсөн байдал ............ 24
Хүснэгт 13 Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт .................... 29
Хүснэгт 14 Эрүүл мэндийн байгууллагуудад ЭМДС-аас олгох өглөг, сая төгрөг, .. 31
Хүснэгт 15 Даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын тоо, 2022-2024 он.. 32
Хүснэгт 16 Даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын гэрээний .................... 32
Хүснэгт 17 Тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, тусламж, үйлчилгээний багц, нэр төрлөөр, 2023-2024 он .................... 33
Хүснэгт 19 Өрх, сум, тосгоноос үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээний 2024 оны тохиолдлын тоо, олгохоор тооцсон санхүүжилт, сая төгрөгөөр .................... 39
Хүснэгт 20 СТЭМТ-өөс үзүүлэх 4 төрлийн тусламж үйлчилгээний 2024 оны ......... 39
Хүснэгт 21. Эмийн үнийн хөнгөлөлтийн төсөв, гүйцэтгэл, хамралт .................... 40
Хүснэгт 22 Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, .................... 41
Хүснэгт 23 Урьдчилсан сэргийлэх үзлэгийн хамралт, тохиолдол, санхүүжилт, ..... 41
Хүснэгт 24 ЭМДЕГ-ын хүний нөөцийн өөрчлөлт, 2022-2024 он .................... 42
Хүснэгт 25 ЭМДЕГ-ын хүний нөөцийн цалин, урамшуулал, тусламж .................... 42
Хүснэгт 26 Гэмт хэргийн зөрчлийн улмаас ЭМДС-д төлүүлсэн зардал .................... 43
Хүснэгт 27 Иргэн даатгуулагчдад олгосон буцаан олголт (мян.төг) .................... 43
Хүснэгт 28 Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны ээлжит хуралдааны ирц .................... 49

## СХЕМИЙН ЖАГСААЛТ

Схем 1. ЭМДҮЗ-ийн бүтэц ........ 5

## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1 ДНБ-д эрүүл мэндийн салбарын зардлын эзлэх хувь, 2015-2024 он...... 10
График 2 Засгийн газрын нийт зардалд Эрүүл мэндийн зардлын эзлэх хувь, ....... 11
График 3 Эрүүл мэндийн салбарын санхүүжилт (тэрбум төгрөг), 2015-2024 он.... 11
График 4 Эрүүл мэндийн зардалд анхан шатны тусламж, үйлчилгээний зардлын эзлэх хувь, 2015-2024 он ........ 12
График 5 ЭМДС-ийн 2021-2024 оны орлого, орлогын эх үүсвэрээр (хувиар)......... 14
График 6 ЭМДС-ийн орлого, зарлагын гүйцэтгэл, сангийн тэнцэл (тэрбум төг),.... 16
График 7 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нийт зардалд эзлэх хувь, ЭМБ-ын төрлөөр, 2024 он ........ 17
График 8 Эрүүл мэндийн даатгалын хамралтын хувь, даатгуулагчийн төрлөөр ... 19
График 9 ЭМДС-ийн орлогыг даатгуулагчийн нэр төрлөөр болон даатгуулагчид . 20
График 10 ЭМДС-аас нэн шаардлагатай тусламж, үйлчилгээнд 2020-2024 онд зарцуулсан зардал (хувиар) ........ 23
График 11 Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо, санхүүжилтэд эзлэх хувь, ТҮ- ний нэр төрлөөр ........ 34
График 12 Эмийн үнийн хөнгөлтийн зардлын төсөв, гүйцэтгэл, хамралт,............ 40
График 13 Бэлтгэсэн контентын тоо, 2022-2024 он ........ 45
График 14 Контент хандалтын давхардсан тоо, 2022-2024 он ........ 45
График 15 Контент хуваалцсан тоо, 2022-2024 он ........ 45
График 16 ЭМД-тай холбоотой мэдээ, мэдээллийн үзүүлэлт ........ 46
График 17 Нийгмийн сүлжээгээр цацагдсан байдал байдал. ........ 46
График 18 ЭМДЕГ-т хандсан асуудлуудын талаар ........ 46

## ХАВСРАЛТ 1.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны ээлжит хуралдааны ирц

## НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн $14^1$.1-т "Эрүүл мэндийн даатгалын удирдах дээд байгууллага нь Үндэсний зөвлөл байна.", $14^1$.2-т "Үндэсний зөвлөл нь ажлаа Улсын Их Хуралд жил бүр тайлагнана." гэж тус тус заасан.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т зааснаар эрүүл мэндийн даатгалын байгууллагын тогтолцоо нь Үндэсний зөвлөл, эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн эрүүл мэндийн даатгалын хэлтэс, сумын эрүүл мэндийн даатгал хариуцсан байцаагчаас бүрддэг хуулийн зохицуулалттай.

ЭМДҮЗ нь эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих дээд байгууллага бөгөөд эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаанд даатгагч, даатгуулагч, ажил олгогч, Засгийн газрын тэгш оролцоог хангах, төрийн бодлого, эрүүл мэндийн даатгалын байгууллагын алсын хараа, хэтийн зорилгыг хууль эрх зүйн хүрээнд тодорхойлон хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн хуулиар тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлж байна.

ЭМДҮЗ нь бүтцийн хувьд Засгийн газрыг төлөөлсөн 3 гишүүн, ажил олгогчийг төлөөлсөн 3 гишүүн, даатгуулагчийг төлөөлсөн 3 гишүүн, орон тооны бус нийт 9 гишүүнтэй, өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах чиг үүрэг бүхий ажлын албатай. Ажлын алба нь УИХ-ын НББСШУ-ны байнгын хорооноос баталсан бүтэц, орон тооны дагуу 12 орон тоотойгоос 8 орон тоотойгоор 2024 онд үйл ажиллагаа явуулж ирлээ.

### 1.1.ЭМДҮЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн

*Схем 1 ЭМДҮЗ-ийн бүтэц*




Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн $14^1$.2 дахь хэсэгт заасны ар Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж таван жилийн хугацаагаар томилж, чөлөөлдөг.

Улсын Их Хурлын 2017 оны 40 дүгээр тогтоолоор томилогдсон ЭМДҮЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусcантай холбогдуулан Улсын Их Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 27 дугаар тогтоолоор ЭМДҮЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, Засгийн газрыг төлөөлсөн гишүүнээр Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдыг, даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр Б.Алтанхуяг, Т.Баясгалан, С.Эрдэнэбат, ажил олгогчийг төлөөлсөн гишүүнээр Ж.Гэрэлмаа, Ш.Зоригоо, Н.Одонгуа нарыг тус тус томилсон.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр даатгуулагчийн олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагыг төлөөлсөн Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны ерөнхийлөгч, ЭМДҮЗ-ийн гишүүн С.Эрдэнэбат нь Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдож, ЭМДҮЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ НББХ-нд гаргасан тул ЭМДҮЗ нь 2024 оны сүүлийн хагас жилд 8 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явууллаа.

### 1.2. ЭМДҮЗ-ийн үндсэн үйл ажиллагаа

ЭМДҮЗ-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.10-т "Үндэсний зөвлөл нь улиралд хоёроос доошгүй удаа, шаардлагатай тохиолдолд дарга буюу гишүүдийн олонхын саналаар хуралдах бөгөөд хурлыг бүх талын оролцоог хангасан саналын эрхтэй **гишүүдийн гуравны хоёроос доошгүйн ирцтэйгээр хуралдуулна**." гэж зааснаар 2024 онд 8 удаагийн ээлжит хуралдааныг танхимаар зохион байгуулж, хуралдааны ирц дунджаар 83.2 хувь байна.

*Хүснэгт 1 ЭМДҮЗ-ийн хуралдааны тойм, гишүүдийн ирц 2022-2024 он*

| Он | Хурал-дааны тоо | Хэлэлцсэн асуудал | Батлагдсан тогтоолын тоо | ЗХХАУБ-д бүртгэгдсэн тогтоолын тоо | Гишүүдийн дундаж ирц |
|---|---|---|---|---|---|
| 2022 | 12 | 24 | 18 | 6 | 77.7% |
| 2023 | 6 | 15 | 12 | 6 | 80.3% |
| 2024 | 8 | 25 | 16 | 4 | 83.4% |
| **Нийт** | **26** | **64** | **46** | **14** | **80.4%** |

*Даатгуулагчийн олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагыг төлөөлсөн Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны ерөнхийлөгч, ЭМДҮЗ-ийн гишүүн С.Эрдэнэбат нь Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонтой холбоотой даатгуулагчийг төлөөлсөн нэг гишүүний сул орон тоо гарч, сүүлийн хагас жилд ЭМДҮЗ-ийн хуралдааны ирцэд нөлөөлсөн болно. /Хавсралтаар хүргүүлэв./*

ЭМДҮЗ нь 2024 онд 8 удаа, нийт 23 цаг буюу 1384 минут хуралдаж, 25 асуудал хэлэлцэж, 16 тогтоол батлан гаргасан байна.

*Хүснэгт 2 ЭМДҮЗ-ийн хуралдааны үйл ажиллагаа, баталсан шийдвэр*

| № | Хуралдсан огноо | Гишүүдийн ирц | Хэлэлцсэн асуудлын тоо | Хуралдсан цаг /минутаар/ | Хуралдаанаар баталсан шийдвэрийн тоо |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2024.01.08 | 77.7 | 1 | 120 | 1 |
| 2 | 2024.02.06 | 88.8 | 4 | 144 | 2 |
| 3 | 2024.03.29 | 88.8 | 4 | 300 | 3 |
| 4 | 2024.04.30 | 88.8 | 3 | 55 | 1 |
| 5 | 2024.07.22 | 77.7 | 2 | 200 | 1 |
| 6 | 2024.09.16 | 77.7 | 2 | 225 | 1 |
| 7 | 2024.11.07 | 88.8 | 5 | 225 | 1 |
| 8 | 2024.12.14 | 77.7 | 4 | 115 | - |
| | **Нийт** | **83.2** | **25** | **1,384** | **11/5** |

Одоогийн байдлаар ЭМДҮЗ-ийн 24 тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

## 1.4. ЭМДҮЗ-ийн баталсан тогтоол, шийдвэр

ЭМДҮЗ нь хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн даатгалын бодлого, үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн удирдлага, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн арга, өртгийг тогтоох, чанарын хяналтыг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж ирлээ.

ЭМДҮЗ нь 2024 онд 8 удаагийн ээлжит хуралдаанаар 11 тогтоол, өөрийн дотоод үйл ажиллагаатай холбоотой 5 тогтоол, нийт 16 тогтоол баталж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний 2 актыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд шинээр бүртгүүлж, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний 2 актад нэмэлт өөрчлөлт хийлгэж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

*Хүснэгт 3 ЭМДҮЗ-ийн хуралдааны үйл ажиллагаа, баталсан шийдвэр*

| д/д | Тогтоолын огноо | № | Батлагдсан тогтоол |
|---|---|---|---|
| **Нэг. ЭМДҮЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн баталсан тогтоолууд** | | | |
| 1 | 2024.01.08 | 01 | Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарийг батлах тухай |
| 2 | 2024.02.06 | 02 | Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай /сонгон шалгаруулах/ |
| 3 | 2024.03.01 | 03 | Техникийн хорооны бүрэлдэхүүн, журам шинэчлэн батлах тухай |
| 4 | 2024.03.29 | 05 | Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай тогтоолын төсөл, танилцуулга /анхан шат/ |
| 5 | 2024.03.29 | 06 | Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" тогтоолын төсөл, танилцуулга /лавлагаа шат/ |
| 6 | 2024.03.29 | 07 | Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай /Техникийн хорооны журмын 2.4.8/ |

| | | | |
|---|---|---|---|
| 7 | 2024.04.30 | 08 | Техникийн хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай |
| 8 | 2024.07.22 | 10 | Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай /2024 оны төсвийн хуваарь батлах тухай 01-р тогтоолын 2-р хавсралт/ |
| 9 | 2024.09.16 | 14 | Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоол/ |
| 10 | 2024.11.07 | 15 | Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн нарийвчилсан хуваарийг шинэчлэн батлах тухай тогтоолын төсөл, танилцуулга |
| 11 | 2024.11.07 | 16 | Эрүүл мэндийн даатгалын 2024 оны эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулах тухай" тогтоолын төсөл, танилцуулга |
| | | | **Хоёр. Дотоод үйл ажиллагаатай холбоотой тогтоол** |
| 12 | 2024.03.01 | 04 | Ажлын хэсэг байгуулах тухай |
| 13 | 2024.07.01 | 09 | Урамшуулал олгох тухай |
| 14 | 2024.07.31 | 11 | Ажлаас чөлөөлөх тухай |
| 15 | 2024.08.01 | 12 | Ажилд томилох тухай |
| 16 | 2024.09.10 | 13 | Сургалтад хамруулах тухай |

### 1.3. Улсын Их Хуралд ЭМДҮЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг тайлагнасан тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн $14^1$.2-т "Үндэсний зөвлөл нь ажлаа Улсын Их Хуралд жил бүр тайлагнана." гэж заасны дагуу ЭМДҮЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг 7 бүлэг, 24 дэд бүлгийн хүрээнд ЭМДС-ийн төсвийн гүйцэтгэлийг сүүлийн 3 жилээр харьцуулан судалгаа, шинжилгээ, үнэлгээ хийж боловсруулан дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналыг ЭМДҮЗ-ийн ээлжит хуралдаанаар хэлэлцэж, гишүүд саналаа тусгаж, тайланд эрх бүхий байгууллагаас баталсан холбогдох журмын дагуу системчилсэн үнэлгээ хийж, хууль тогтоомжийн биелэлтийн хамт УИХ-ын НББХ-нд 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүргүүлсэн.

ЭМДҮЗ-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны тайланг сонсгох УИХ-ын НББХ-ны 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн ээлжит хуралдаанд Эрүүл мэндийн сайд, ЭМДҮЗ-ийн дарга Т.Мөнхсайхан, ЭМДҮЗ-ийн гишүүн Б.Алтанхуяг, Т.Баясгалан, Ж.Гэрэлмаа, Ш.Зоригоо, Н.Одонгуа болон ажлын албаны дарга, албан хаагчид, СЯ, ГБХНХЯ, ЭМЯ, ЭМДЕГ-ын холбогдох газар, хэлтсийн дарга нар оролцсон. Хуралдаанд ЭМДҮЗ-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны тайланг Эрүүл мэндийн сайд, ЭМДҮЗ-ийн дарга Т.Мөнхсайхан танилцуулж, тайлантай холбогдуулан НББХ-ны гишүүдийн асуусан асуултад ЭМДҮЗ-ийн гишүүд, холбогдох албан тушаалтнууд хариулт өгч, тайлбар хийж, үйл ажиллагаагаа тайлагнасан.

Улсын Их Хурлын Тамгын газраас ирүүлсэн "Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээ"-нд нийт 11 дүгнэлт, 10 зөвлөмж тусган ирүүлснээс уг зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх хамтарсан ажлын төлөвлөгөөг ЭМДҮЗ-ийн ажлын албаны дарга, ЭМДЕГ-ын дарга хамтран баталж, хэрэгжилтийг хангаж ажилласнаас 80 хувийн биелэлттэй байна.

### 1.4. Албан томилолтоор ажилласан тухай

ЭМДҮЗ-ийн гишүүдээр ахлуулсан ажлын хэсэг 2024 онд орон нутгийн 24, нийслэлийн 22, нийт 46 эрүүл мэндийн байгууллагад албан томилолтоор ажиллаж, нийт 1000 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй уулзаж, ЭМДҮЗ-ийн үйл

ажиллагааны талаар мэдээлэл хүргэж, ЭМДҮЗ-ийн баталсан тогтоол шийдвэрийн хэрэгжилттэй газар дээр нь танилцаж, тулгамдсан асуудлыг сонсож, харилцан санал солилцож ажилласан.

*Хүснэгт 4 ЭМДҮЗ-ийн гишүүдийн албан томилолтоор ажилласан байдал*

| Томилолтоор ажилласан газар | 2023 он | | | 2024 он | | | Нийт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ЭМБ-ын тоо | Хаана | Уулзалтад оролцсон хүний тоо | ЭМБ-ын тоо | Хаана | Уулзалтад оролцсон хүний тоо | ЭМБ-ын тоо | Уулзалтад оролцсон хүний тоо |
| **Нийслэл** | **4** | **ЭМБ-ын нэр** | **50** | **22** | **ЭМБ-ын нэр** | **500** | **26** | **550** |
| Улсын эмнэлэг | 3 | ХСҮТ, ХУЭМТ, СБДЭМТ | 50 | 10 | УНТЭ, УХТЭ, СЭМҮТ, ЭНЭҮТ, ХӨСҮТ, Өргөө АГ, ТЗНЭ, БГДЭМТ, БЗДЭМТ, ЧЭМТ, Налайх дүүргийн ЭМТ | 500 | 13 | 550 |
| Хувийн эмнэлэг | | | | 4 | БЗНЭ, Номун, Дархан детект, Сайнсайхан медикал | | 4 | |
| Өрхийн ЭМТ | 2 | СБЭМТ, ХУЭМТ | | 8 | Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Налайх дүүргийн тус бүр 2 ӨЭМТ | | 8 | |
| **Орон нутаг** | **16** | **Аймгийн нэр** | **110** | **24** | **Аймгийн нэр** | **520** | **40** | |
| ЭМД-ын хэлтэс | 3 | Дархан-Уул, Орхон, Өмнөговь аймаг | 110 | 4 | Баян-Өлгий Төв, Хөвсгөл, Дархан-Уул, Сэлэнгэ аймаг, аймаг | 520 | 5 | 630 |
| Аймгийн ЭМГ | 3 | | | 3 | | | 5 | |
| Улсын эмнэлэг | 3 | | | 4 | | | 5 | |
| Хувийн эмнэлэг | 3 | | | 4 | | | 7 | |
| Сум, өрхийн ЭМТ | 3 | | | 5 | | | 8 | |
| Сувилал | 1 | | | | | | 1 | |
| Эмийн сан | | | | 4 | | | 4 | |
| **Нийт** | **20** | | **160** | **46** | | **1020** | **66** | **1180** |

Томилолтоор ажилласан тайланг ЭМДҮЗ-ийн хуралдаанд тухай бүр танилцуулж, тулгамдсан асуудлыг бодлогын шийдвэрт тусгаж, холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

## ХОЁР. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ, ТӨСВИЙН БОДЛОГЫН ЗОРИЛТ

Дэлхий нийтийн зорьж буй Тогтвортой хөгжлийн зорилгод нийцүүлэн эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн хувьд дараах 4 гол бодлогын зорилтуудын хэрэгжилтийг тооцож ажилладаг. Үүнд:

- Эрүүл мэндийн салбарын улсын зардлын хэмжээг ДНБ-ны 5 хувьд хүргэх, Засгийн газрын зардлыг 12 хувьд хүргэх;

- Анхан шатны тусламж, үйлчилгээнд зарцуулж буй зардлыг ДЭМБ-ын зөвлөж буй жишигт хүргэх буюу ДНБ-ний 1 хувийг анхан шатны тусламж, үйлчилгээнд зарцуулах;
- Хувь хүний халаасны төлбөрийн хэмжээг үе шаттай бууруулж, эрүүл мэндийн нийт зардлын 25 хувьд хүргэж бууруулах;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах тогтолцоотой болох.

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоог өөрчлөх, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор 2020 онд УИХ-аас Эрүүл мэндийн салбарын тухай багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, 2021 оноос санхүүгийн салангид эх үүсвэрүүд болох улсын төсвийн эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэсэн.

Нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн даатгалын байгууллага нь хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан, иргэдийн эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудаас нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг худалдан авах, гэрээлэх, тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хийж санхүүжүүлэх тогтолцоог бүрэн хэрэгжүүлж, төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийн ялгааг арилган, иргэдэд эрүүл мэндийн улмаас учирч байгаа санхүүгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг шат дараатай авсаар байна.

### 2.1. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эрүүл мэндийн салбарын зардлын эзлэх хувь

*Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь:* Манай орны хувьд ДНБ-д эрүүл мэндийн зардлын эзлэх хувь 2014-2020 он хүртэл 2.7-3.6 хувийн хооронд буюу дунджаар 3.0 хувь тогтмол үзүүлэлттэй гардаг байсан. Харин 2021 онд хамгийн өндөр буюу 4.6 хувьд байгаа нь Коронавируст халдварын өвчлөлд улсын төсвөөс нэмэлт санхүүжилт олгосонтой холбоотой байна. Эрүүл мэндийн салбарт санхүүжилтийн шинэчлэл хэрэгжсэнээс хойш буюу 2021-2024 онуудад дундаж нь 3.5 болж өссөн ч 2024 онд Тогтвортой хөгжлийн бодлогын зорилтоос 1.8 пунктээр доогуур байна.

*График 1 ДНБ-д эрүүл мэндийн салбарын зардлын эзлэх хувь, 2015-2024 он*




*Эх үүсвэр: ЭМЯ-ны Санхүү, даатгалын хэлтэс*

**ЗГ-ын нийт зардалд эрүүл мэндийн зардлын эзлэх хувь:** 2015-2020 онд эрүүл мэндийн салбарын зардал[1] өмнөх онтой харьцуулахад жилд дунджаар 8.9 хувиар өссөн байна. Коронавируст халдварын үе буюу 2021 онд эрүүл мэндийн салбарт улсын төсвөөс нэг удаагийн шинжтэй нэмэлт санхүүжилтүүд хийгдсэнтэй холбоотой 12.8 хувьд хүрсэн нь хамгийн өндөр хувьтай байна.

Тайлант онд Засгийн газрын нийт зардалд Эрүүл мэндийн зардлын эзлэх хувь 8.4 хувь байгаа нь Тогтвортой хөгжлийн бодлогын зорилтоос 3.6 пунктээр доогуур буюу өмнөх оноос 0.7 хувиар буурсан байна.

*График 2 Засгийн газрын нийт зардалд Эрүүл мэндийн зардлын эзлэх хувь, 2015-2024 он*




*Эх сурвалж: ЭМЯ-ны Санхүү, даатгалын хэлтэс*

## 2.2. Эрүүл мэндийн салбарын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Монгол Улсын Төсвийн тухай хуулиар жил бүр улсын төсвөөс болон гадаадын зээл тусламжийн хүрээнд эрүүл мэндийн салбарт оруулах хөрөнгө оруулалт, урсгал төсвийн хэмжээг Сайдын багцын төсөвт, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого болон төр хариуцах эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг ЭМДС-ийн төсөвт тус тус батлан хэрэгжүүлдэг.

2024 онд эрүүл мэндийн улсын зардалд эзлэх ЭМД-ын сангийн зардлын хувь 75.7 байгаа нь өмнөх оноос 3.2 хувиар буурсан. Харин эрүүл мэндийн улсын зардалд эзлэх улсын төсвийн шилжүүлгийн хэмжээ 23.0 хувьтай байгаа нь өмнөх оноос 3.0 хувиар өссөн байна.

*График 3 Эрүүл мэндийн салбарын санхүүжилт (тэрбум төгрөг), 2015-2024 он*




*Эх сурвалж: ЭМЯ-ны Санхүү, даатгалын хэлтэс*

---

[1] *Нийт эрүүл мэндийн салбарын зардал нь Улсын төсвийн гүйцэтгэлээр буюу Эрүүл мэндийн сайдын багцын төсөв болон Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийг хамтатган тооцсон дүн болно.*

2021 оноос улсын төсвөөс хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэн, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2020 оноос 3.9 дахин нэмэгдсэн.

*Анхан шатны тусламж, үйлчилгээнд зарцуулж буй зардлын хэмжээ:* Анхан шатны тусламж, үйлчилгээний зардлыг 2021 оноос нэг эх үүсвэрээс санхүүжүүлж эхлэхэд эрүүл мэндийн зардалд анхан шатны тусламж, үйлчилгээний зардлын эзлэх хувь 16 хувь байсан бөгөөд Ковидын цар тахлын улмаас 2022 онд хамгийн өндөр буюу 23 хувьд хүрсэн ч 2024 оны байдлаар 21 хувийг эзэлж буурсан байна.

*График 4 Эрүүл мэндийн зардалд анхан шатны тусламж, үйлчилгээний зардлын эзлэх хувь, 2015-2024 он*




*Эх сурвалж: ЭМЯ-ны Санхүү, даатгалын хэлтэс*

## 2.3. Хувь хүний халаасны төлбөр

Монгол улс нь эрүүл мэндийн даатгалын тогтолцоо нэвтэрснээс хойш иргэний төлөх хамтын төлбөрийн хэмжээг хувиар тогтоож ирсэн бөгөөд олон улсад хамтын төлбөрийг хувьчилж тогтоох нь өндөр өртөг бүхий тусламж, үйлчилгээг авч буй иргэн нь илүү өндөр төлбөр төлдөг тул санхүүгийн эрсдэлд илүү оруулдаг гэж үздэг.

2020 оны байдлаар халаасны төлбөрийн хэмжээ эрүүл мэндийн нийт зардлын 36.4 хувийг эзэлж байна гэсэн судалгаа гарсан тул хувь хүний төлбөрийн хэмжээг 25 хувь хүргэж бууруулах зорилт тавьсан. Даатгуулагчийн төлөх хамтын төлбөрөөс урт хугацаанд эмчлэгддэг хүнд өвчтэй иргэдийг чөлөөлөх, эсвэл бага төлүүлэх, төлсөн хамтын төлбөрийн дүн нь өрхийн орлогын тодорхой хувиас илүү гарсан бол чөлөөлөх буюу хамтын төлбөрийн “тааз” тогтоож чөлөөлөх зэрэг оновчтой бодлого хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

*2.3.1. Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг бүрэн хариуцах:* Эрүүл мэндийн тухай хуулиар төрөх, жирэмсэн, нярайн тусламж, үйлчилгээ, халдварт өвчин, яаралтай тусламж, түргэн тусламж зэрэг нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний зардлыг төр хариуцдаг. Нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнээр иргэн, даатгуулагчийн амь насанд гэнэтийн эрсдэл учруулж болзошгүй

зүрх, тархины мэс засал болон хорт хавдрын бүх төрлийн тусламж, үйлчилгээг хамтын төлбөргүйгээр ЭМД-ын сангаас 100 % хариуцан санхүүжүүлдэг болсон.

*2.3.2. Эмзэг бүлгийн иргэдийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах:* Эрүүл мэндийн даатгалын үндсэн зарчим нь эмзэг бүлгийн иргэдийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах бөгөөд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд иргэний хариуцан төлөх хамтын төлбөрөөс төрөөс шимтгэлийг нь хариуцдаг иргэдийг бүрэн чөлөөлснөөр 2021 онд 39 тэрбум, 2022 онд 47 тэрбум төгрөг, 2023 онд 62.8 тэрбум, 2024 онд 76.8 тэрбум төгрөгийг тус тус чөлөөлсөн байна.

## ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа удирдлага болгон төрөөс эрүүл мэндийн даатгалын талаар баримтлах бодлого, зорилтуудын хэрэгжилтийг хангуулах, даатгалын сангийн орлого, зарлагын тэнцлийг хангах, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллалаа.

### 3.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл

*3.1.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого:* Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 1,964.7 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд ЭМДҮЗ-ийн 2024 оны 01, 10, 15 дугаар тогтоолоор эрүүл мэндийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны 2024 оны төсвийн нарийвчилсан хуваарь болон хуваарийн өөрчлөлтийг тус тус баталж, хэрэгжилтийг хангуулсан.

Орлогын гүйцэтгэл 1,921.7 тэрбум төгрөг, үүнээс ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл 812.6 тэрбум төгрөг, төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл 324.1 тэрбум төгрөг, төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт 746.8 тэрбум төгрөг, бусад даатгуулагчаас төлөх шимтгэл 34.2 тэрбум төгрөг, бусад орлогоос 3.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 97.8 хувийн биелэлттэй байна.

Батлагдсан төсвийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан 2024 онд бусад эх үүсвэрээс буюу Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 69.1 тэрбум төгрөг, ЭМЯ-аас 35.0 тэрбум төгрөг, нийт 104.1 тэрбум төгрөгийг нэмэлт санхүүжилтээр, мөн дансны үлдэгдлээс санхүүжих 5.2 тэрбум төгрөгийг нэмэлтээр төвлөрүүлж, нийт 109.3 тэрбум төгрөгийг нэмэлт эх үүсвэрээр төвлөрүүлжээ. Ингэснээр сангийн нийт орлого 2,031.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 5 ЭМДС-ийн сангийн орлогын гүйцэтгэл, 2021-2024 он, мян.төгрөг*

| № | Төсвийн үзүүлэлт | 2021 оны гүйцэтгэл | 2022 оны гүйцэтгэл | 2023 оны гүйцэтгэл | 2024 он | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төсөв | Гүйцэтгэл | Хувиар |
| | **САНГИЙН ОРЛОГО** | **995,952.3** | **1,219,075.1** | **1,563,809.7** | **1,964,757.3** | **1,921,743.4** | **97.8%** |
| 1 | Ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл | 388,469.0 | 616,566.5 | 859,154.7 | 859,154.7 | 812,662.2 | 94.6% |
| 2 | Төрөөс ЭМД-ыг хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл | 83,951.3 | 228,117.4 | 324,113.0 | 324,113.00 | 324,113.00 | 100.0% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Төр хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилт | 496,465.2 | 687,445.3 | 746,804.8 | 746,804.80 | 746,804.80 | 100.0% |
| 4 | Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл | 17,001.3 | 29,391.7 | 34,684.8 | 34,684.80 | 34,199.40 | 98.6% |
| 5 | Бусад орлого | 10,065.5 | 2,288.8 | 0.0 | - | 3,964.00 | |
| | **НЭМЭЛТ ЭХ ҮҮСВЭР** | **281,875.1** | **557,679.4** | **63,910.5** | - | **109,268.5** | |
| 6 | Нэмэлт санхүүжилт | 73,500.0 | 295,335.1 | 20,000.0 | - | 104,082.93 | |
| 7 | Дансны үлдэгдлээс санхүүжих | 208,375.1 | 262,344.2 | 43,910.5 | - | 5,185.58 | |
| | **НИЙТ САНХҮҮЖИЛТ** | **1,277,827.4** | **1,776,754.5** | **1,627,720.2** | | **2,031,229.1** | |

ЭМДС-ийн орлогыг бүрдүүлж буй орлогын эх үүсвэрийн эзлэх хувийг авч үзвэл 42.3 хувийг ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл, 38.9 хувийг төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт, 16.9 хувийг төрөөс ЭМД-ыг хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл, 1.8 хувийг бусад орлого тус тус эзэлж байна. ЭМДС-ийн орлого өмнөх онтой харьцуулахад ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл 2.9 хувиар, төрөөс ЭМД-ыг хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл 2.3 хувиар өссөн бол төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт 5.1 хувиар, бусад орлого 0.1 хувиар тус тус буурсан байна.

*График 5 ЭМДС-ийн 2021-2024 оны орлого, орлогын эх үүсвэрээр (хувиар)*




*Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар*

*3.1.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага:* ЭМДС-ийн 2024 оны төсвийн тухай хуулиар сангийн зарлагыг 1,933.2 тэрбум төгрөгөөр баталсан. Үүнээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд 1,725.4 тэрбум төгрөг, эмийн үнийн хөнгөлөлтөд 137.3 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардалд 16.4 тэрбум төгрөг, эрсдэлийн санд 53.6 тэрбум төгрөг, илүү төлсөн шимтгэлийн буцаан олголтод 470.9 сая төгрөгийг тус тус зарцуулахаар баталсан.

Тайлант онд сангийн тусламж, үйлчилгээний зардлын олгохоор тооцсон гүйцэтгэл 2,129.8 тэрбум төгрөг, үүнээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд 1,923.3 тэрбум төгрөг, эмийн үнийн хөнгөлөлтөд 137.8 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардалд 15.0 тэрбум төгрөг, эрсдэлийн санд 53.6 тэрбум төгрөг, илүү төлсөн шимтгэлийн буцаан олголтод 25.6 сая төгрөгийг тус тус олгохоор тооцсон нь

эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал 197.9 тэрбум төгрөгөөр, эмийн үнийн хөнгөлөлтийн зардал 478.8 сая төгрөгөөр батлагдсан төсвөөс хэтэрсэн байна. Өмнөх оны өглөг 218.3 тэрбум төгрөгийг 2024 оны төсвөөс олгосонтой холбоотой сангийн нийт зарлага 2,348.1 тэрбум төгрөг байна.

Түүнчлэн 2024 оны эрсдэлийн сангийн 53.6 тэрбум төгрөгөөс лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардалд 43.6 тэрбум, амбулаторийн тусламж, үйлчилгээний зардалд 10.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

*Хүснэгт 6 ЭМДС-ийн зарлагын гүйцэтгэл, 2021-2024 он, мян.төгрөг*

| № | Төсвийн үзүүлэлт | 2021 оны гүйцэтгэл | 2022 оны гүйцэтгэл | 2023 оны гүйцэтгэл | 2024 он | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төсөв | Олгохоор тооцсон гүйцэтгэл | Олгосон гүйцэтгэл |
| | **САНГИЙН ЗАРЛАГА** | **1,542,492.4** | **1,877,320.4** | **1,622,801.6** | **1,933,171.6** | **2,129,752.8** | **2,088,979.2** |
| 1 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт | 1,464,825.9 | 1,477,189.3 | 1,482,480.3 | 1,725,369.4 | 1,923,313.5 | 1,883,015.0 |
| | Үүнээс: Ковидын тусламж, үйлчилгээнд | 543,036.0 | 126,236.4 | - | | | |
| 2 | Эмийн үнийн хөнгөлөлт | 68,948.8 | 80,758.1 | 89,976.0 | 137,322.8 | 137,801.6 | 137,322.8 |
| 3 | Нийгмийн даатгалын байгууллагад олгох | 1,100.0 | 1,100.0 | - | - | | - |
| 4 | Үйл ажиллагааны урсгал зардал | 7,537.7 | 13,259.5 | 10,031.4 | 16,445.8 | 15,049.5 | 15,053.2 |
| 5 | Эрсдэлийн сан | | 40,000.0 | 40,000.0 | 53,562.6 | 53,562.6 | 53,562.6 |
| 6 | Илүү төлсөн шимтгэлийн буцаан олголт | 80 | 348.5 | 313.90 | 470.9 | 25.6 | 25.6 |
| | **ӨМНӨХ ОНЫ ӨГЛӨГ** | | **264,664.9** | **60,565.1** | | **218,321.7** | |
| | **Нийт зарлага** | **1,542,492.4** | **1,877,320.4** | **1,848,041.9** | | **2,348,074.5** | |
| | **Сангийн тэнцэл** | **-264,665.0** | **-60,565.9** | **-218,321.7** | | **-316,845.3** | |

*3.1.3. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэл, сангийн тэнцэл:* Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага жил бүр тогтмол өсөж ирсэн ба жилийн дундаж өсөлт 19 хувь байсан бол 2021 оноос эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлтийн хүрээнд улсын төсвөөс олгодог байсан төр хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилтийг ЭМДС-д нэгтгэн нэг эх үүсвэрээс санхүүжүүлдэг болсноор 2020 онтой харьцуулахад ЭМДС-ийн 2024 ны орлого өмнөх оноос 4.1 дахин, зарлага 5.5 дахин нэмэгдсэн. Тайлант онд ЭМДС-ийн орлого 2,031.2 тэрбум, зарлага 2,348.1 тэрбум байгаа нь өмнөх оноос орлого 357.9 тэрбум төгрөгөөр, зарлага 403.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Ковидын цар тахал, эрүүл мэндийн салбарын цалингийн өсөлт, эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний суурь тариф болон тусламж, үйлчилгээний тохиолдлын тооны өсөлт зэргээс шалтгаалан эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага батлагдсан төсвөөс жил бүр хэтэрснээс

сангийн тэнцэл алдагдаж,  2024 онд эрүүл мэндийн байгууллагуудад 316.8 тэрбум төгрөгийн өглөгтэй гарсан байна.

*График 6. ЭМДС-ийн орлого, зарлагын гүйцэтгэл, сангийн тэнцэл (тэрбум төг), 2020-2024 он*




*Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар*

Тайлант оны жилийн эцэст ЭМДС-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 155.9 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүнээс төрийн сангийн харилцах дансанд 101.1 тэрбум төгрөг, арилжааны банкны харилцах дансанд 54.7 тэрбум төгрөг байна.

*Хүснэгт 7 ЭМДС-ийн мөнгөн хөрөнгийн 2023-2024 оны үлдэгдэл, сая.төгрөг*

| № | Банкны нэр | Данс | 2023 он | 2024 он |
|---|---|---|---|---|
| 1 | Төрийн сан | Харилцах | 66,384.91 | 101,141.69 |
| 2 | Чингис хаан банк | Харилцах | 30,895.73 | 30,575.73 |
| 3 | Хаан банк | Харилцах | 25,335.56 | 9,551.47 |
| 4 | Голомт банк | Харилцах | 13,178.93 | 8,148.95 |
| 5 | Худалдаа хөгжлийн банк | Харилцах | 11,022.23 | 3,334.51 |
| 6 | Төрийн банк | Харилцах | 9,521.86 | 1,070.34 |
| 7 | Капитрон банк | Харилцах | 3,288.07 | 17.66 |
| 8 | Хас банк | Харилцах | 1,429.78 | 2,031.14 |
| | **Нийт** | | **161,057.09** | **155,871.50** |

*3.1.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал:* 2024 оны байдлаар эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд нийт 2,110.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноос эрүүл мэндийн байгууллагын төрлөөр олгосон санхүүжилтийг авч үзвэл улсын эмнэлэгт 1,127.9 тэрбум, хувийн эмнэлэгт 266.8 тэрбум, сувилалд 27.2 тэрбум, анхан шатны эрүүл мэндийн байгууллагад 487.4 тэрбум, эмийн санд 137.8 тэрбум, урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад 31.6 тэрбум, төр хариуцах эмийн зардалд 31.6 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна.

*Хүснэгт 8 ЭМДС-аас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд 2023-2024 онд олгосон санхүүжилт, ЭМБ-ын төрлөөр*

| ЭМБ-ын төрөл | 2023 он | | | 2024 он | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Тохиолд-лын тоо | Мөнгөн дүн /сая.төг/ | Хувиар | Тохиолд-лын тоо | Мөнгөн дүн /сая.төг/ | Хувиар |
| Улсын эмнэлэг | 9,700,766 | 973,465.0 | 54.8% | 9,586,342 | 1,127,901.9 | 53.4% |
| Хувийн эмнэлэг | 1,139,618 | 249,442.6 | 14.1% | 1,366,583 | 266,782.5 | 12.6% |
| Сувилал | 110,022 | 39,292.5 | 2.2% | 98,338 | 27,166.4 | 1.3% |
| Өрх, сум, тосгоны ЭМТ-өөс үзүүлэх 4 төрлийн ТҮ | 1,305,558 | 84,382.4 | 4.8% | 2,097,303 | 141,943.5 | 6.7% |
| Өрх, сум, тосгоны ЭМТ /нэг иргэн/ | | 274,794.1 | 15.5% | | 345,502.6 | 16.4% |
| Төр хариуцах эмийн санхүүжилт | | 11,348.3 | 0.6% | | 31,652.5 | 1.5% |
| Урьдчилан сэргийлэх үзлэг үзүүлж буй ЭМБ | 356,749 | 42,614.7 | 2.4% | 219,206 | 31,626.3 | 1.5% |
| Эмийн сан | 4,298,381 | 99,506.5 | 5.6% | 5,269,352 | 137,801.6 | 6.5% |
| **Нийт** | **16,911,094** | **1,774,846.2** | **100.0%** | **18,637,124** | **2,110,377.3** | **100%** |

2024 оны байдлаар эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд нийт 2,110.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноос эрүүл мэндийн байгууллагын төрлөөр нийт зардалд эзлэх хувийг авч үзвэл улсын эмнэлэгт 53.4 хувь, хувийн эмнэлэгт 12.6 хувь, сувилалд 1.3 хувь, анхан шатны тусламж үйлчилгээнд 23.1 хувь, үүнээс нэг иргэний санхүүжилт 16.4 хувь, өрх, сум тосгоны ЭМТ-өөс үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээ 6.7 хувь, эмийн санд 6.5 хувь, урьдчилан сэргийлэх үзлэгт болон төр хариуцах эмийн зардалд тус бүр 1.5 хувийг тус тус зарцуулсан байна.

*График 7 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нийт зардалд эзлэх хувь, ЭМБ-ын төрлөөр, 2024 он*




### 3.2.Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Энэ хуулийн 6.1-д заасан даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар жил бүр тогтооно" гэж заасан байдаг.

Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Хөдөлмөр,

нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2022 оны 10 дугаар тогтоолуудтай уялдуулж, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 491 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-т заасан даатгуулагчийн сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг түүний сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч, 0-18 насны хүүхэд болон ажил хөдөлмөр эрхлээгүй иргэний сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувиар буюу 6,600 төгрөгөөр, бусад даатгуулагчийн сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2 хувиар буюу 13,200 төгрөгөөр тогтоосон.

*Хүснэгт 9 Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ, 2019-2024 он*

| № | Даатгуулагчийн төрөл | Шимтгэлийн 2020, 2021, 2022 оны хэмжээ | Шимтгэлийн 2023 оны хэмжээ | Шимтгэлийн 2024 оны хэмжээ | Төлөх хугацаа |
|---|---|---|---|---|---|
| | Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ | 420,000 төгрөг | 550,000 төгрөг | 660,000 төгрөг | |
| 1 | Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан | Хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын 4-өөс доошгүй хувиар, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь | | | Сар бүр |
| 2 | 0-18 насны хүүхэд | 4200 төгрөг /ХХДХ-ий 1%/ | 5500 төгрөг /ХХДХ-ий 1%/ | 6600 төгрөг /ХХДХ-ий 1%/ | Сар бүр |
| 3 | Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч | | | | Хагас, эсхүл бүтэн жилээр |
| 4 | Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэн | 4200 төгрөг /ХХДХ-ий 1%/ | 5500 төгрөг /ХХДХ-ий 1%/ | 6600 төгрөг /ХХДХ-ий 1%/ | Хагас, эсхүл бүтэн жилээр |
| 5 | Төрөөс шимтгэлийг нь хариуцан төлөх иргэн | 8400 төгрөг /ХХДХ-ий 2%/ | 11000 төгрөг /ХХДХ-ий 2%/ | 13200 төгрөг /ХХДХ-ий 2%/ | Сар бүр |
| 6 | Гадаадын иргэн,харьяалалгүй хүн | 8400 төгрөг /ХХДХ-ий 2%/ | 11000 төгрөг /ХХДХ-ий 2%/ | 13200 төгрөг /ХХДХ-ий 2%/ | Хагас, эсхүл бүтэн жилээр |

## 3.3. Эрүүл мэндийн даатгалын хамралт

2024 онд эрүүл мэндийн даатгалд 3,274.9 мянган даатгуулагч хамрагдаж, хамрагдалт 93.4 хувьтай байна. Үүнээс аж ахуйн нэгж байгууллагад ажиллагч 770.9 мянга, малчин 51.2 мянга, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, ажилгүй иргэн 117.8 мянга, их, дээд сургууль болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцагч 42.5 мянга, төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцдаг иргэн 2,267.4 мянга, гадаадын иргэн харъяалалгүй хүн 1.3 мянган даатгуулагч эрүүл мэндийн даатгалд хамрагдлаа.

*Хүснэгт 10 Эрүүл мэндийн даатгалын хамралт, даатгуулагчийн төрлөөр, 2022-2024 он*

| № | Хамралтын төрөл | 2022 он | 2023он | Хамрагдвал зохих хүн амын тоо | 2024 он Хамрагдсан даатгуу-лагчийн тоо | Хамрал-тын хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Аж ахуйн нэгж байгууллагын ажилтан | 749.3 | 789.0 | 770.9 | 770.9 | 100.0% |
| 2 | Малчин | 51.9 | 57.1 | 140.5 | 51.2 | 36.4% |
| 3 | Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн | 133.9 | 145.9 | 266.1 | 117.8 | 44.3% |
| 4 | Их дээд, сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагч | 14.3 | 18.8 | 59.3 | 42.5 | 71.7% |
| 5 | Гадаадын иргэн харьяалалгүй хүн | 0.6 | 0.6 | 0.5 | 1.3 | 260.0% |
| 6 | ЭМД-ыг төрөөс хариуцдаг иргэн | 2,250.4 | 2,228.8 | 2,267.4 | 2,291.2 | 101.0% |
| | **Нийт дүн** | **3,200.5** | **3,240.2** | **3,504.7** | **3,274.9** | **93.4%** |
| | **Хамралтын хувь** | **92.5%** | **92.5%** | | **93.4%** | |

Тайлант онд сүүлийн 3 жилийн статистик судалгаанд үндэслэн улсын хэмжээнд хамрагдвал зохих малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, оюутан суралцагч тус бүрээр эрүүл мэндийн даатгалын хамралтын төлөвлөгөөг ЭМДЕГ-ын даргын тушаалаар баталж, төв, орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлж, мэргэжил арга зүйгээр хангаж, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

Засгийн газрын “Оюутны талаар авах зарим арга хэмжээний тухай” 2023 оны 111 дүгээр тогтоолын дагуу их дээд, сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагч оюутнуудыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт хамруулах зорилгоор нэг удаагийн шинжтэй эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төрөөс хариуцан төлсөнтэй холбоотой их дээд, сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагчдын хамралт 42.5 мянгад хүрч, хамралт өмнөх оноос 2.3 дахин нэмэгдсэн.

*График 8 Эрүүл мэндийн даатгалын хамралтын хувь, даатгуулагчийн төрлөөр*



Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, иргэд, даатгуулагчдад эрүүл мэндийн даатгалын ойлголт, ач холбогдлыг сурталчлан таниулах ажлын үр дүнд эрүүл мэндийн даатгалд хамрагдсан нийт даатгуулагчийн тоо өмнөх оноос 34.7 мянган даатгуулагчаар, хамралтын хувь 0.9 хувиар нэмэгдэж, гадаадын иргэн, харъяалалгүй хүний хамралт 2.6 дахин өссөн зэрэг үр дүнтэй байна.

Нийгмийн даатгалын тухай ерөнхий хууль 2024 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой "Шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэд"-ийн орлогыг эрүүл мэндийн даатгалын байгууллага хариуцан төвлөрүүлж эхэлсэн бөгөөд энэхүү орлого төвлөрүүлэлтийн үйл ажиллагааг И-монголиа, И-баримт системийг ашиглан бүрэн цахимжуулж, харин цахим хэлбэрээр төлөх боломжгүй иргэдийн асуудлыг арилжааны банкаар дамжуулан төлүүлсэн. Шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчид нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ шаардлагатай үедээ эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлдөг буруу зан үйл, хандлагаас шалтгаалан хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчдын хамралт өмнөх оноос буурсан байна.

### 3.4. Даатгуулагчийн шимтгэлийн орлого бүрдүүлэлт, тусламж, үйлчилгээ авсан зардлын харьцаа

Эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлогыг даатгуулагчийн нэр төрлөөр, тухайн даатгуулагчид эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулсан зардлын эзлэх хувиар харьцуулан гаргахад:

a. Цалин түүнтэй адилтгах орлогоос шимтгэл төлж буй даатгуулагч нь нийт даатгуулагчийн 23 хувийг эзэлж, нийт шимтгэлийн орлогын 69.4 хувийг бүрдүүлж, сангаас зарцуулсан зардлын 12.8 хувийг эзэлж байна.
b. Төрөөс шимтгэлийг нь хариуцах иргэд нь нийт даатгуулагчийн 70 хувийг эзэлж, нийт шимтгэлийн орлогын 27.7 хувийг бүрдүүлж, сангаас зарцуулсан зардлын 77.2 хувийг эзэлж байна.
c. Шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагч нь нийт даатгуулагчийн 6.0 хувийг эзэлж, нийт шимтгэлийн орлогын 2.9 хувийг бүрдүүлж, сангаас зарцуулсан зардлын 10.0 хувийг эзэлж байна.

*График 9 ЭМДС-ийн орлогыг даатгуулагчийн нэр төрлөөр болон даатгуулагчид ЭМДС-аас зарцуулсан зардлын эзлэх хувь*



Төрөөс шимтгэлийг нь хариуцах иргэдэд 0-18 насны хүүхэд, тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэн, хүүхдээ хоёр (ихэр бол гурав) нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх (эцэг), хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч болон ял эдэлж байгаа ялтан хамаардаг бөгөөд нийт 2.3 сая гаруй даатгуулагчийн шимтгэлийг төрөөс хариуцдаг. Эдгээр иргэд нь нийт шимтгэлийн орлогын 27.7 хувийг бүрдүүлж, сангаас зарцуулсан зардлын 77.2 хувийг эзэлж байгаа нь зарлага нь орлогоос 2.8 дахин их байна.

## ДӨРӨВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

УИХ-аас 2020 онд Эрүүл мэндийн салбарын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн салбарт санхүүжилтийн шинэчлэлийг 2021 оноос хэрэгжүүлж ажилласан. Тус шинэчлэлийн бодлогын өөрчлөлтийн хүрээнд дараах 6 гол зорилтыг дэвшүүлж холбогдох хуулиудад өөрчлөлт оруулсан байдаг. Үүнд:

1. Улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын сангийн салангид үр ашиггүй эх үүсвэрүүдийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэж, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлэх;
2. Эрүүл мэндийн даатгалын сангийн даатгуулагчдад үзүүлэх санхүүгийн хамгаалалтыг нэмэгдүүлэх зорилгоор жилийн дээд хязгаарыг хүчингүй болгох;
3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг хянах, үнэлэх тогтолцоог бий болгож, санхүүжилттэй уялдуулах;
4. Эмийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үнийг бууруулах;
5. Хөнгөлөлттэй эмийн хүртээмжийг нэмэгдүүлж, чирэгдлийг арилгах;
6. Ажлын гүйцэтгэлтэй уялдсан цалин урамшууллын тогтолцоог бий болгох;

Дээрх 6 зорилтын хүрээнд тодорхой үр дүнгүүд гарсан хэдий ч эрүүл мэндийн даатгалын тогтолцооны үр дүнг сайжруулахаар Засгийн газрын зүгээс Азийн хөгжлийн банк, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын техник туслалцааны төсөл хэрэгжүүлж, өнгөрсөн 4 жилийн хугацаанд Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, төрийн өмчийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудуудыг хамруулсан сургалтууд хийж, бодлогын баримт бичиг боловсруулах, тооцоолол, судалгаа хийх, олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэхэд дэмжлэг авч ажиллалаа.

**ЭМДҮЗ-ийн онцлох шийдвэрүүд**

*4.1.1. ЭМДҮЗ-ийн 05 дугаар тогтоолоор өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн албан хаагчдын үндсэн цалин, орон нутгийн нэмэгдлийг өсгөж, тусламж, үйлчилгээний тарифыг шинэчиллээ.*

- ✓ Орон нутгийн өрхийн эрүүл мэндийн төвүүд болон сум, тосгоны эрүүл мэндийн төвийн албан хаагчдын үндсэн цалинг 10 хувиар өсгөж, орон нутгийн нэмэгдлийг 40 хувьд хүргэх холбогдох тооцооллыг цалингийн тохируулга хэсэгт тусгалаа.

- ✓ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу байгуулагдсан 1500-аас доош хүн амтай 23 сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс нэг иргэнээр тооцох санхүүжилтэд хүн амаас хамаарсан тэгш байдлын индексийн коэффициентийг 2 дахин, оношилгоо, шинжилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, зарим сэргээн засах, өдрийн эмчилгээний тарифыг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлсэн.
- ✓ Өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээг өргөжүүлж хүүхдийн өдрийн эмчилгээний багц, хүүхдийн халдварт бус суулгалт өвчний багцуудыг шинээр үүсгэснээр лавлагаа шатлалын ачааллыг бууруулах, анхан шатандаа хүртээмжтэй тусламж, үйлчилгээг авах нөхцлийг бүрдүүлсэн.
- ✓ Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээний багцыг өргөжүүлж, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ болон хүүхэд, тулгуур хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмнэлэгт ирэх боломжгүй ахмад настанд зайлшгүй үзүүлэх тусламж, үйлчилгээг шинээр нэмсэн.

*4.1.2. ЭМДҮЗ-ийн 06, 14 дүгээр тогтоолоор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад үндсэн тусламж, үйлчилгээг нутагшуулахаар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн багийн үйл ажиллагааг бодлогоор дэмжлээ.*

- ✓ Алслагдмал, хүн ам цөөтэй аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагыг дэмжих, эрүүл мэндийн салбарын албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх зорилгоор эрүүл мэндийн даатгалын сангаас олгож буй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд бүсчлэлийн коэффициентийг тогтоож, суурь тарифыг 4 хувиар нэмэгдүүллээ. Тухайлбал, баруун бүсэд 1.15, нийслэлд 1.0 байхаар тохируулга хийснээр баруун бүсийн эрүүл мэндийн байгууллагууд нийслэлийнхээс 15 хувиар илүү тарифаар санхүүжих болсноор иргэн амьдарч буй газраа санхүүгийн эрсдэлгүйгээр шаардлагатай тусламж, үйлчилгээг авах боломжийг бүрдүүллээ.
- ✓ Эрүүл мэндийн даатгалын сангийн үр ашгийг сайжруулах үүднээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртгийн судалгаанд үндэслэн өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээг амбулаторийн тусламж, үйлчилгээний багцад нэгтгэж, багцыг өргөтгөлөө.
- ✓ Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдэд төвлөрсөн хорт хавдар, зүрх судас, хүүхдийн шүд амны хөндий, ерөнхий мэс заслын тусламж, үйлчилгээг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад үндсэн тусламж, үйлчилгээг нутагшуулах зорилгоор төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн багийг орон нутагт ажиллуулсан тохиолдолд нэмэгдэл урамшуулал олгох зохицуулалтыг хийлээ.

*4.1.3.Даатгуулагч эрүүл мэндийн зарим тусламж, үйлчилгээг эмнэлэгт хэвтэлгүйгээр амбулаториор, өдрийн эмчилгээгээр авах боломжийг өргөжүүллээ.*

Эрүүл мэндийн даатгалын сангийн үр ашгийг сайжруулах, шаардлагагүй өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний тоо хэмжээг бууруулах үүднээс бодлогоор амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний шинэ багцыг бий болгож, амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүллээ.

*4.1.4. Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний ЭМДС-ийн тусламж, үйлчилгээний зардалд эзлэх хувийг нэмэгдүүллээ.*

Нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнээр даатгуулагчийн амь насанд гэнэтийн эрсдэл учруулж болзошгүй төрөх, жирэмсэн, нярайн тусламж, үйлчилгээ, халдварт өвчин, хавдар, түргэн тусламж, яаралтай тусламж зэрэг нэн шаардлагатай тусламж, үйлчилгээнд зарцуулах зардлын хэмжээг тогтмол нэмэгдүүлснээр 2024 онд 84.2 хувьд хүрч, 2020 онтой харьцуулахад 2 дахин өссөн байна.

*График 10 ЭМДС-аас нэн шаардлагатай тусламж, үйлчилгээнд 2020-2024 онд зарцуулсан зардал (хувиар)*




*4.1.5.Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлснээр хорт хавдрын болон яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагын тоо өсөж, төрөлжсөн төв эмнэлгийн төвлөрлийг сааруулдаа.*

Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний зардлыг нэмэгдүүлснээр тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагын тоог 2021 онтой харьцуулахад хорт хавдрын мэс засал үзүүлэх ЭМБ-ын тоо 7.8 дахин, хорт хавдрын хими, бай эмчилгээ үзүүлэх ЭМБ-ын тоо 2.8 дахин нэмэгдсэн бол яаралтай тусламж үзүүлэх ЭМБ-ын тоо 13.0 хувиар нэмэгдсэн байна.

*Хүснэгт 11 Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагуудын тоо*

| № | Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний төрөл | 2021 он | 2022 он | 2023 он | 2024 он | Өсөлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хорт хавдар хими, бай | 13 | 16 | 30 | 37 | 184.6% |
| 2 | Хорт хавдар хөнгөвчлөх | 26 | 37 | 41 | 46 | 76.9% |
| 3 | Хорт хавдар мэс засал | 5 | 20 | 38 | 39 | 680.9% |
| 4 | Яаралтай тусламж | 54 | 62 | 61 | 61 | 13.0% |

*4.1.5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд иргэдийн халааснаас төлөх хэмжээг бууруулдаа.*

ДЭМБ-аас хийсэн судалгаагаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг авч буй иргэнээс төлөх төлбөрийн хэмжээг хувиар тогтоох нь иргэд санхүүгийн хувьд ядууралд илүү өртдөг тул хамтын төлбөрийн бодлогод өөрчлөлт оруулж, хамтын төлбөрийн хэмжээг хувиар биш тогтмол мөнгөн дүнгээр төлөх хэлбэрт шилжүүлснээр өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээнд иргэдийн төлөх төлбөрийн

хэмжээ буурсан. Тухайлбал, элэг шилжүүлэн суулгах мэс заслын төлбөрийн хэмжээ 113.6 сая, даатгуулагч хувиасаа 28.4 сая төгрөг төлдөг байсныг 5.0 сая төгрөг болгон бууруулснаар халааснаас төлөх төлбөрийн хэмжээ өмнөхөөс 5.7 дахин буурсан.

*4.1.6. Эмзэг бүлгийн иргэдийг санхүүгийн эрсдэлээс хамгаалж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төлөх хамтын төлбөрөөс чөлөөллөө.*

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төрөөс хариуцдаг иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд иргэний хариуцан төлөх хамтын төлбөрөөс бүрэн чөлөөлснөөр 2021 онд 39 тэрбум, 2022 онд 47 тэрбум төгрөг, 2023 онд 62.8 тэрбум төгрөгийг, 2024 онд 76.8 тэрбум төгрөгийг хамтын төлбөрөөс чөлөөлсөн нь 2021 онтой харьцуулахад бараг 2 дахин өссөн байна.

*Хүснэгт 12 Эмзэг бүлгийн хүн амыг хамтын төлбөрөөс чөлөөлсөн байдал 2022-2024 он /тэрбум төгрөгөөр/*

| № | Хамтын төлбөрөөс чөлөөлөх бүлэг | Хамтын төлбөрөөс чөлөөлсөн дүн | | |
|---|---|---|---|---|
| | | 2022 он | 2023 он | 2024 он |
| 1 | Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн | 3.26 | 7.34 | 8.67 |
| 2 | Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн | 30.69 | 42.71 | 49.62 |
| 3 | Ял эдэлж байгаа ялтан | 0.05 | 0.04 | 0.04 |
| 4 | 0-18 насны хүүхэд | 10.12 | 13.51 | 16.18 |
| 5 | Хугацаат цэргийн алба хаагч | 0.04 | 0.06 | 0.06 |
| 6 | Хүүхдээ хоёр /ихэр бол гурав/ нас хүртэл өсгөн бойжуулж буй эх, эцэг | 2.97 | 1.85 | 2.18 |
| | **Нийт** | **47.16** | **62.81** | **76.75** |

**4.2.Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар:**

*4.2.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах орон тооны бус техникийн хороог байгууллаа.*

ЭМД-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.12 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд ЭМДҮЗ-ийн 2024 оны 03 дугаар тогтоолоор “Техникийн хорооны бүрэлдэхүүн, ажиллах журам”-ыг шинэчлэн баталж, орон тооны бус техникийн хорооны гишүүнийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг нээлттэй зохион байгуулсан. Сонгон шалгаруулалтад оролцсон техникийн хорооны гишүүнд нэр дэвшигчдийг ЭМДҮЗ-ийн хуралдаанд нэр дэвшигч бүрээр танилцуулж, ЭМДҮЗ-ийн 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор орон тооны бус техникийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 2021 оноос хойш хэрэгжээгүй байсан хуулийн хэрэгжилтийг хангууллаа.

Техникийн хороо байгуулагдсанаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар хараат бус, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргах бодит нөхцөл бүрдсэн ч эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024-2025 оны үйл ажиллагааны зардлын төсөвт тус хорооны гишүүдийн урамшууллын зардал батлагдаагүйн улмаас 2024 онд

техникийн хороо ажиллаагүй болно. Харин 2025 онд 4 тогтоолын төсөл дээр 14 дүгнэлт, 38 зөвлөмжийг гаргаж, ЭМДҮЗ-ийн хуралдаанд танилцуулаад байна.

*4.2.2. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийг шинэчлэн батлууллаа.*

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн $14^1$.4-т "Үндэсний зөвлөлийн дүрмийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо батална." гэж заасан тул Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийг шинэчлэн батлах тухай тогтоолын төслийг шинэчлэн боловсруулж, 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 131 дугаартай албан тоотоор НББХ-нд дахин хүргүүлсэн. Шинэчилсэн дүрмийн төсөлд хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан 23 заалтыг өөрчлөн найруулж, 17 заалтыг шинээр нэмж, 25 заалтыг холбогдох хуульд нийцүүлэн давхцал, хийдлийг арилгаж хассан. Мөн Нийгмийн бодлогын байнгын хорооноос зохион байгуулсан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийн төслийг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдаанд шинэчилсэн дүрмийн төслийг танилцуулж, хэлэлцүүлэв.

УИХ-ын НББХ-ны 11 дүгээр сарын 19-ний өдрийн ээлжит хуралдаанаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийг шинэчлэн батлах тухай тогтоолын төслийг хэлэлцүүлж, НББХ-ны гишүүдийн саналыг тусгаж, НББХ-ны 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаар дахин хэлэлцүүлж, 2025 оны 01 дүгээр тогтоолоор ЭМДҮЗ-ийн дүрмийг шинэчлэн батлуулсан. Дүрэм батлагдсанаар Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй, хариуцлагатай болж, хууль, тогтоомжийн биелэлтэд хяналт тавих эрх, үүрэг илүү өргөжин, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах үйл явц илүү сайжирч, ажлын албаны албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэлийг УИХ-аас томилогддог ажлын албаны ангилал, зэрэглэлтэй дүйцүүлэн тогтоосон.

*4.2.3. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, хууль эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр УИХ-д санал, хүсэлтээ уламжлан ажиллалаа.*

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 113 дугаар захирамжаар байгуулагдсан "ЭМД-ын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанд ЭМДҮЗ-ийн үйл ажиллагаа, ЭМД-ын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал, боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагын талаар Үндэсний зөвлөлийн гишүүн Б.Алтанхуяг танилцуулга хийв. Тус хуралдаанд Үндэсний зөвлөлийн гишүүд, ЭМЯ, ЭМДЕГ-ын удирдлагууд, төв, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын 100 гаруй удирдах ажилтнуудын төлөөлөл оролцож, эрүүл мэндийн даатгалын асуудлаар харилцан санал солилцсон.

*4.2.4. Эрүүл мэндийн даатгалын өнөөгийн байдал, бодлогын шийдвэр гаргалтад салбар хоорондын хамтын ажиллагааны уялдааг нэмэгдүүлэх зорилгоор Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын олон улсын зөвлөхүүдтэй туршлага солилцлоо.*

ЭМДҮЗ-ийн гишүүдийн санаачилгаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Женев хот дахь төв оффист эрүүл мэндийн системийн ахлах зөвлөх Д.Баярсайхан, ДЭМБ-ын Зүүн Өмнөд Азийн бүсийн төвийн эдийн засагч Ц.Цолмонгэрэл нарыг Монгол Улсад ирэх үеэр урьж, 08 дугаар сарын 07-ны өдөр уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Уг уулзалт, хэлэлцүүлэгт эрүүл мэндийн даатгалын харилцаанд оролцогч талууд болох Эрүүл мэндийн яам Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны холбогдох төлөөлөл, ЭМДҮЗ-ийн даатгуулагчийг болон ажил олгогчийг төлөөлсөн 5 гишүүн, Ажлын алба, зарим эрүүл мэндийн байгууллагын төлөөлүүд оролцож, олон улсын зөвлөхүүд "Эрүүл мэндийн даатгалын зарим асуудал" сэдвээр илтгэл танилцуулж, харилцан санал солилцсон.

Олон улсын зөвлөхүүд эрүүл мэндийн даатгалын сангийн менежментийг зөв хийхийн тулд бодлогын шийдвэр гаргалтад салбар хоорондын хамтын ажиллагааны уялдааг нэмэгдүүлэх, шийдвэр гаргалтанд мэргэжлийн салбар зөвлөл, мэргэжлийн холбоодыг түлхүү татан оролцуулах, нотолгоонд суурилан тогтвортой, урт хугацаанд хэрэгжүүлэх бодлогыг боловсруулах, мэргэжлийн түвшинд хэлэлцэж, үр дүнг тогтмол үнэлэх талаар хэлэлцүүлэг өрнүүлж, нэгдсэн ойлголтод хүрсэн.

**4.3.ЭМДҮЗ-ийн тогтоолын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийсэн талаар:**

*4.3.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын хэрэгжилтийн явцад хяналт, үнэлгээ хийсэн талаар:*

*<u>4.3.1.1. Эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн нэхэмжлэлийн талаар:</u>*

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийн хяналтын мэдээлэлд 2024 оны эхний 10 сарын байдлаар судалгааг хийхэд эхний 10 сарын байдлаар төв орон нутгийн 300 эрүүл мэндийн байгууллагаас 10.1 сая тохиолдлын 1.3 их наяд төгрөгийн нэхэмжлэл ирүүлснийг хянасан байна.

А. Эрүүл мэндийн байгууллагын төрлөөр авч үзвэл:

- ✓ төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад 8.5 сая тохиолдлын 992.7 (86.2%) тэрбум төгрөг,
- ✓ хувийн хэвшлийн эмнэлэгт 1.3 сая тохиолдлын 246.8 (12.8%) тэрбум төгрөг,
- ✓ рашаан сувилалд 9.1 мянган тохиолдолд 24.9 (0.9%) тэрбум төгрөгийг олгосон дүнтэй байна.

Б. Тусламж, үйлчилгээний төрлөөр авч үзвэл нийт олгохоор тооцсон 1.3 наяд төгрөгийн:

- ✓ 55.9 хувь буюу 706.2 тэрбум төгрөг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд,
- ✓ 20.9 хувь буюу 264.6 тэрбум төгрөг амбулаторийн тусламж, үйлчилгээнд,
- ✓ 4 хувь буюу 50.8 тэрбум төгрөг өдрийн эмчилгээнд,
- ✓ бусад тусламж, үйлчилгээнд 0.6-3.9 хувь буюу 7.5 тэрбум төгрөгөөс 49.6 тэрбум төгрөг зарцуулагдсан дүнтэй байна.

В. Тохиолдлын тоог авч үзвэл нийт 9.8 мянган тохиолдлын:

- ✓ 67.0 хувь буюу 6.6 сая тохиолдол нь амбулаторийн тусламж, үйлчилгээ

- ✓ 8.1 хувь буюу 797.0 мянган тохиолдол яаралтай тусламж, үйлчилгээ,
- ✓ 6.5 хувь буюу 640.5 мянган тохиолдлыг хэвтэн эмчлүүлэх тусламж,үйлчилгээний тохиолдлын тоо эзэлж байна.

*4.3.1.2. Нэхэмжлэлийн хяналтын хасагдлын талаар:*

А. Цахим хасагдлаар 18.6 тэрбум төгрөгийн хасалт хийж, 629.2 мянган тохиолдлын (6.2 хувь) 465.4 тэрбум (38.4 хувь) төгрөгийг тусламж, үйлчилгээг түүвэрлэн шалгаснаас нарийвчилсан хяналтаар 100.9 мянган тохиолдлын 40.9 тэрбум төгрөгийг хассанд эх олонлогоор 42.9 мянган тохиолдолд 13.1 тэрбум төгрөгийн хасагдал тооцсон дүнтэй байна.

Б. Хасагдлыг эрүүл мэндийн байгууллагын төрлөөр авч үзвэл нарийвчилсан хяналт болон эх олонлогоор хасагдсан нийт 54.1 тэрбум төгрөгийн

- ✓ 86.9 хувь буюу 47.0 тэрбум төгрөг улсын эмнэлгүүдийн нэхэмжлэлээс:
- ✓ 12.8 хувь буюу 6.9 тэрбум төгрөг хувийн эмнэлгүүдийн нэхэмжлэлээс,
- ✓ 0.3 хувь буюу 0.1 тэрбум төгрөг рашаан сувиллын нэхэмжлэлээс тус тус хасагдсан байна.

В. Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналт болон эх олонлогийн хасалтаар хасагдсаныг тусламж, үйлчилгээний төрлөөр авч үзвэл:

- ✓ нийт хасалтын 70.4 хувь буюу 38.0 тэрбум төгрөг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнээс,
- ✓ 19.0 хувь буюу 10.3 тэрбум төгрөг яаралтай тусламжаас хасагдсан дүнтэй байна.

*4.3.2.Хөнгөлөлттэй эмийн жагсаалтыг баталсан тогтоолын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийсэн талаар:*

ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоол /хамрах хүрээ 2022.01.01-2024.08.31-ний байдлаар/-ын хүрээнд хөнгөлттэй эмийн жор бичилт болон эмийн үнийн хөнгөлөлтийн зардлын гүйцэтгэлийн тоо, мэдээллийг, даатгуулагчийн регистрийг patient_id буюу давтагдахгүй дугаараар орлуулан, эм бичсэн эрүүл мэндийн байгууллага болон эм олгосон эмийн сангийн нэр, байршил, эмийн сангийн нэхэмжлэлийн тоо, мөнгөн дүн, даатгалын байгууллагын олгосон тоо, мөнгөн дүнг нэгтгэн судалгаа хийж, дараах дүгнэлтийг гаргав.

- ✓ ЭМДС-аас эмийн үнийн хөнгөлөлтийн зардалд 2022 онд 3.9 сая тохиолдолд 79.4 тэрбум төгрөгийг олгохоор тооцсон бол 2023 онд 4.2 сая тохиолдолд 89.9 тэрбум төгрөгийг олгохоор тооцсон байна. Өмнөх онтой харьцуулахад 2023 онд тохиолдлын тоо 409.5 мянга, санхүүжилт 10.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.
- ✓ 2024 оны 1-8 сард 3.6 сая тохиолдолд 93.3 тэрбум төгрөгийг олгохоор тооцсон нь 2023 оны 1-12 сараас 3.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, 2023 оны 1-8 сартай харьцуулахад 35.7 тэрбум төгрөг (62%)-өөр нэмэгдсэн дүнтэй байна.

- ✓ Эмийн үнийн хөнгөлөлтөд хамрагдсан даатгуулагчийн тоо давхардалгүйгээр 2022 онд 568.8 мянга, 2023 онд 645.6 мянган даатгуулагч байна. Монгол Улсын хүн амын тоо 2022 онд 3,368,632 бөгөөд эмийн үнийн хөнгөлөлтөд хамрагдсан даатгуулагч нийт хүн амын 2022 онд 17.9 хувийг 2023 онд 20.5 хувийг эзэлж ЭҮХ-т хамрагдсан даатгуулагчийн тоо 2023 онд урьд оноос 76.8 мянган хүнээр буюу 2.6 хувиар нэмэгдсэн байна.
- ✓ Эмийн үнийн хөнгөлөлтөд хамрагдсан даатгуулагчийн мэдээллийг аймаг тус бүрээр салгаж, тус аймгийн хүн амын хэдэн хувь эмийн үнийн хөнгөлөлтөд хамрагдаж байгааг гаргавал хамгийн өндөр нь 2022 онд Орхон аймаг 21.7 хувь, Ховд аймаг 21.6 хувь байгаа бол хамгийн бага нь Хөвсгөл аймаг 12.1 хувь, Сэлэнгэ аймаг 14.5 хувь байна. 2023 онд Орхон аймаг 24.6 хувь хамгийн өндөр бол Улаанбаатар хот, Булган аймгууд 23.2 хувь болж нэмэгдсэн байна. Хамгийн бага нь Баян-Өлгий аймаг хүн амын 7.8 хувь хамрагдсан нь ЭМДЕГ-аас 2023 онд тус аймагт хийсэн хяналт шалгалтаар зарим эмийн сангийн гэрээг цуцалсантай холбоотой байна.
- ✓ Эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг нийслэлд дунджаар нэг даатгуулагч жилдээ 2022 онд 6.4 удаа, 2023 онд 6.2 удаа авсан бол 2023 онд нийслэлд 6.6 удаа, орон нутагт 5.7 удаа авсан байна.
- ✓ Нэг жоронд ногдох дундаж зардал 2022 онд 20.4 мянган төгрөг, 2023 онд 20.9 мянган төгрөг бол 2024 онд 25.5 мянган төгрөг болж өссөн дүнтэй байна.

**4.4. УИХ-ын Тамгын газраас ЭМДҮЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээний дүгнэлт, зөвлөмж, түүний хэрэгжилтийн талаар:**

Улсын Их Хурлын Тамгын газраас "Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээ"-г 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр ЭМДҮЗ-д ирүүлсэн.

Тус шинжилгээнд ЭМДҮЗ нь 2023 онд өөрийн бүрэн эрхийн хүрээнд холбогдох шийдвэр гаргахаас гадна эрүүл мэндийн даатгалын сангийн голлох тоон үзүүлэлтэд сүүлийн 3-5 жилээр харьцуулсан шинжилгээ хийж, тогтоолын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийж, үр дүнг тооцож, алдаа зөрчлийг арилгуулахтай холбоотой тодорхой санал гаргаж, НББХ-ны хуралдаанаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар анх удаа тайлагнаж, Үндэсний зөвлөлийн батлан хэрэгжүүлсэн шийдвэрүүдийн ололттой талыг гаргаж тавьснаар "байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж, өөрийн тавьсан зорилгод ямар хэмжээнд хүрснийг тодорхойлоход чиглэнэ" гэсэн үнэлгээний зорилгодоо хүрч, тайлан ач холбогдолтой болсон гэж дүгнэж ирүүлжээ.

Мөн анхаарах шаардлагатай 10 асуудалд холбогдох зөвлөмжийг ирүүлсэн бөгөөд зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх хамтарсан ажлын төлөвлөгөөг боловсруулан, ЭМДҮЗ-ийн ажлын албаны дарга, ЭМДЕГ-ын даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажилласнаас дараах 6 зөвлөмжийн хэрэгжилт бүрэн биелэгдэж, зөвлөмжийн хэрэгжилт дунджаар 83.6 хувьтай байна.

- ✓ *Зөвлөмж 1 биелэлт:* 2024 онд эрүүл мэндийн даатгалд 3,275.0 мянган даатгуулагч хамрагдаж, хамрагдалт 93.4 хувьтай байгаа нь өмнөх оноос хамралтын хувь 0.9 хувиар өссөн.

- ✓ *Зөвлөмж 2 биелэлт:* ЭМДС-ийн 2024 оны төсвийн тухай хуулиар эрсдэлийн санг 53,6 тэрбум төгрөгөөр баталсан нь ЭМДС-ийн нийт орлогын 2.8 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 0.3 хувиар, мөнгөн дүнгээр 13,6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.
- ✓ *Зөвлөмж 4, 6 биелэлт:* УИХ-ын НББХ-ны 2025 оны 01 дүгээр тогтоолоор баталсан ЭМДҮЗ-ийн шинэчилсэн дүрэмд "ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал нь төрийн захиргааны албан тушаалд хамаарах бөгөөд цалингийн сүлжээ, албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэвийг Улсын Их Хурлаас томилогддог байгууллагын ажлын албатай дүйцүүлэн тогтооно." гэж тусгаснаар ажлын албаны албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэвийг Улсын Их Хурлаас томилогддог байгууллагын ажлын албатай дүйцүүлэн тогтоох эрх зүйн нөхцөл бүрдсэн.
- ✓ *Зөвлөмж 5, 10 биелэлт:* Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор өгсөн үүрэг, чиглэлийн хэрэгжилт болон тайланд хуулиар олгосон бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний зэрэг болон сөрөг нөлөөлөл, үр дүнг дэлгэрэнгүй байдлаар тайлагнасан. */Хууль тогтоомжийн биелэлт /22 хуудас/-ийг заалт бүрээр дэлгэрэнгүй гаргаж, 2023 оны үйл ажиллагааны тайлангийн хамт НББХ-нд хүргүүлсэн болно./*

Зөвлөмжид тусгагдсан эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хэмжээг нэмэгдүүлэх, сангийн чөлөөт үлдэгдэлд хүү тооцох асуудлыг шийдвэрлэх, Капитал, Чингис хаан банкнаас хүлээн авсан өр, авлагын хэмжээг бууруулах, аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, эрсдэлд суурилсан дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааг тогтмолжуулах зөвлөмжийн биелэлтийг эрчимжүүлж, холбогдох төлөвлөгөөг гаргуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

### 4.5. Хууль тогтоомжийн биелэлтийн талаар:

Тайлант оны жилийн эцсийн байдлаар нийт 29 хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн 129 заалтыг хяналтад авснаас, биелэлтийн хувь 98.6 хувьтай байна.

*Хүснэгт 13 Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт*

| № | Хяналтад авсан | Хууль, тогтоомжийн тоо | Заалтын тоо | Хэрэгжилт /хувиар/ |
|---|---|---|---|---|
| 1 | Монгол Улсын хууль | 1 | 39 | 98.7 |
| 2 | Монгол Улсын Их Хурлын тогтоол | 4 | 8 | 100.0 |
| 3 | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол | 24 | 73 | 98.0 |
| | **Нийт** | **29** | **120** | **98.9** |

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.3-т заасан аргачлалын дагуу үнэлэхэд Монгол Улсын хуулиар үүрэг чиглэл болгосон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 39 заалтын хэрэгжилт 98.7 хувь, Улсын Их Хурлын 4 тогтоолын 8 заалтын хэрэгжилт 100.0 хувь, ЭМДҮЗ-ийн хүчин

төгөлдөр мөрдөгдөж байгаа 24 тогтоолын 73 заалтын хэрэгжилт 98.0 хувь буюу нийт 29 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 120 заалтын хэрэгжилт 98.9 хувьтай байна.

Ажлын алба Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, баримт бичгийн улсын стандартын дагуу 136 албан бичиг, 11 өргөдөл хүлээн авч, бүртгэл хяналтын карт хөтөлж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, холбогдох байгууллага, иргэдэд 151 албан бичиг явуулсан байна.

2024 онд ЭМДҮЗ-ийн батлагдсан төсөв 744.9 сая төгрөгийг Төсвийн тухай хуулийн дагуу зарцуулан ажиллаж, санхүүгийн өр төлбөр, авлагагүй ажилласан байна.

**4.6. Үндэсний аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудит болон санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар:**

Үндэсний аудитын газраас эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж, аудитаар сангийн төсвийн гүйцэтгэлтэй холбоотойгоор нийт 250,439.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 250,252.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 186.1 сая төгрөгийн зөвлөмжийг ЭМДЕГ-т хүргүүлсэн байна.

*4.6.1. Албан шаардлага 953/АО121241 СНЭГ-2024/34/НА- СТА-ТЕЗ биелэлт:*

ШШГЕГ-аас 2024 онд Чингис хаан банканд байрших, эрсдэл үүссэн 30,895.7 сая төгрөгөөс 320.0 сая төгрөгийг ЭМДС-ийн Төрийн сан банкны дансанд төвлөрүүлж, 30,575.7 сая төгрөгийн авлагатай байна.

*4.6.2. Албан шаардлага 954/АО121241 СНЭГ-2024/34/НА- СТА-ТЕЗ биелэлт:*

Хаппи веритас ХХК-ийн Интерферон альфа эмнэлэгээс 876.8 сая төгрөгийн авлага нь Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх хурлаар нэхэмжлэгч талын нэхэмжлэлийг ханган шийдвэрлэсэн бөгөөд хариуцагч ЭМДЕГ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч Нийслэлийн захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж, Давж заалдах шатны шүүхийн магадлал албажиж гараагүй хүлээгдэж байна. Харин Аюурвэйд ХХК-ий 5.9 сая төгрөгийн авлагыг ЭМДС-ийн Төрийн сан банкны дансанд бүрэн төвлөрүүлсэн.

*4.6.3.Албан шаардлага 955/АО121241 СНЭГ-2024/34/НА- СТА-ТЕЗ биелэлт:*

Капитал банкны эрх хүлээн авагчаас шилжүүлэн авсан "Энхтайван найрамдлын ордон"-г 2021 онд "М" ХХК-тай түрээслэх гэрээ байгуулан ажиллаж байсан бөгөөд 2022 оны 12-р сард "М" ХХК-ны эзэн “Б” нь нас барсан тул Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2024 оны 7-р сарын 6-ны 182/ШЗ2О23/О8888 тоот захирамжаар Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгосон тул Шүүхийн захирамжийн дагуу авлагаас хасаж бүртгэсэн болно.

*4.6.4. Албан шаардлага 956/АО121241 СНЭГ-2024/34/НА-СТА-ТЕЗ биелэлт:*

Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад төлөх 2023 оны 218.3 тэрбум төгрөгийн өглөгийг эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвөөс бүрэн олгосон бөгөөд улирлын томуу, томуу төст өвчний дэгдэлттэй

холбоотой эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалан 2024 онд 316.8 тэрбум төгрөгийн өглөгтэй гарсан.

*Хүснэгт 14 Эрүүл мэндийн байгууллагуудад ЭМДС-аас олгох өглөг, сая төгрөг, 2021-2024 он*

| № | ЭМБ-ын төрөл | 2021 оны өглөг | 2022 оны өглөг | 2023 оны өглөг | 2024 оны өглөг | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Төрийн өмчийн эмнэлэг | 163,790.93 | 60,506.16 | 181,304.49 | 184,660.46 | 58.3 |
| 2 | Хувийн эмнэлэг | 22,183.33 | - | 19,176.20 | 46,698.85 | 14.7 |
| 3 | Рашаан сувилал | 3,324.68 | - | 474.26 | 6,204.98 | 2.0 |
| 4 | Эмийн сан | 7,782.13 | 0.27 | 5,708.62 | 19,329.03 | 6.1 |
| 5 | Өрхийн эмнэлэг | 52,424.96 | 0.36 | 5,946.17 | 11,025.04 | 3.5 |
| 6 | Сумын ЭМТ | 0.66 | 49.11 | 5,390.99 | 48,822.74 | 15.4 |
| 7 | Бусад | 15,158.29 | 9.17 | 320.93 | 97.47 | 0 |
| | **НИЙТ ДҮН** | **264,664.99** | **60,565.07** | **218,321.67** | **316,838.57** | **100** |

*4.6.5. Аудитын зөвлөмжийн биелэлтийн талаар:*

Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх хүрээнд авлага барагдуулах ажлын хэсэг байгуулан ажиллаж, Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 136.1 тэрбум төгрөгийн авлагаас тус банкны эрх хүлээн авагч 13.4 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгөөр төлсөн. 46.7 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгө хүлээн авснаас 11.1 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн орлогыг ЭМДС-ийн дансанд төвлөрүүлж, 2024 оны жилийн эцсийн байдлаар Капитал банкны авлага 76.0 тэрбум төгрөг байна. Капитал банкнаас хүлээн авсан үл хөдлөх хөрөнгөөс Улаанбаатар хотод 20, орон нутагт 12 аж ахуйн нэгж, нийт 32 аж ахуйн нэгж, хувь хүнтэй түрээсийн гэрээ байгуулан ажиллаж, 2024 онд 896,4 сая төгрөгийн түрээсийн орлогыг ЭМДС-д төвлөрүүлсэн. Харин Чингис хаан банканд 30.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

## ТАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ 2024 ОНЫ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

### 5.1.Эрүүл мэндийн даатгалын гэрээтэй байгууллагууд, гэрээний хэрэгжилт:

ЭМДҮЗ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-д нэгдсэн сонгон шалгаруулалтыг гурван жилд зохион байгуулахаар тусгасан.

ЭМДҮЗ-ийн 2021 оны 13, 2023 оны 07 дугаар тогтоолын дагуу лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудтай даатгалын гэрээг 3 жилийн хугацаатай байгуулан гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2024 онд нийт 320 лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, 552 анхан шатны эрүүл мэндийн байгууллага, 1513 эмийн сан, нийт 2385 эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулан ажилласан.

*Хүснэгт 15 Даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын тоо, 2022-2024 он*

| № | ЭМБ-ын төрөл, тусламж, үйлчилгээний ангилал | 2022 он | 2023 он | 2024 он | Үүнээс: Цуцалсан | Үүнээс: Шинээр гэрээ байгуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| ***Лавлагаа шатлалын ЭМБ*** | | **322** | **320** | **320** | **5** | **5** |
| 1 | Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага | 78 | 78 | 78 | - | -- |
| 2 | Хувийн эмнэлэг | 192 | 192 | 197 | 5 | |
| 3 | Рашаан сувилал | 52 | 50 | 45 | | 5 |
| ***Анхан шатлалын ЭМБ*** | | **532** | **546** | **552** | | **6** |
| 4 | Өрхийн эрүүл мэндийн төв | 207 | 218 | 224 | | 6 |
| 5 | Сумын эрүүл мэндийн төв | 309 | 311 | 311 | - | - |
| 6 | Тосгоны эрүүл мэндийн төв | 16 | 17 | 17 | - | - |
| **Эмийн сан** | | 1588 | 1484 | 1513 | - | 29 |
| | **Нийт** | **2448** | **2349** | **2385** | | |

Тайлант онд орон нутгийн 19, нийслэлийн 64 эмнэлэг гэрээнд нэмэлт оруулах хүсэлт ирүүлсний дагуу ЭМДЕГ-аас газар дээрх хяналтыг хийж, хяналтын үр дүнг үндэслэн Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээнд нэмэлт оруулах эсэхийг шийдвэрлэн ажиллаласан байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 2024 оны А/174 дугаар тушаалын дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний биелэлтийг 2,385 эрүүл мэндийн байгууллагад дүгнэснээс 90 ба түүнээс дээш үнэлгээтэй 61.4 хувь, 70 ба түүнээс дээш үнэлгээтэй 8.1 хувь, 69.9 ба түүнээс доош хангалтгүй үнэлгээтэй 6.4 хувь байна. Гэрээний дүгнэлтээр 92 эрүүл мэндийн байгууллагын гэрээг түдгэлзүүлэв.

*Хүснэгт 16 Даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын гэрээний хэрэгжилтийн үнэлгээ 2024 он*

| № | ЭМБ-ын төрөл, тусламж, үйлчилгээний ангилал | 2024 он | Гэрээний биелэлтийн үр дүн: 90 ба түүнээс дээш үнэлгээтэй (Маш сайн) | 70 ба түүнээс дээш үнэлгээтэй (Хангалттай) | 69.9 ба түүнээс доош үнэлгээтэй (Хангалтгүй) | Гэрээг түдгэл-зүүлсэн |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага | 78 | 66 /22%/ | 233 /77.6%/ | | 1 /0.3%/ |
| 2 | Хувийн эмнэлэг | 197 | | | | |
| 3 | Рашаан сувилал | 45 | | | | |
| 4 | Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв | 552 | 184 /33%/ | 268 /49%/ | 100 /18%/ | |
| 5 | Эмийн сан | 1513 | 1215 /84.4%/ | 170 /11.8%/ | 53 /3.7%/ | 91 /6%/ |
| | **Нийт** | **2385** | **1465 /61.4%/** | **671 /28.1%/** | **153 /6.4%/** | **92 /3.8%/** |

## 5.2. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлгийн тусламж, үйлчилгээний 12 багцад 2024 онд 11.1 сая тохиолдолд 1.4 их наяд төгрөгийн санхүүжилт олгосон нь 2023 онтой харьцуулахад тохиолдлын тоо 0.9 хувь, санхүүжилт 13.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт 11.1 сая тохиолдлын 83.9 хувь буюу 5.8 сая нь төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас, 15.6 хувь буюу 1.0 сая нь хувийн хэвшлийн эмнэлгээс, 0.5 хувь буюу 33.3 мянга тохиолдлыг сувиллаас үзүүлсэн байна.

Нийт санхүүжилт болох 1.421,8 тэрбум төгрөгийн 1.127,5 тэрбум (79.3%) төгрөгийг төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад, 266.7 тэрбум (18.8%) төгрөгийг хувийн хэвшлийн эмнэлэгт, 27.1 тэрбум (1.9%) төгрөгийг сувиллаас үзүүлсэн тусламж, үйлчилгээнд олгосон байна.

*Хүснэгт 17 Тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, тусламж, үйлчилгээний багц, нэр төрлөөр, 2023-2024 он*

| № | Тусламж, үйлчилгээний нэр төрөл | 2023 он | | 2024 он | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тохиолд-лын тоо | Санхүү-жилт | Тохиолд-лын тоо | Санхүү-жилт | Тохиолдлын тооны өөрчлөлт | | Санхүүжилтийн өөрчлөлт | |
| | | | | | | Тоо-гоор | Хувиар | Мөнгөн дүнгээр | Хувиар |
| 1 | **Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ** | **715,084** | **686,016.6** | **722,238** | **796,955.6** | **7,154** | **1.0%** | **110,939** | **16.2%** |
| | 1.1.Мэс засал | 154,577 | 281,336.5 | 171,550 | 331,563.6 | 16,973 | 11.0% | 50,227 | 17.9% |
| | 1.2.Эмийн эмчилгээ | 531,951 | 317,731.3 | 519,283 | 366,326.9 | -12,668 | -2.4% | 48,596 | 15.3% |
| | 1.3.Эрчимт эмчилгээ | 16,114 | 46,200.7 | 17,509 | 62,654.4 | 1,395 | 8.7% | 16,454 | 35.6% |
| | 1.4.Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх хими, туяа эмчилгээ | 12,294 | 27,739.9 | 13,736 | 22,231.6 | 1,442 | 11.7% | -5,508 | -19.9% |
| | 1.5. Эрхтэн шилжүүлэх мэс засал | 148 | 13,008.2 | 160 | 14,178.9 | 12 | 8.1% | 1,171 | 9.0% |
| 2 | **Амбулаторийн тусламж, үйлчилгээ** | **7,327,934** | **226,923.5** | **7,417,854** | **300,086.9** | **89,920** | **1.2%** | **73,163** | **32.2%** |
| | 2.1. Амбулаторийн үзлэг | 3,933,818 | 66,913.2 | 3,633,276 | 83,459.7 | -300,542 | -7.6% | 16,547 | 24.7% |
| | 2.2. Амбулаторийн үзлэг оношилгоо шинжилгээний багц | 2,010,379 | 110,066.3 | 2,151,156 | 142,854.2 | 140,777 | 7.0% | 32,788 | 29.8% |
| | 2.3. Амбулаторийн хяналтын үзлэг | 808,766 | 16,594.9 | 1,046,411 | 38,930.9 | 237,645 | 29.4% | 22,336 | 134.6% |
| | 2.4. Амбулаториор хийгдэх мэс ажилбар | 72,237 | 2,118.2 | 66,167 | 2,598.3 | -6,070 | -8.4% | 480 | 22.7% |
| | 2.5. Шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээ | 343,167 | 17,845.8 | 368,887 | 23,693.2 | 25,720 | 7.5% | 5,847 | 32.8% |
| | 2.6. Жирэмсний хяналт | 159,567 | 13,385.1 | 151,957 | 8,550.5 | -7,610 | -4.8% | -4,835 | -36.1% |
| 3 | **Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ** | **609,214** | **52,046.1** | **323,533** | **28,126.8** | **-285,681** | **-46.9%** | **-23,919** | **-46.0%** |
| 4 | **Өдрийн эмчилгээ** | **124,373** | **51,001.3** | **156,290** | **56,979.0** | **31,917** | **25.7%** | **5,978** | **11.7%** |
| | 4.1.Өдрийн мэс засал | 12,320 | 3,100.8 | 12,970 | 4,492.6 | 650 | 5.3% | 1,392 | 44.9% |
| | 4.2.Өдрийн эмийн эмчилгээ | 81,168 | 19,334.0 | 112,895 | 30,032.1 | 31,727 | 39.1% | 10,698 | 55.3% |
| | 4.3.Хорт хавдрын туяаны өдрийн эмчилгээ | 21,312 | 7,565.2 | 20,652 | 9,369.3 | -660 | -3.1% | 1,804 | 23.8% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 4.4. Хорт хавдрын химийн өдрийн эмчилгээ | 9,573 | 21,001.4 | 9,773 | 13,084.9 | 200 | 2.1% | -7,917 | -37.7% |
| 5 | **Диализын тусламж, үйлчилгээ** | **221,276** | **31,446.7** | **251,032** | **38,703.0** | **29,756** | **13.4%** | **7,256** | **23.1%** |
| 6 | **Сэргээн засах тусламж, үйлчилгээ** | **298,309** | **52,467.6** | **300,701** | **36,519.3** | **2,392** | **0.8%** | **-15,948** | **-30.4%** |
| | 6.1.Амбулаторийн үзлэг | 186,584 | 3,729.7 | 237,392 | 5,036.5 | 50,808 | 27.2% | 1,307 | 35.0% |
| | 6.2.Өдрийн эмчилгээ | 14,820 | 2,221.1 | 20,561 | 5,865.3 | 5,741 | 38.7% | 3,644 | 164.1% |
| | 6.3.Хэвтүүлэн эмчлэх | 96,905 | 46,516.8 | 42,748 | 25,617.5 | -54,157 | -55.9% | -20,899 | -44.9% |
| 7 | **Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ** | **317,069** | **56,132.8** | **321,516** | **45,688.1** | **4,447** | **1.4%** | **-10,445** | **-18.6%** |
| | 7.1.Амбулаторийн үзлэг | 198,641 | 3,967.5 | 227,848 | 4,884 | 29,207 | 14.7% | 917 | 23.1% |
| | 7.2. Өдрийн эмчилгээ | 18,574 | 2,682.1 | 24,230 | 4,052 | 5,656 | 30.5% | 1,370 | 51.1% |
| | 7.3.Хэвтүүлэн эмчлэх | 99,854 | 49,483.3 | 69,438 | 36,752.8 | -30,416 | -30.5% | -12,735 | -25.7% |
| 8 | **Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ** | **7,963** | **6,994.7** | **8,849** | **8,564.1** | **886** | 11.1% | **1,569** | 22.4% |
| 9 | **Яаралтай тусламж** | **805,826** | **66,331.2** | **920,547** | **56,358.7** | **114,721** | 14.2% | **-9,972** | -15.0% |
| 10 | **Түргэн тусламж** | **522,639** | **27,966.2** | **552,601** | **32,576.8** | **29,962** | 5.7% | **4,611** | 16.5% |
| 11 | **Телемедицины тусламж, үйлчилгээ** | **719** | **38.8** | **712** | **38.4** | **-7** | -1.0% | **-0.4** | -1.0% |
| 12 | **Сувиллын тусламж, үйлчилгээ** | **-** | **-** | **75390** | **21254.2** | **75390** | - | **21254.2** | - |
| | **Нийт дүн** | **10,950,406** | **1,257,365.5** | **11,051,263** | **1,421,850.8** | **100,857** | **0.9%** | **164,485** | **13.1%** |

Тусламж, үйлчилгээний тохиолдлын тоонд эзлэх хувийг харахад хамгийн өндөр нь амбулаторийн ТҮ 67.1 хувийг эзэлж байгаа нь 2024 онд ЭМДҮЗ-ийн 06 дугаар тогтоолоор "Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ"-ний 8 багцыг шинээр үүсгэж, амбулаторийн тусламж, үйлчилгээний тарифыг 20 хувиар нэмэгдүүлсэн бодлогын өөрчлөлттэй холбоотой.

*График 11 Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо, санхүүжилтэд эзлэх хувь, ТҮ- ний нэр төрлөөр*




*5.2.1.Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ:* Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд 2024 онд 722.2 мянган тохиолдолд 796.9 тэрбум төгрөгийн

санхүүжилтийг олгосон нь өмнөх оноос тоо хэмжээ 1.0 хувиар, санхүүжилт 16.2 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд нийт санхүүжилтийн 56.0 хувийг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд зарцуулсан байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний 5 төрлөөс өндөр өсөлт гарсан нь эрчимт эмчилгээний санхүүжилт 35.6 хувиар нэмэгдсэн нь эрчимт эмчилгээний тарифын өсөлттэй, хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх хими, туяа эмчилгээний тохиолдлын тоо 11.7 хувиар өссөн ч санхүүжилтийн хэмжээ 19.9 хувиар буурсан нь хими эмчилгээний үйлдлийн зардал болон эмийн зардлыг тус тусад нь санхүүжүүлэхээр бодлогын тохируулга хийж, тарифыг бууруулан санхүүжүүлсэнтэй тус тус холбоотой байна.

*5.2.2. Амбулаторийн тусламж, үйлчилгээ:* 2024 онд 7.4 сая тохиолдолд 300.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх оноос тохиолдлын тоо 1.2 хувиар, санхүүжилт 32.2 хувиар тус тус өссөн байна. ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоолоор амбулаторийн үзлэг, хяналтын багцад өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээг нэгтгэн “Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ”-ний 8 багцыг шинээр үүсгэж, амбулаторийн тусламж, үйлчилгээний тарифыг 20 хувиар нэмэгдүүлсэн нь санхүүжилтийн өсөлтөд нөлөөлж байна.

*5.2.2.1. Шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээ:* 2024 онд 368.9 мянган тохиолдолд 23.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх оноос тохиолдлын тоо 7.5 хувиар, санхүүжилт 32.8 хувиар тус тус өссөн байна. Энэ нь 2021 онд Монгол Улсын хүн амын дунд хийгдсэн судалгаанаас харахад шүдний цоорлын тархалт 3-6 настай хүүхдүүдийн дунд 88%, жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд 96% байгаа тул хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдийн шүд, амны хөндийн тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, шүдний цоорол өвчнөөс шалтгаалсан өвчлөлийн бууруулах зорилгоор ЭМДҮЗ-ийн 2024 оны 14 дүгээр тогтоолоор даатгалын сангаас санхүүжүүлэх шүдний тохиолдлын тоог нэмэгдүүлж, тарифыг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй холбоотой.

*5.2.2.2. Жирэмсний хяналтын тусламж, үйлчилгээ:* 2024 онд жирэмсний хяналтын тусламж, үйлчилгээнд 152.0 мянган тохиолдолд 8.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх оноос тохиолдлын тоо 4.8 хувиар, санхүүжилт 36.1 хувиар буурсан. ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоолоор хэвийн жирэмсний хяналтыг анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд үзүүлэхээр, эрсдэлтэй жирэмсний хяналтыг харьяа лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад үзүүлсэн тохиолдлын тоогоор санхүүжүүлэх өөрчлөлтийг хийсэнтэй холбоотой байна.

*5.2.3. Өдрийн эмчилгээ:* 2024 онд давхардсан тоогоор 156.3 мянган тохиолдолд 57.0 тэрбум төгрөгийг олгосон нь өмнөх оноос тохиолдлын тоо 25.7 хувь, санхүүжилтийн хэмжээ 11.7 хувиар өссөн байна.

*5.2.3.1. Өдрийн эмийн эмчилгээ:* Өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээнээс 2024 онд хамгийн өсөлттэй өдрийн эмийн эмчилгээг өмнөх онтой харьцуулахад тохиолдлын тоо 39.1 хувиар, санхүүжилт 55.3 хувиар өссөн нь хэвтүүлэн эмчлүүлэх шаардлагагүй 6 оношийн хамааралтай бүлгийг хасаж, тухайн бүлгийг өдрийн эмийн эмчилгээ рүү шилжүүлсэн бодлогын тохируулгаас шалтгаалсан байна.

*5.2.3.2. Хорт хавдрын химийн өдрийн эмчилгээ:* 2024 онд давхардсан тоогоор 9.8 мянган тохиолдолд 13.1 тэрбум төгрөгийг олгосон. Өмнөх тогтоолын хүрээнд хорт хавдрын системийн хими эмчилгээ, химийн бай эмчилгээний тохиолдлыг 1,151.0-4,500.0 мянган төгрөгийн хооронд ялгаатай санхүүжүүлж байсан бөгөөд өртгийн судалгаагаар химийн эмчилгээнд ашиглаж буй 16-20 төрлийн эмийн зардал харилцан адилгүйн улмаас химиэмчилгээний үйлдлийн зардал болон эмийн зардлыг тус тусад нь санхүүжүүлэх хэрэгцээ бий болсон. ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоолоор өдрөөр үзүүлэх хорт хавдрын системийн хими, химийн бай эмчилгээний тарифыг бууруулсантай холбоотой нь өмнөх оноос санхүүжилтийн хэмжээ 37.7 хувиар буурсан байна.

*5.2.4. Өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээ:* 2024 онд өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээнд 323.5 мянган тохиолдолд 28.1 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг олгосон байна.

Гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд шилжиж, MRI, CT гэсэн өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээг ЭМДС-аас санхүүжүүлж эхэлснээр нэг талаас иргэн даатгуулагчид эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдлээс бүрэн хамгаалагдсан сайн талтай боловч нөгөө талаас эрүүл мэндийн байгууллагууд шаардлагагүй оношилгоо, шинжилгээ хийж, даатгалын сангийн санхүүжилт эрс нэмэгдсэн. Тухайлбал: MRI шинжилгээний гүйцэтгэл 2021 онд 14,296 байсан бол 2023 онд 44,816 болж 3,1 дахин, КТ шинжилгээний гүйцэтгэл 2021 онд 35,266 байсан бол 2023 онд 97,753 болж 2,7 дахин, дурангийн оношилгооны гүйцэтгэл 2021 онд 26,079 байсан бол 2023 онд 54,326 болж 2 дахин тус тус нэмэгдсэн сөрөг үр дагавар гарсан.

Шаардлагагүй өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээг хязгаарлах, амбулаторийн тусламж, үйлчилгээг цогц, хүртээмжтэй, чанартай үзүүлэх зорилгоор ЭМДҮЗ-ийн тогтоолоор өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээг амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, хяналтын багцад нэгтгэсэнтэй холбоотой өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээний тохиолдлын тоо өмнөх оноос 46.9 хувиар, санхүүжилтийн хэмжээ 46.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

*5.2.5. Диализийн тусламж, үйлчилгээ:* 2024 онд 251.0 мянган тохиолдолд 38.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх оноос тохиолдлын тоо 13.4 хувиар, санхүүжилт 23.1 хувиар өссөн байна.

*5.2.6. Сэргээн засахын тусламж, үйлчилгээ:* 2024 онд онд сэргээн засах тусламж, үйлчилгээний 300.7 мянган тохиолдолд 36.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх оноос тохиолдлын тоо 0.8 хувиар, өсөж, санхүүжилтийн хэмжээ 30.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

- ✓ *Сэргээн засахын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ:* 2024 онд сэргээн засахын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний 42.7 мянган тохиолдолд 25.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх оноос тохиолдлын тоо 55.9 хувиар, санхүүжилтийн хэмжээ 44.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тогтоолын өөрчлөлтөөр сэргээн засах тусламж үйлчилгээг дахин багцалж, сувилалд эмчлэгдэх боломжтой архаг өвчнийг сувиллын тусламж, үйлчилгээний багц руу шилжүүлж, мөн хурц өвчний дараа үед үзүүлэх сэргээн засах тусламж, үйлчилгээний оношийн

хамааралтай бүлгийн багцыг шинэчилж, эмчилгээний үр дүнг үнэлж, санхүүжилтийг үргэлжлүүлдэг тогтолцоо руу шилжүүлж, тарифыг бууруулснаас шалтгаалан санхүүжилтийн хэмжээ буурсан байна.

- ✓ *Сэргээн засахын өдрийн эмчилгээ:* 2024 онд онд сэргээн засахын өдрийн эмчилгээний 20.6 мянган тохиолдолд 5.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх оноос тохиолдлын тоо 38.7 хувиар, санхүүжилтийн хэмжээ 164.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь тогтоолын өөрчлөлтөөр сэргээн засахын өдрийн эмчилгээний 3 төрлийн шинэ багц /үе мөч, тулгуур эрхтний эмгэг, тархи мэдрэлийн эмгэг, хорт хавдрын дараах сэргээн засах/-ыг үүсгэж, өмнө мөрдөгдөж байсан тарифыг дунджаар 2.2 дахин нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

*5.2.7. Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ:* 2024 онд 321.5 мянган тохиолдолд 45.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх оноос тохиолдлын тоо 1.4 хувиар нэмэгдэж, санхүүжилт нь 18.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тогтоолын өөрчлөлтөөр сувиллаас үзүүлэх уламжлалтын тусламж, үйлчилгээний багцыг шинээр үүсгэсэнтэй холбоотой уламжлалтын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний санхүүжилт 25.7 хувиар буурсан байна.

*5.2.8. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ:* 2024 онд хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд 8.8 мянган даатгуулагч хамрагдаж, 8.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон нь өмнөх онтой харьцуулахад тохиолдлын тоо 11.1 хувиар, санхүүжилт 22.4 хувиар нэмэгдсэн байна. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд 97.0 хувь, хувийн хэвшлийн эмнэлэг 3.0 хувь байна.

*5.2.9. Яаралтай тусламж*: 2024 онд яаралтай тусламж, үйлчилгээнд 920.5 мянган даатгуулагч хамрагдаж, 56.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон нь өмнөх онтой харьцуулахад тохиолдлын тоо 14.2 хувиар өссөн ч мөнгөн дүн 15.0 хувиар буурсан байна.

Яаралтай тусламж, үйлчилгээг гүйцэтгэлээр санхүүжүүлж эхэлснээр нэг талаас иргэн даатгуулагчид эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдлээс бүрэн хамгаалагдсан, тусламж, үйлчилгээг цаг алдалгүй авах сайн талтай болович нөгөө талаас эрүүл мэндийн байгууллагууд бага зардлаар яаралтай тусламж, үйлчилгээг үзүүлсэн ч тоо хэмжээний хэт өсөлтийн улмаас даатгалын сангийн санхүүжилт эрс нэмэгдсэн. Өртгийн судалгаанд үндэслэн яаралтай тусламж, үйлчилгээний зардлаас өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээг салгаж, эрэмбэлэн ангилалтыг оновчтой болгосноор яаралтай тусламжийн санхүүжилт буурсан.

*5.2.10. Сувиллын тусламж, үйлчилгээ:* 2024 онд сувиллын тусламж, үйлчилгээнд 75.4 мянган даатгуулагч хамрагдаж, 21.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон нь тогтоолын өөрчлөлтөөр сувиллын тусламж, үйлчилгээ, сувиллаас үзүүлэх уламжлалтын болон сэргээн засах тусламж, үйлчилгээ гэсэн 3 багцыг шинээр үүсгэсэнтэй холбоотой байна.

### 5.3. Анхан шатлалын /ӨСТЭМТ/ тусламж, үйлчилгээ

ЭМДҮЗ-ийн 2024 оны 05 дугаар тогтоолоор сум, тосгоны эрүүл мэндийн төвийн газарзүйн индексийг нэмэгдүүлэх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд ажиллаж буй эмч, ажилчдын үндсэн цалин, орон нутгийн нэмэгдлийг олгох бодлогыг баримталж, тусламж, үйлчилгээний жагсаалтыг өргөжүүлж, тарифыг нэмэгдүүлсэн.

Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 дүгээр сарын 01-ээс нэмэгдүүлсэн цалингийн өсөлт, орон нутгийн нэмэгдэл, анхан шатны тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлсэнтэй холбоотой 2024 онд анхан шатны эрүүл мэндийн байгууллагад нийтдээ 487.4 тэрбум төгрөг зарцуулсан нь өмнөх онтой харьцуулахад 35.7 хувиар буюу 128.1 тэрбум төгрөгөөр, нэг иргэнээр тооцсон санхүүжилт өмнөх оноос 25.7 хувь буюу 70.6 тэрбум төгрөгөөр, 4 төрлийн тусламж, үйлчилгээ 133.8 хувь буюу 57.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Хүснэгт 18 ӨСТЭМТ-өөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, 2022-2024 он*

| № | Анхан шатны тусламж, үйлчилгээ | 2022 он | 2023 он | 2024 он | Өөрчлөлт /2024-2023/ | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Тоогоор | Хувиар |
| 1 | **Сум, тосгоны ЭМТ-өөс үзүүлэх ТҮ** | **84,561.5** | **50,290.4** | **87,417.3** | **37,126.9** | **73.8%** |
| 1.1 | Хэвтүүлэн эмчлэх | 75,469.9 | 30,073.4 | 48,572.6 | 18,499.2 | 61.5% |
| 1.2 | Түргэн тусламж | 6,771.1 | 11,231.7 | 21,465.1 | 10,233.4 | 91.1% |
| 1.3 | Яаралтай тусламж | 1,320.9 | 5,109.8 | 10,336.2 | 5,226.4 | 102.3% |
| 1.4 | Шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээ | 999.6 | 3,875.5 | 7,043.4 | 3,167.9 | 81.7% |
| 2 | **Өрх, сум тосгоны ЭМТ-с үзүүлэх 4 төрлийн ТҮ** | **14,329.8** | **34,083.7** | **54,526.2** | **20,442.5** | **60.0%** |
| 2.1 | Сэргээн засах | 3,685.1 | 9,489.8 | 14,040.5 | 4,550.7 | 48.0% |
| 2.2 | Өдрийн эмчилгээ | 5,189.3 | 11,343.3 | 17,506.9 | 6,163.6 | 54.3% |
| 2.3 | Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ | 2,134.9 | 3,762.5 | 6,023.1 | 2,260.6 | 60.1% |
| 2.4 | Оношилгоо, шинжилгээ | 3,320.3 | 9,488.0 | 16,955.7 | 7,467.7 | 78.7% |
| 3 | **Нэг иргэнээр тооцсон ТҮ-ний санхүүжилт** | **197,122.7** | **274,924.4** | **345,502.5** | **70,578.1** | **25.7%** |
| | **Нийт анхан шатны тусламж, үйлчилгээний зардал** | **296,014.2** | **359,298.6** | **487,446.0** | **128,147.4** | **35.7%** |

Анхан шатны нэг иргэнээр тооцсон багц тусламж, үйлчилгээний 2024 оны гүйцэтгэлээс харахад тусламж, үйлчилгээний тэргүүлэх чиглэл болох халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг, өвчнөөс урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээний гүйцэтгэл жил бүр сайжирч байгаа хэдий ч эмчлэхэд илүү анхаарч эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх, эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, тусламж, үйлчилгээ хангалтгүй байна.

Нэг иргэнээр тооцсон багц тусламж, үйлчилгээний 2024 оны гүйцэтгэлийг авч үзвэл 20.5%-ийг эмчлэхэд, 31.7%-ийг Халдварт бус өвчний эрт илрүүлэгт, 33.0%-ийг эрүүл мэндийг хянахад, 6.7%-ийг эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөхөд, 4.1%-ийг өвчнөөс урьдчилан сэргийлэхэд, 0.001%-ийг эрүүл мэндийн дэмжихэд, 3.3%-ийг халдварт өвчний эрт илрүүлэгт, 0.7%-ийг сэргээн засах тусламж, үйлчилгээнд, 0.02%-ийг хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд тус тус хийсэн байна.

Өрх, сум, тосгоны ЭМТ-өөс үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээний 1,564.9 мянган тохиолдолд 52.2 тэрбум төгрөгийн, сум, тосгоны ЭМТ-өөс үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээнд 91.4 мянган тохиолодд 2.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

*Хүснэгт 19 Өрх, сум, тосгоноос үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээний 2024 оны тохиолдлын тоо, олгохоор тооцсон санхүүжилт, сая төгрөгөөр*

| № | Тусламж, үйлчилгээний төрөл | ӨЭМТ | | СТЭМТ | |
|---|---|---|---|---|---|
| | | Тохиолдлын тоо | Санхүүжилт | Тохиолдлын тоо | Санхүүжилт |
| 1 | Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ | 62,420 | 5,712.20 | 3,727 | 310.9 |
| 2 | Оношилгоо, шинжилгээ | 1,189,229 | 15,950.00 | 76,774 | 1,005.70 |
| 3 | Өдрийн эмчилгээ | 144,076 | 16,959.50 | 4,578 | 547.4 |
| 4 | Сэргээн засах тусламж, үйлчилгээ | 169,224 | 13,537.30 | 6,290 | 503.2 |
| | **Нийт дүн** | **1,564,949** | **52,159.00** | **91,369** | **2,367.30** |

Сум, тосгоны ЭМТ-өөс үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээний тохиолдлын тоог харьцуулан үзэхэд хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ 27.4 хувийг эзэлж байгаа ч бусад тусламж, үйлчилгээний эзлэх хувь ойролцоо байна. Харин санхүүжилтийг харьцуулахад хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ 55.4 хувь буюу хамгийн өндөр хувийг, шүдний тусламж, үйлчилгээ 8.1 хувийг эзэлж байгаа нь хамгийн бага хувьтай байна.

*Хүснэгт 20 СТЭМТ-өөс үзүүлэх 4 төрлийн тусламж үйлчилгээний 2024 оны тохиолдлын тоо, олгохоор тооцсон санхүүжилт, сая төгрөгөөр*

| № | Тусламж, үйлчилгээний төрөл | Тохиолдлын тоо | Хувиар | Санхүүжилт | Хувиар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ | 122,624 | 27.8% | 48,572.6 | 55.6% |
| 2 | Түргэн тусламж | 106,575 | 24.2% | 21,465.1 | 24.6% |
| 3 | Яаралтай тусламж, үйлчилгээ | 105,499 | 23.9% | 10,336.2 | 11.8% |
| 4 | Шүд амны хөндий | 106,287 | 24.1% | 7,043.4 | 8.1% |
| | **Нийт** | **440,985** | **100.0%** | **87,417.2** | **100%** |

## 5.4. Эмийн үнийн хөнгөлөлт

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 11 дүгээр тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хувь хэмжээ"-г мөрдөж байна.

Хүн амын дунд зонхилон тохиолддог, нас баралтын хувь өндөртэй зүрх судас, чихрийн шижин, уушгины эмгэг болон хавдрын үеийн эм зүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор "Новартис эмийн хүртээмжийг сайжруулах" хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлэхээр Швейцарын Холбооны Улсын "Новартис Глобал" эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу 15 ерөнхий нэршлийн 24 тун, хэмжээ бүхий эмийг эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувь хөнгөлөхөөр тусгасан.

2024 онд 1513 эмийн сангаар дамжуулан эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг 815.7 мянган даатгуулагчид үзүүлж, даатгалын сангаас 134.6 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 139.5 мянган хүнээр нэмэгдэж, санхүүжилт 21.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт 21. Эмийн үнийн хөнгөлөлтийн төсөв, гүйцэтгэл, хамралт 2022-2024 он, сая төгрөгөөр*

| Төсөв, гүйцэтгэл | 2022 он | 2023 он | 2024 он | Өөрчлөлт /2024-2023/ | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Тоогоор | Хувиар |
| Төсөв /сая.төг/ | 67,306.2 | 89,982.5 | 137,801.6 | 47,819.1 | 53.1% |
| Гүйцэтгэл /сая.төг/ | 84,251.7 | 99,506.5 | 134,549.6 | 35,043.1 | 35.2% |
| Хамрагдсан хүний тоо | 572,568 | 645,360 | 815,732 | 139,467 | 21.6% |

2024 онд нийслэлийн эмийн сангуудад нийт санхүүжилтийн 61.0 хувь буюу 81 тэрбум төгрөг, орон нутгийн эмийн сангуудад 39.0 хувь буюу 53.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Даатгуулагчийн төрлөөр нь авч үзэхэд 2024 онд тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд хөнгөлөлттэй эмийн нийт санхүүжилтийн 68.2 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр байна.

*График 12 Эмийн үнийн хөнгөлтийн зардлын төсөв, гүйцэтгэл, хамралт, 2022-2024 он, сая төгрөгөөр*




## 5.5. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1-т "Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ" гэсэн зорилтын хүрээнд даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулж байна.

Судалгаагаар 2023 онд хэрэглээний үнийн индекс 14.8 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний зардал 10.6 хувь өссөн, инфляцын түвшин болон бусад үнийн өсөлттэй уялдуулан ЭМДҮЗ-ийн 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 10 дугаар тогтоолоор "Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, төлбөрийг нь санхүүжүүлэх журам, багц, төлбөрийн хэмжээ"-г шинэчлэн баталж, төлбөрийн хэмжээг дунджаар 40 хувиар нэмэгдүүлэн 2024 оны эхнээс мөрдсөн.

*Хүснэгт 22 Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний төлбөрийн хэмжээ*

| Насны бүлэг | ЭМДҮЗ-ийн 2022 оны 06-р тогтоолын төлбөрийн хэмжээ | ЭМДҮЗ-ийн 2023 оны 10-р тогтоолын төлбөрийн хэмжээ | Өсөлтийн хувь | Өсөлт мөнгөн дүнгээр |
|---|---|---|---|---|
| 18-30 насны багц 1 | 60,000 | 90,000 | 50% | 30,000 |
| 31-45 насны багц 2 | 130,000 | 190,000 | 46% | 60,000 |
| 46-60 насны багц 3 | 150,000 | 200,000 | 33% | 50,000 |
| 61- дээш насны багц 4 | 140,000 | 180,000 | 29% | 40,000 |
| **Дундаж өсөлтийн хувь** | | | **40%** | **45,000** |

2024 онд улсын хэмжээнд 219.2 мянган хүн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагдаж 31.6 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулсан байна.

*Хүснэгт 23 Урьдчилсан сэргийлэх үзлэгийн хамралт, тохиолдол, санхүүжилт, насны багцаар 2023-2024 он*

| Багц | 2023 он | | 2024 он | | | | Өөрчлөлт /2024-2023/ | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тохиол-дол | Санхүү-жилт /сая төг/ | Тохиолдол | | Санхүүжилт | | Тохиол-дол | Санхүү-жилт /сая төг/ |
| | | | Тоо | Хувь | Мөнгөн дүн | Хувь | | |
| 18-30 насны багц | 60,656 | 3,625.9 | 37,468 | 17.1% | 3,104.4 | 9.8% | -23,188 | -521.5 |
| 31-45 насны багц | 130,514 | 16,067.7 | 89,200 | 40.7% | 13,105.0 | 41.4% | -41,314 | -2,962.7 |
| 46-60 насны багц | 113,701 | 16,044.3 | 62,880 | 28.7% | 10,865.3 | 34.4% | -50,821 | -5,179.0 |
| 61+дээш насны багц | 52,516 | 6,905.0 | 29,658 | 13.5% | 4,551.7 | 14.4% | -22,858 | -2,353.3 |
| **Нийт** | **357,387** | **42,642.9** | **219,206** | **100.0%** | **31,626.3** | **100.0%** | **-138,181** | **-11,016.6** |

Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралтын тохиолдлын тоо өмнөх оноос 138,2 мянган тохиолдлоор, санхүүжилт 11.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд 31-45 насны даатгуулагчид хамгийн өндөр хамрагдсан нь нийт тохиолдлын 40.7 хувь, санхүүжилтийн 41.4 хувийг тус тус эзэлж байна. Харин урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд 18-30 насны залуучууд хамгийн бага хамрагдсан нь нийт тохиолдлын 17.1 хувь, санхүүжилтийн 9.8 хувийг тус тус эзэлж байна.

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийг 81 эрүүл мэндийн байгууллага үзүүлснээс өмчийн хэлбэрээр авч үзвэл 47 (58.0%) нь төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага, 34 (42.0%) нь хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байна.

# ЗУРГАА. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХҮНИЙ НӨӨЦ, ХЯНАЛТ, ЦАХИМЖИЛТ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

## 6.1.Байгууллагын хүний нөөц:

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 344 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг байгуулж, ЭМДҮЗ-ийн 2020 оны 17 дугаар тогтоолоор ЭМДЕГ-ын бүтцийг баталсан.

*Хүснэгт 24 ЭМДЕГ-ын хүний нөөцийн өөрчлөлт, 2022-2024 он*

| Шалгуур үзүүлэлт | 2022 он | 2023 он | 2024 он |
|---|---|---|---|
| Орон тоо (нийт ажилтан) | 170 | 191 | 193 |
| Албан тушаалын шинэчилсэн тодорхойлолт (тоо) | - | 28 | - |
| Сул орон тоо нөхсөн (тоо) | 6 | 7 | 1 |
| Гүйцэтгэх | 47 | 25 | 5 |
| Албан тушаал дэвшсэн ажилтан (тоо) | 47 | 42 | 48 |
| Хөдөлмөрийн гэрээ шинэчлэгдсэн ажилтан (тоо) | 13 | 13 | 12 |

Албан хаагчдын чиг үүргийг оновчтой хуваарилах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор ЭМДЕГ-ын даргын 2024 оны А/19 дүгээр тушаалаар “Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын бүтцийн нэгжүүдийн ажил, албан тушаалын жагсаалт”-ыг шинэчлэн баталж, мөрдүүллээ.

Засгийн газрын тогтоолын дагуу төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн хэмжээг үндэслэн ЭМДЕГ-ын даргын 2024 оны А/54 дүгээр тушаалаар 193 албан хаагчийн цалинг шинэчлэн баталлаа.

Шинэчлэн тогтоосон цалинд төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвийн нэмэгдэл 113 албан хаагчид 18-42 хувиар, төрийн алба хаасан хугацаанаас хамаарч 189 албан хаагчид 1-25 хувиар, ур чадварын нэмэгдэл 31 ажилтанд 25 хувиар, мэргэшсэн нягтлан бодогчийн нэмэгдэл 7 албан хаагчид 15 хувиар үндсэн цалингаас тус бүр нэмэгдлийг тооцон олгож байна. Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах, цалин нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай, үр дүнтэй бүтээлчээр ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор төрийн үйлчилгээний ангилалд ажиллаж байгаа 31 албан хаагчид ур чадварын нэмэгдлийг 25 хувиар тооцон олгож байна.

ЭМДЕГ-ын хэмжээнд төрийн захиргааны албан тушаалын 159 албан хаагчийн 113 буюу 71,0 хувь нь төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвтэй буюу 2023 оны мөн үеэс 14 хувиар өссөн байна.

*Хүснэгт 25 ЭМДЕГ-ын хүний нөөцийн цалин, урамшуулал, тусламж*

| Шалгуур үзүүлэлт | 2022 он | 2023 он | 2024 он | 2023 оны өөрчлөлт хувиар | 2024 оны өөрчлөлт хувиар |
|---|---|---|---|---|---|
| Үр дүнгийн урамшуулал авсан ажилтан (тоо) | 183 | 156 | 187 | -14.75% | 19.87% |
| Буцалтгүй тусламж авсан ажилтан (тоо) | 61 | 36 | 32 | -40.98% | -11.11% |
| Буцалтгүй тусламжийн нийт мөнгөн дүн (сая ₮) | 77.4 | 34.2 | 27.1 | -55.82% | -20.82% |

## 6.2. Эрүүл мэндийн даатгалын хяналт

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д "гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрүүл мэнд нь хохирсон даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг холбогдох хууль хяналтын байгууллага хариуцан буруутай этгээдээр эрүүл мэндийн даатгалын байгууллагад нөхөн төлүүлнэ." гэж заасан. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2024 онд 2,407.5 сая төгрөгийн зардлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос 263 дахин өссөн байна.

*Хүснэгт 26 Гэмт хэргийн зөрчлийн улмаас ЭМДС-д төлүүлсэн зардал*

| Он | Гэм буруутай иргэдийн тоо | Нөхөн төлүүлсэн дүн /мян.төг/ |
|---|---|---|
| 2022 | 610 | 281,233.9 |
| 2023 | 1646 | 1,066,668.6 |
| 2024 | 3421 | 2,407,566.5 |
| **Нийт** | **5677** | **3,755,469.0** |

Даатгуулагчийн гомдлын мөрөөр 2024 онд ЭМДЕГ-аас 6 эрүүл мэндийн байгууллагад газар дээрх хяналт шалгалтыг хийж, 16 иргэн-даатгуулагчийн нэмэлт төлбөр төлсөн мэдээллийг баримт нотолгоонд тулгуурлан бодитой эсэхийг нягтлан шалгаж, тусламж, үйлчилгээ авах үедээ гэрээнд заагаагүй нэмэлт төлбөр авсан 6 иргэний төлбөрийн баримтыг үндэслэн 455.0 мянган төгрөгийг буцаан олгуулж, даатгуулагчдыг хохиролгүй болгосон.

*Хүснэгт 27 Иргэн даатгуулагчдад олгосон буцаан олголт (мян.төг)*

| Буцаан олголт | 2022 он | | 2023 он | | 2024 он | |
|---|---|---|---|---|---|---|
| | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн |
| Эрүүл мэндийн байгууллага нь эм тариа гаднаас авахуулсан | - | - | 5 | 11,285.4 | | |
| Гэрээнд тусгагдаагүй нэмэлт төлбөр авсан | 12 | 13,996.4 | 3 | 2,323.3 | 6 | 455.0 |
| Өөр байгууллагад оношилгоо, шинжилгээнд илгээсэн | - | - | 3 | 1,996.2 | - | - |
| Мессеж мэдээллийн дагуу газар дээрх хяналтаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх хугацаанд нь гаднаас авахуулсан эм тарианы мөнгийг буцаан олгуулсан байдал | - | - | 9 | 1,078.9 | - | - |
| **Нийт** | **12** | **13,996.4** | **20** | **16,683.7** | **6** | **455.0** |

## 6.3. Эрүүл мэндийн даатгалын цахимжилт

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын төлбөр, тооцоо, даатгуулагчид болон ажил үйлчилгээ худалдан авах байгууллагуудтай харилцах, даатгалын санд хяналт тавих ажиллагаа цахим хэлбэрт бүрэн шилжсэн. Үндэсний зөвлөл, ЭМДЕГ-аас орчин үеийн мэдээллийн технологийн боломж, нөөцийг ашиглан, гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудыг эрүүл мэндийн даатгалын системтэй цахимаар холбох, цахим баримтын системтэй уялдуулан мэдээллийг хянах тогтолцоог хөгжүүлэхээр зорьсон нь тодорхой үр дүнд хүрсэн.

Эрүүл мэндийн даатгалын цахим системд даатгалын гэрээтэй 2350 байгууллага холбогдсон бөгөөд бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын иргэд, даатгуулагчдад үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, үр дүнд үндэслэн санхүүжүүлэх, хяналт тавих зорилготой эрүүл мэндийн даатгалын цахим тогтолцоог хөгжүүлэн ажилласан.

E-Mongolia академи улсын үйлдвэрийн газартай ХУР системээр дамжуулан мэдээлэл солилцох 16 сервис, Монгол Улсын донорын хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд донорын нэгдсэн сангийн 6 сервис, жирэмсний хяналтын дэвтрийн мэдээллийг E-Mongolia платформ руу дамжуулах 4 сервисийг хөгжүүлсэн.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн үйлчилгээг иргэдэд хялбар болгох зорилгоор Төрийн үйлчилгээний төлбөрийн нэгдсэн системд **E-Mongolia** болон **"ebarimt"** аппликейшн ашиглан хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, оюутан, малчин, гадаадын иргэн харьяалалгүй хүн зэрэг нийт 321,3 мянган хүн эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлж, 29,9 тэрбум төгрөгийг даатгалын санд төвлөрүүлсэн нь нийт бүрдүүлсэн бусад орлогын 87.4 хувийг эзэлж байна. **E-Mongolia** болон **"ebarimt"** аппликейшн ашиглан шимтгэлээ төлсөн даатгуулагчийн тоо өмнөх оноос 46.1 мянган даатгуулагчаар, бусад орлогод эзлэх хувь 14.2 хувиар тус тус өссөн сайн үзүүлэлттэй байна.

Эрүүл мэндийн даатгалын цахим системд цугларсан их өгөгдөл мэдээллийг боловсруулж хяналт хийх, шийдвэр гаргах процесст ашиглах зорилгоор дата боловсруулах хяналтын цахим системийг нэвтрүүлж, нийтдээ 18 тайлан судалгааны зорилгоор "**Tableau систем**"-ийг даатгалын байгууллагын хүрээнд нэвтрүүлэн мэдээллийг ил тод, түргэн шуурхай боловсруулж өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж, иргэдийн тусламж үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгаа, шинжилгээний мэдээлэл бүртгэх дашбоард хөгжүүлсэн.

Эрүүл мэндийн даатгалын цахим програмыг санхүүгийн **Fiscus** програмтай холбох үүднээс даатгалын гэрээтэй аймаг, нийслэлийн 2350 эрүүл мэндийн байгууллагуудын fincode (санхүүгийн код)-ыг ЭМД-ын цахим програм (ID-КОД)-тай нэг бүрчлэн тулгаж нэгтгэн мэдээллийн баазыг баяжуулж, 40,646 датаг **Fiscus** системд илгээж, санхүүгийн мэдээлэл солилцох хөгжүүлэлтийг дуусгасан.

ЭМДҮЗ-ийн 2024 оны 05, 06, 14 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд нийт 141 өөрчлөлт, хөгжүүлэлт хийгдэж, гэрээний мэдээллийг шинэчлэн, кодчлолын өөрчлөлтүүдийг нэвтрүүлсэн.Цахим жор үүсгэх сервисүүд (7 сервис) болон ЭМБ-аас мэдээллийг бүртгэх 5 сервис хөгжүүлсэн.

Цахим системийн аюулгүй байдлыг хангахын тулд өгөгдлийн сангийн TEMP, UNDO tablespace-ийн хэмжээг тус бүр 96GB-аар нэмэгдүүлж, серверийн аюулгүй байдлыг сайжруулсан.

### 6.4. Сургалт, сурталчилгааны үр дүн:

Даатгуулагч-иргэдийг тогтмол мэдээллээр хангах чиглэлээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний жилийн эцсийн байдлаар нийт 1,075 контент бэлтгэн түгээсэн нь давхардсан тоогоор 7,518 мянга гаруй хүнд хүрч, 38,758 удаа хуваалцжээ.

*График 13 Бэлтгэсэн контентын тоо, 2022-2024 он*




Сүүлийн 3 жилд давхардсан тоогоор 17,689.4 мянган хүн мэдээлэл авахаар ЭМДЕГ-ын цахим хуудсанд хандсан байна.

*График 14 Контент хандалтын давхардсан тоо, 2022-2024 он*




Сүүлийн 3 жилд давхардсан тоогоор 120.9 мянган хүн ЭМДЕГ-ын цахим хуудсанд хандаж, контент хуваалцсан байна.

*График 15 Контент хуваалцсан тоо, 2022-2024 он*



ЭМД-тай холбоотой мэдээ мэдээлэлд мониторинг хийж, цаг алдалгүй хариу арга хэмжээг авч түргэн шуурхай ажилласны үр дүнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр эрүүл мэндийн даатгалтай холбоотой 2089 мэдээ, мэдээлэл гарсан.

*График 16 ЭМД-тай холбоотой мэдээ, мэдээллийн үзүүлэлт*




*График 17 Нийгмийн сүлжээгээр цацагдсан байдал байдал.*




ЭМДЕГ-т мэдээлэл авахаар хуулийн этгээд, иргэнээс хандсан асуудлыг авч үзэхэд санхүүжилттэй холбоотой 26 хувь, даатгалын гэрээ байгуулах, сунгах асуудлаар 13 хувь, мэдээллийн технологи 12.5 хувь, нэхэмжлэлийн хяналтын асуудлаар 9.4 хувь, шимтгэл төлөлт 7.9 хувь, өргөдөл гомдол 0.5 хувийг тус тус эзэлж байна.

*График 18 ЭМДЕГ-т хандсан асуудлуудын талаар*




## ДОЛОО. ДҮГНЭЛТ, САНАЛ

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2024 онд 1,964.8 тэрбум төгрөгөөр батлагдсанаас 1,921.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөний биелэлт 97.8 хувьтай байна. Батлагдсан төсвийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан нийт 109.3 тэрбум төгрөгийг нэмэлт эх үүсвэрээр төвлөрүүлж, нийт орлого 2,031.2 тэрбум төгрөг болсон байна.

2. Ковидын цар тахал, эрүүл мэндийн салбарын цалингийн өсөлт, эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний суурь тариф болон тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчийн тохиолдлын тооны өсөлт зэргээс шалтгаалан эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага батлагдсан төсвөөс жил бүр хэтэрснээс сангийн тэнцэл алдагдаж, 2024 онд эрүүл мэндийн байгууллагуудад 316.8 тэрбум төгрөгийн өглөгтэй гарсан байна;

3. Засгийн газрын нийт зардалд эрүүл мэндийн зардлын эзлэх хувь 2023 онд 9.1 хувь байсан бол 2024 онд 8.4 хувь болж буурсан нь Тогтвортой хөгжлийн бодлогын зорилтоос 3.6 пунктээр доогуур байгаа тул Засгийн газрын нийт зардалд эзлэх эрүүл мэндийн улсын салбарын зардлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна;

4. Тайлант онд эрүүл мэндийн улсын зардалд эзлэх эрүүл мэндийн даатгалын сангийн зардал 75.7 хувь, эрүүл мэндийн улсын зардалд эзлэх улсын төсвийн шилжүүлгийн хэмжээ 23 хувьтай байна;

5. Эрүүл мэндийн зардалд анхан шатны тусламж, үйлчилгээний зардлын эзлэх хувь 2021 онд хамгийн өндөр буюу 23 хувь байсан бол 2022 оноос жил бүр 1.0 хувиар буурч 2024 онд 21.0 хувьтай гарсан байна;

6. Эрүүл мэндийн даатгалд нийт хүн амын 93.4 хувийг хамруулсан нь өмнөх оноос 0.9 хувиар нэмэгдсэн нь “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-ийн 2.1.2-т заасан зорилтот түвшин (92.7%)-ээс 0.7 хувиар давсан ч Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын шалгуур үзүүлэлт”-ийн зорилтот түвшин (94.0%)-ээс 0.6 хувиар бага байна;

7. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус техникийн хороог байгуулсан нь хараат бус, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн нотолгоонд суурилсан шийдвэр гаргах бодит нөхцөл бүрдсэн байна;

8. Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 01 дүгээр тогтоолоор баталсан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн шинэчилсэн дүрэмд ажлын албаны албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэлийг УИХ-аас томилогддог ажлын албаны ангилал, зэрэглэлтэй дүйцүүлэн тогтоохоор шийдвэрлэснээр ЭМДҮЗ-ийн үйл ажиллагааны жил бүрийн тайланд дурдагддаг зөрчил арилж, ажлын албаны албан хаагчдын нийгмийн баталгаа хангагдсан байна;

9. E-Mongolia болон “ebarimt” аппликейшн ашиглан нийт 321.3 мянган хүн даатгуулагч эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлж, 29.9 тэрбум төгрөгийг даатгалын санд төвлөрүүлсэн нь нийт бүрдүүлсэн бусад орлогын 87.4 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оноос даатгуулагчийн тоо 46.1 мянгаар, бусад орлогод эзлэх хувь 14.2 хувиар тус тус өссөн нь эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн үйлчилгээг иргэдэд ойртуулан, цахим хэлбэрээр, хялбар болгосонтой холбоотой зэрэг үр дүн гарсан байна.

**Цаашид анхаарах асуудал, санал**

1. Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэд нь нийт даатгуулагчийн 70.0 хувийг эзэлж, нийт шимтгэлийн орлогын 27.7 хувийг бүрдүүлж, сангаас зарцуулсан зардлын 77.2 хувийг эзэлж байгаа тул төрөөс эрүүл мэндийн даатгалыг хариуцах иргэдийн шимтгэлийн хувь, хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх;

2. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн шимтгэлийн хувь хэмжээг татвар төлж буй орлогын хэмжээтэй уялдуулан тогтоох замаар эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх;

3. Нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнээр даатгуулагчийн амь насанд гэнэтийн эрсдэл учруулж болзошгүй төрөх, жирэмсэн, нярайн тусламж, үйлчилгээ, халдварт өвчин, хавдар, түргэн тусламж, яаралтай тусламж зэрэг нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэгч эрүүл мэндийн байгууллагын тоо, түүнд зарцуулах зардлын хэмжээг тогтмол нэмэгдүүлснээр 2024 онд нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний зардал 84.2 хувьд хүрч, 2020 оноос 2 дахин өссөн тул төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх;

4. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн орлогын 10 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулна" гэж заасан бөгөөд 2024 онд эрсдэлийн санг 53.6 тэрбум төгрөгөөр байгуулсан нь нь эрүүл мэндийн даатгалын сангийн нийт орлогын 2.7 хувийг, шимтгэлийн орлогын 4.4 хувийг эзэлж байгааг нэмэгдүүлэх;

5. Эрүүл мэндэд хор хөнөөлтэй бүтээгдэхүүн болох согтууруулах ундаа, тамхины онцгой татвараас эрүүл мэндийн даатгалын сан руу оруулах замаар сангийн орлогыг өсгөх хууль эрх зүйн орчинг судалж шийдвэрлэх;

*---oOo---*

*Хүснэгт 28 Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны ээлжит хуралдааны ирц*

/Төлөөлөл бүрээр/

| № | ЭМДҮЗ-ийн бүрэлдэхүүн | 2024 он | | |
|---|---|---|---|---|
| | | Хуралдсан тоо | Оролцсон тоо | Дундаж хувь |
| **Нэг.Засгийн газрын төлөөлөл, дундаж ирц** | | **8** | **17** | **70.9%** |
| 1 | **Эрүүл мэндийн сайд, ЭМДҮЗ-ийн дарга** | **8** | **8** | **100.0%** |
| | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд | 8 | 8 | **100.0%** |
| 3 | Сангийн сайд | 8 | 1 | **12.5%** |
| **Хоёр. Даатгуулагчийн төлөөлөл, дундаж ирц** | | **8** | **20** | **83.3%** |
| 4 | Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхийлөгч | 8 | 4 | **50.0%** |
| 5 | Монголын төмөр замчдын үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга | 8 | 8 | **100.0%** |
| 6 | ШУА-ийн харъяа Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан | 8 | 8 | **100.0%** |
| **Гурав. Ажил олгогчийн төлөөлөл, дундаж ирц** | | **8** | **23** | **95.8%** |
| 7 | Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбооны ерөнхийлөгч | 8 | 8 | **100.0%** |
| 8 | Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооны УЗ-ийн гишүүн | 8 | 8 | **100.0%** |
| 9 | Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимын гишүүн | 8 | 7 | **87.5%** |
| **Нийт ирц** | | **8** | **60** | **83.3%** |

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА**

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

# 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2025 он

## АГУУЛГА


**НЭГ. ҮНДЭСЛЭЛ**

**ХОЁР.БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

2.1. ЭМДҮЗ-ийн чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт

2.2. ЭМДЕГ-ын чиг үүрэг, бүтэц

2.3. ЭМДҮЗ-ийн үндсэн үйл ажиллагаа

2.4. ЭМДҮЗ-ийн баталсан тогтоол, шийдвэр

**ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

3.1. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ

3.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого

3.3. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага

3.4. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэл, сангийн тэнцэл

3.5. Даатгуулагчийн шимтгэлийн орлого бүрдүүлэлт, тусламж, үйлчилгээ авсан зардлын харьцаа

3.6.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал

**ДӨРӨВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

4.1.Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар

4.2.ЭМДҮЗ-ийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, онцлох шийдвэрүүд

4.3.ЭМДҮЗ-ийн тогтоолын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийсэн талаар

4.4.Хууль тогтоомжийн биелэлтийн талаар

4.5.Бусад

**ТАВ. ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

5.1.УИХ-ын Тамгын газраас ЭМДҮЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээний дүгнэлт, зөвлөмж, түүний хэрэгжилтийн талаар:

5.2.Үндэсний аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудит болон санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар

**ЗУРГАА. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЯНАЛТ, ЦАХИМЖИЛТ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА**

6.1. Эрүүл мэндийн даатгалын хяналт

6.2. Цахимжилт

6.3 Сургалт, сурталчилгаа

**ДОЛОО. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ, ХАРЬЦУУЛАЛТ**

7.1. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ

7.2. Анхан шатлалын /ӨСТЭМТ/ тусламж, үйлчилгээ

7.3. Эмийн үнийн хөнгөлөлт

7.4. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ

**НАЙМ. ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, САНАЛ**

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| ЭМДҮЗ | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл |
| УИХ | Улсын Их Хурал |
| НББСШУ | Нийгмийн Бодлого, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| ЭМДЕГ | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар |
| ЭМД | Эрүүл мэндийн даатгал |
| ЭМДХ | Эрүүл мэндийн даатгалын хэлтэс |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ОШ | Оношилгоо, шинжилгээ |

## СХЕМИЙН ЖАГСААЛТ

Схем 1.ЭМДҮЗ-ийн бүтэц ........ 5
схем 2. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц ........ 6

## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Эрүүл мэндийн даатгалын хамралтын хувь, даатгуулагчийн төрлөөр .. 11
График 2. ЭМДС-ийн орлого, орлогын эх үүсвэрээр (хувиар) ........ 13
График 3. ЭМДС-ийн орлого, зарлагын гүйцэтгэл, (тэрбум төг), 2020-2024 он, ..... 14
График 4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нийт зардалд эзлэх хувь, ЭМБ-ын төрлөөр,2024 он ........ 17
График 5. ЭМДС-аас нэн шаардлагатай тусламж, үйлчилгээнд 2020-2024 онд зарцуулсан зардал (хувиар) ........ 20
График 6. Бэлтгэсэн контентын тоо, 2022-2024 он ........ 30
График 7. Контент хуваалцсан тоо, 2022-2024 он ........ 30
График 8. Контент хандалтын давхардсан тоо, 2022-2024 он ........ 31
График 9. Нийгмийн сүлжээгээр цацагдсан байдал байдал ........ 31
График 10. ЭМД-тай холбоотой мэдээ, мэдээллийн үзүүлэлт ........ 31
График 11. ЭМДЕГ-т хандсан асуудлуудын талаар: ........ 31
График 12. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо, санхүүжилтэд эзлэх хувь, тусламж үйлчилгээний нэр төрлөөр ........ 34
График 13. Эмийн үнийн хөнгөлтийн зардлын төсөв, гүйцэтгэл, хамралт, 2022-2024 он, сая төгрөгөөр ........ 39

## ХАВСРАЛТ

1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдийн хуралдааны ирц, 2024 он

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


Хүснэгт 1. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын хүний нөөцийн орон тоо ......... 6
Хүснэгт 2. ЭМДҮЗ-ийн хуралдааны тойм, гишүүдийн ирц 2022-2024 он .................. 7
Хүснэгт 3. ЭМДҮЗ-ийн хуралдааны үйл ажиллагаа, баталсан шийдвэр .................. 7
Хүснэгт 4. ЭМДҮЗ-ийн 2024 онд баталсан тогтоолууд ............................................ 8
Хүснэгт 5. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ, 2019-2024 он....... 9
Хүснэгт 6. Эрүүл мэндийн даатгалын хамралт,даатгуулагчийн төрлөөр, .............. 10
Хүснэгт 7. ЭМДС-ийн сангийн орлогын гүйцэтгэл, 2021-2024 он, мян.төгрөг ........ 12
Хүснэгт 8. ЭМДС-ийн зарлагын гүйцэтгэл, 2021-2024 он, мян.төгрөг...................... 13
Хүснэгт 9. ЭМДС-ийн мөнгөн хөрөнгийн 2023-2024 оны үлдэгдэл, сая.төгрөг ....... 15
Хүснэгт 10.ЭМДС-аас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд 2023-2024 онд ......... 16
Хүснэгт 11. Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагуудын тоо ........................................................................................ 21
Хүснэгт 12. Эмзэг бүлгийн хүн амыг хамтын төлбөрөөс чөлөөлсөн байдал 2022-2024 он /тэрбум төгрөгөөр/ ........................................................................... 21
Хүснэгт 13 хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт................................. 24
Хүснэгт 14. Эрүүл мэндийн байгууллагуудад ЭМДС-аас олгох өглөг, сая төгрөг, 2021-2024 он ......................................................................................... 27
Хүснэгт 15. Гэмт хэргийн зөрчлийн улмаас ЭМДС-д төлүүлсэн зардал, 2022-2024 он ......................................................................................... 28
Хүснэгт 16. Иргэн даатгуулагчдад олгосон буцаан олголт (мян.төг) ....................... 28
Хүснэгт 17. Тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, тусламж, үйлчилгээний багц, нэр төрлөөр, 2023-2024 он ............................................. 32
Хүснэгт 18. ӨСТЭМТ-өөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, 2022-2024 он ..................................................................................................................... 37
Хүснэгт 19. ӨСТЭМТ-өөс үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээний 2024 оны тохиолдлын тоо, олгохоор тооцсон санхүүжилт, сая төгрөгөөр ....................... 38
Хүснэгт 20. СТЭМТ-өөс үзүүлэх 4 төрлийн тусламж үйлчилгээний 2024 оны тохиолдлын тоо, олгохоор тооцсон санхүүжилт, сая төгрөгөөр............................... 38
Хүснэгт 21. Эмийн үнийн хөнгөлөлтийн төсөв, гүйцэтгэл, хамралт, 2022-2024 он, сая төгрөгөөр.......................................................................................................... 39
Хүснэгт 22. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, ....................... 40
Хүснэгт 23. Урьдчилсан сэргийлэх үзлэгийн хамралт, тохиолдол, санхүүжилт,..... 40

## НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 05 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл /цаашид "ЭМДҮЗ" гэх/-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланд Хууль зүйн яамнаас боловсруулсан 2011 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 55 дугаар "Аргачлал батлах тухай " тушаалын дагуу үнэлгээ хийсэн болно.

Үнэлгээ нь байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж, өөрийн тавьсан зорилгод ямар хэмжээнд хүрснийг тодорхойлоход чиглэх бөгөөд Системчилсэн үнэлгээ хийхдээ "Дотоодын буюу өөрийн байгууллагын үнэлгээ"-ний хэлбэрийг сонгож, дараах чиглэлээр үнэлгээ хийлээ. Үүнд:

- Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт
- Байгууллагын үндсэн үйл ажиллагаа
- Салбарын эрх зүйн орчин
- Дотоод үйл ажиллагаа

## ХОЁР.БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

**2.1. ЭМДҮЗ-ийн чиг үүрэг, бүтэц:** Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн $14^1$.1-т "Эрүүл мэндийн даатгалын удирдах дээд байгууллага нь Үндэсний зөвлөл байна.", $14^1$.2-т "Үндэсний зөвлөл нь ажлаа Улсын Их Хуралд жил бүр тайлагнана." гэж тус тус заасан.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т зааснаар эрүүл мэндийн даатгалын байгууллагын тогтолцоо нь Үндэсний зөвлөл, эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн эрүүл мэндийн даатгалын хэлтэс, сумын эрүүл мэндийн даатгал хариуцсан байцаагчаас бүрддэг хуулийн зохицуулалттай.

ЭМДҮЗ нь эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих дээд байгууллага бөгөөд эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаанд даатгагч, даатгуулагч, ажил олгогч, Засгийн газрын тэгш оролцоог хангах, төрийн бодлого, эрүүл мэндийн даатгалын байгууллагын алсын хараа, хэтийн зорилгыг хууль эрх зүйн хүрээнд тодорхойлон хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн хуулиар тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлж байна.

ЭМДҮЗ нь бүтцийн хувьд Засгийн газрыг төлөөлсөн 3 гишүүн, ажил олгогчийг төлөөлсөн 3 гишүүн, даатгуулагчийг төлөөлсөн 3 гишүүн, орон тооны бус нийт 9 гишүүнтэй, өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах чиг үүрэг бүхий ажлын албатай. Ажлын алба нь УИХ-ын НББСШУ-ны байнгын хорооноос баталсан бүтэц, орон тооны дагуу 12 орон тоотойгоос 8 орон тоотойгоор 2024 онд үйл ажиллагаа явуулж ирлээ.

Схем 1.*ЭМДҮЗ-ийн бүтэц*




Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн $14^1$.2 дахь хэсэгт зааснаар Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж таван жилийн хугацаагаар томилж, чөлөөлдөг.

Улсын Их Хурлын 2017 оны 40 дүгээр тогтоолоор томилогдсон ЭМДҮЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Улсын Их Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 27 дугаар тогтоолоор ЭМДҮЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, Засгийн газрыг төлөөлсөн гишүүнээр Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдыг, даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр Б.Алтанхуяг, Т.Баясгалан, С.Эрдэнэбат, ажил олгогчийг төлөөлсөн гишүүнээр Ж.Гэрэлмаа, Ш.Зоригоо, Н.Одонгуа нарыг тус тус томилсон.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр даатгуулагчийн олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагыг төлөөлсөн Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны ерөнхийлөгч, ЭМДҮЗ-ийн гишүүн С.Эрдэнэбат нь Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдож, ЭМДҮЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ НББХ-нд гаргасан тул ЭМДҮЗ нь 2024 оны сүүлийн хагас жилд 8 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явууллаа.

**2.2.ЭМДЕГ-ын чиг үүрэг, бүтэц:** Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 344 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг байгуулсан бөгөөд эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, эрүүл мэндийн даатгалын санг бүрдүүлэн орлого, зарлагын гүйцэтгэлийг хангаж, хяналт тавих, даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн зардлыг санхүүжүүлэх, хууль тогтоомжоор тогтоосон хугацаанд олгох, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлүүлэх, иргэд, даатгуулагчид

Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлах, ач холбогдлыг ойлгуулан таниулах замаар хамралтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн даатгалын байгууллагын ажилтнуудын мэргэшлийг дээшлүүлэх, хүний нөөцийг чадавхижуулах, эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиглэлээр хэрэгжилтийг ханган ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 176 дугаар тогтоолоор ЭМДЕГ-ын орон тооны дээд хязгаарыг 170 байхаар шинэчлэн тогтоосон.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар Эрүүл мэндийн даатгалын байгууллагын дүрмийг, 2020 оны 17 дугаар тогтоолын хавсралтаар Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтцийг шинэчлэн баталсан байна.

*Схем 2. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц*




Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь бүтцийн хувьд 5 газар, 7 хэлтэстэй, 2021 оноос 21 аймаг, Багануур, Налайх дүүргийн эрүүл мэндийн даатгалын тасгийг өргөжүүлэн "Эрүүл мэндийн даатгалын хэлтэс"-ийг байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

*Хүснэгт 1. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын хүний нөөцийн орон тоо*

| Он | Орон тоо баталсан шийдвэр | Батлагдсан орон тоо | 2024 онд ажилласан орон тоо | Сургалтын тоо | | Цалин шинэчил сэн албан хаагчийн тоо |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Дотоод | Гадаад | |
| **ЭМДҮЗ** | УИХ-ын НББСШУБХ-ны 2018 оны 18 дугаар тогтоол | 12 | 8 | 1 | 1 | 8 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **ЭМДЕГ** | Засгийн газрын 2020 оны 176 дугаар тогтоол | 170 | 193 | 17 | 9 | 193 |

**2.3.ЭМДҮЗ-ийн үндсэн үйл ажиллагаа:** ЭМДҮЗ-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.10-т "Үндэсний зөвлөл нь улирал хоёроос доошгүй удаа, шаардлагатай тохиолдолд дарга буюу гишүүдийн олонхын саналаар хуралдах бөгөөд хурлыг бүх талын оролцоог хангасан саналын эрхтэй гишүүдийн гуравны хоёроос доошгүйн ирцтэйгээр хуралдуулна." гэж зааснаар 2024 онд 8 удаагийн ээлжит хуралдааныг танхимаар зохион байгуулж, хуралдааны ирц дунджаар 83.2 хувь байна.

Хүснэгт 2. *ЭМДҮЗ-ийн хуралдааны тойм, гишүүдийн ирц 2022-2024 он*

| Он | Хуралдааны тоо | Хэлэлцсэн асуудал | Баталсан тогтоолын тоо | ЗХХАУБ-д бүртгэгдсэн тогтоолын тоо | Гишүүдийн дундаж ирц |
|---|---|---|---|---|---|
| 2022 | 12 | 24 | 18 | 6 | 77.7% |
| 2023 | 6 | 15 | 12 | 6 | 80.3% |
| 2024 | 8 | 25 | 16 | 4 | 83.2% |
| | **26** | **64** | **46** | **14** | **80.4%** |

*Даатгуулагчийн олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагыг төлөөлсөн Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны ерөнхийлөгч, ЭМДҮЗ-ийн гишүүн С.Эрдэнэбат нь Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонтой холбоотой даатгуулагчийг төлөөлсөн нэг гишүүний сул орон тоо гарч, сүүлийн хагас жилд ЭМДҮЗ-ийн хуралдааны ирцэд нөлөөлсөн болно.*

ЭМДҮЗ нь 2024 онд 8 удаа, нийт 23 цаг буюу 1384 минут хуралдаж, 25 асуудал хэлэлцэж, 16 тогтоол батлан гаргасан байна.

*Хүснэгт 3. ЭМДҮЗ-ийн хуралдааны үйл ажиллагаа, баталсан шийдвэр*

| № | Хуралдсан огноо | Гишүүдийн ирц | Хэлэлцсэн асуудлын тоо | Хуралдсан цаг /минутаар/ | Хуралдаанаар баталсан шийдвэрийн тоо |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2024.01.08 | 77.7 | 1 | 120 | 1 |
| 2 | 2024.02.06 | 88.8 | 4 | 144 | 2 |
| 3 | 2024.03.29 | 88.8 | 4 | 300 | 3 |
| 4 | 2024.04.30 | 88.8 | 3 | 55 | 1 |
| 5 | 2024.07.22 | 77.7 | 2 | 200 | 1 |
| 6 | 2024.09.16 | 77.7 | 2 | 225 | 1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | 2024.11.07 | 88.8 | 5 | 225 | 1 |
| 8 | 2024.12.14 | 77.7 | 4 | 115 | - |
| **Нийт** | | **83.2** | **25** | **1,384** | **11/5** |

**2.4.ЭМДҮЗ-ийн баталсан тогтоол, шийдвэр:** ЭМДҮЗ нь хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн даатгалын бодлого, үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн удирдлага, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн арга, өртгийг тогтоох, чанарын хяналтыг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж ирлээ.

ЭМДҮЗ нь 2024 онд 8 удаагийн ээлжит хуралдаанаар 11 тогтоол, өөрийн дотоод үйл ажиллагаатай холбоотой 5 тогтоол, нийт 16 тогтоол баталж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний 2 актыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд шинээр бүртгүүлж, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний 2 актад нэмэлт өөрчлөлт хийлгэж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Одоогийн байдлаар ЭМДҮЗ-ийн 24 тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Хүснэгт 4. *ЭМДҮЗ-ийн 2024 онд баталсан тогтоолууд*

| Д/д | Тогтоолын огноо | № | Батлагдсан тогтоол |
|---|---|---|---|
| **Нэг. ЭМДҮЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн баталсан тогтоолууд** | | | |
| **1** | 2024.01.08 | 01 | Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарийг батлах тухай |
| **2** | 2024.02.06 | 02 | Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай /сонгон шалгаруулах/ |
| **3** | 2024.03.01 | 03 | Техникийн хорооны бүрэлдэхүүн, журам шинэчлэн батлах тухай |
| **4** | 2024.03.29 | 05 | Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай тогтоолын төсөл, танилцуулга /анхан шат/ |
| **5** | 2024.03.29 | 06 | Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" тогтоолын төсөл, танилцуулга /лавлагаа шат/ |
| **6** | 2024.03.29 | 07 | Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай /Техникийн хорооны журмын 2.4.8/ |
| **7** | 2024.04.30 | 08 | Техникийн хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай |
| **8** | 2024.07.22 | 10 | Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай /2024 оны төсвийн хуваарь батлах тухай 01-р тогтоолын 2-р хавсралт/ |
| **9** | 2024.09.16 | 14 | Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоол/ |
| **10** | 2024.11.07 | 15 | Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн нарийвчилсан хуваарийг шинэчлэн батлах тухай тогтоолын төсөл, танилцуулга |
| **11** | 2024.11.07 | 16 | Эрүүл мэндийн даатгалын 2024 оны эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулах тухай" тогтоолын төсөл, танилцууулга |
| **Хоёр. Дотоод үйл ажиллагаатай холбоотой тогтоол** | | | |
| **12** | 2024.03.01 | 04 | Ажлын хэсэг байгуулах тухай |
| **13** | 2024.07.01 | 09 | Урамшуулал олгох тухай |
| **14** | 2024.07.31 | 11 | Ажлаас чөлөөлөх тухай |
| **15** | 2024.08.01 | 12 | Ажилд томилох тухай |
| **16** | 2024.09.10 | 13 | Сургалтад хамруулах тухай |

## ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа удирдлага болгон төрөөс эрүүл мэндийн даатгалын талаар баримтлах бодлого, зорилтуудын хэрэгжилтийг хангуулах, даатгалын сангийн орлого, зарлагын тэнцлийг хангах, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллалаа.

### 3.1. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Энэ хуулийн 6.1-д заасан даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар жил бүр тогтооно” гэж заасан байдаг.

Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2022 оны 10 дугаар тогтоолуудтай уялдуулж, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 491 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-т заасан даатгуулагчийн сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг түүний сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч, 0-18 насны хүүхэд болон ажил хөдөлмөр эрхлээгүй иргэний сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувиар буюу 6,600 төгрөгөөр, бусад даатгуулагчийн сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2 хувиар буюу 13,200 төгрөгөөр тогтоосон.

*Хүснэгт 5. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ, 2019-2024 он*

| № | Даатгуулагчийн төрөл | Шимтгэлийн 2020, 2021, 2022 оны хэмжээ | Шимтгэлийн 2023 оны хэмжээ | Шимтгэлийн 2024 оны хэмжээ | Төлөх хугацаа |
|---|---|---|---|---|---|
| Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ | | 420,000 төгрөг | 550,000 төгрөг | 660,000 төгрөг | |
| 1 | Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан | Хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын 4-өөс доошгүй хувиар, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь | | | Сар бүр |
| 2 | 0-18 насны хүүхэд | 4200 төгрөг /ХХДХ-ий 1%/ | 5500 төгрөг /ХХДХ-ий 1%/ | 6600 төгрөг /ХХДХ-ий 1%/ | Сар бүр |
| 3 | Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч | | | | Хагас, эсхүл бүтэн жилээр |
| 4 | Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэн | 4200 төгрөг /ХХДХ-ий 1%/ | 5500 төгрөг /ХХДХ-ий 1%/ | 6600 төгрөг /ХХДХ-ий 1%/ | Хагас, эсхүл бүтэн жилээр |
| 5 | Төрөөс шимтгэлийг нь хариуцан төлөх иргэн | 8400 төгрөг /ХХДХ-ий 2%/ | 11000 төгрөг /ХХДХ-ий 2%/ | 13200 төгрөг /ХХДХ-ий 2%/ | Сар бүр |

| 6 | Гадаадын иргэн, харьяалалгүй хүн | 8400 төгрөг /ХХДХ-ий 2%/ | 11000 төгрөг /ХХДХ-ий 2%/ | 13200 төгрөг /ХХДХ-ий 2%/ | Хагас, эсхүл бүтэн жилээр |
|---|---|---|---|---|---|

2024 онд эрүүл мэндийн даатгалд 3,274.9 мянган даатгуулагч хамрагдаж, хамрагдалт 93.4 хувьтай байна. Үүнээс аж ахуйн нэгж байгууллагад ажиллагч 770.9 мянга, малчин 51.2 мянга, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, ажилгүй иргэн 117.8 мянга, их, дээд сургууль болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцагч 42.5 мянга, төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцдаг иргэн 2,267.4 мянга, гадаадын иргэн харьяалалгүй хүн 1.3 мянган даатгуулагч эрүүл мэндийн даатгалд хамрагдлаа.

Хүснэгт 6. *Эрүүл мэндийн даатгалын хамралт,даатгуулагчийн төрлөөр, 2022-2024 он*

| № | Хамралтын төрөл | 2022 он | 2023он | 2024 он | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хамрагдвал зохих хүн амын тоо | Хамрагдсан даатгуу-лагчийн тоо | Хамрал-тын хувь |
| 1 | Аж ахуйн нэгж байгууллагын ажилтан | 749.3 | 789.0 | 770.9 | 770.9 | 100.0% |
| 2 | Малчин | 51.9 | 57.1 | 140.5 | 51.2 | 36.4% |
| 3 | Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн | 133.9 | 145.9 | 266.1 | 117.8 | 44.3% |
| 4 | Их дээд, сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагч | 14.3 | 18.8 | 59.3 | 42.5 | 71.7% |
| 5 | Гадаадын иргэн харьяалалгүй хүн | 0.6 | 0.6 | 0.5 | 1.3 | 260.0% |
| 6 | ЭМД-ыг төрөөс хариуцдаг иргэн | 2,250.4 | 2,228.8 | 2,267.4 | 2,291.2 | 101.0% |
| | **Нийт дүн** | **3,200.5** | **3,240.2** | **3,504.7** | **3,274.9** | **93.4%** |
| | **Хамралтын хувь** | **92.5%** | **92.5%** | | **93.4%** | |

Тайлант онд сүүлийн 3 жилийн статистик судалгаанд үндэслэн улсын хэмжээнд хамрагдвал зохих малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, оюутан суралцагч тус бүрээр эрүүл мэндийн даатгалын хамралтын төлөвлөгөөг ЭМДЕГ-ын даргын тушаалаар баталж, төв, орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлж, мэргэжил арга зүйгээр хангаж, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

Засгийн газрын "Оюутны талаар авах зарим арга хэмжээний тухай" 2023 оны 111 дүгээр тогтоолын дагуу их дээд, сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагч оюутнуудыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт хамруулах зорилгоор нэг удаагийн шинжтэй эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төрөөс хариуцан төлсөнтэй холбоотой их дээд, сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагчдын хамралт 42.5 мянгад хүрч, хамралт өмнөх оноос 2.3 дахин нэмэгдсэн.

Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, иргэд, даатгуулагчдад эрүүл мэндийн даатгалын ойлголт, ач холбогдлыг сурталчлан таниулах ажлын үр дүнд эрүүл мэндийн даатгалд хамрагдсан нийт даатгуулагчийн тоо өмнөх оноос 34.7 мянган даатгуулагчаар, хамралтын хувь 0.9 хувиар нэмэгдэж, гадаадын иргэн, харьяалалгүй хүний хамралт 2.6 дахин өссөн зэрэг үр дүнтэй байна.

*График 1. Эрүүл мэндийн даатгалын хамралтын хувь, даатгуулагчийн төрлөөр*




Нийгмийн даатгалын тухай ерөнхий хууль 2024 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой "Шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэд"-ийн орлогыг эрүүл мэндийн даатгалын байгууллага хариуцан төвлөрүүлж эхэлсэн бөгөөд энэхүү орлого төвлөрүүлэлтийн үйл ажиллагааг И-монголиа, И-баримт системийг ашиглан бүрэн цахимжуулж, харин цахим хэлбэрээр төлөх боломжгүй иргэдийн асуудлыг арилжааны банкаар дамжуулан төлүүлсэн. Шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчид нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ шаардлагатай үедээ эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлдөг буруу зан үйл, хандлагаас шалтгаалан хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчдын хамралт өмнөх оноос буурсан байна.

### *3.2.Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого:*

ЭМДС-ийн 2024 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 1,964.7 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд ЭМДҮЗ-ийн 2024 оны 01, 10, 15 дугаар тогтоолоор эрүүл мэндийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны 2024 оны төсвийн нарийвчилсан хуваарь болон хуваарийн өөрчлөлтийг тус тус баталж, хэрэгжилтийг хангуулсан.

Орлогын гүйцэтгэл 1,921.7 тэрбум төгрөг, үүнээс ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл 812.6 тэрбум төгрөг, төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл 324.1 тэрбум төгрөг, төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт 746.8 тэрбум төгрөг, бусад даатгуулагчаас төлөх шимтгэл 34.2 тэрбум төгрөг, бусад орлогоос 3.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 97.8 хувийн биелэлттэй байна.

Батлагдсан төсвийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан 2024 онд бусад эх үүсвэрээс буюу Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 69.1 тэрбум төгрөг, ЭМЯ-аас

35.0 тэрбум төгрөг, нийт 104.1 тэрбум төгрөгийг нэмэлт санхүүжилтээр, мөн дансны үлдэгдлээс санхүүжих 5.2 тэрбум төгрөгийг нэмэлтээр төвлөрүүлж, нийт 109.3 тэрбум төгрөгийг нэмэлт эх үүсвэрээр төвлөрүүлжээ. Ингэснээр сангийн нийт орлого 2,031.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 7. *ЭМДС-ийн сангийн орлогын гүйцэтгэл, 2021-2024 он, мян.төгрөг*

| № | Төсвийн үзүүлэлт | 2021 оны гүйцэтгэл | 2022 оны гүйцэтгэл | 2023 оны гүйцэтгэл | 2024 он | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төсөв | Гүйцэтгэл | Хувиар |
| | **САНГИЙН ОРЛОГО** | **995,952.3** | **1,219,075.1** | **1,563,809.7** | **1,964,757.3** | **1,921,743.4** | **97.8%** |
| 1 | Ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл | 388,469.0 | 616,566.5 | 859,154.7 | 859,154.7 | 812,662.2 | 94.6% |
| 2 | Төрөөс ЭМД-ыг хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл | 83,951.3 | 228,117.4 | 324,113.0 | 324,113.00 | 324,113.00 | 100.0% |
| 3 | Төр хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилт | 496,465.2 | 687,445.3 | 746,804.8 | 746,804.80 | 746,804.80 | 100.0% |
| 4 | Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл | 17,001.3 | 29,391.7 | 34,684.8 | 34,684.80 | 34,199.40 | 98.6% |
| 5 | Бусад орлого | 10,065.5 | 2,288.8 | 0.0 | - | 3,964.00 | |
| | **НЭМЭЛТ ЭХ ҮҮСВЭР** | **281,875.1** | **557,679.4** | **63,910.5** | **-** | **109,268.5** | |
| 6 | Нэмэлт санхүүжилт | 73,500.0 | 295,335.1 | 20,000.0 | - | 104,082.93 | |
| 7 | Дансны үлдэгдлээс санхүүжих | 208,375.1 | 262,344.2 | 43,910.5 | - | 5,185.58 | |
| | **НИЙТ САНХҮҮЖИЛТ** | **1,277,827.4** | **1,776,754.5** | **1,627,720.2** | | **2,031,229.1** | |

ЭМДС-ийн орлогыг бүрдүүлж буй орлогын эх үүсвэрийн эзлэх хувийг авч үзвэл 42.3 хувийг ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл, 38.9 хувийг төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт, 16.9 хувийг төрөөс ЭМД-ыг хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл, 1.8 хувийг бусад орлого тус тус эзэлж байна. ЭМДС-ийн орлого өмнөх онтой харьцуулахад ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл 2.9 хувиар, төрөөс ЭМД-ыг хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл 2.3 хувиар өссөн бол төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт 5.1 хувиар, бусад орлого 0.1 хувиар тус тус буурсан байна.

*График 2. ЭМДС-ийн орлого, орлогын эх үүсвэрээр (хувиар)*




*Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар*

### 3.3. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага:

ЭМДС-ийн 2024 оны төсвийн тухай хуулиар сангийн зарлагыг 1,933.2 тэрбум төгрөгөөр баталсан. Үүнээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд 1,725.4 тэрбум төгрөг, эмийн үнийн хөнгөлөлтөд 137.3 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардалд 16.4 тэрбум төгрөг, эрсдэлийн санд 53.6 тэрбум төгрөг, илүү төлсөн шимтгэлийн буцаан олголтод 470.9 сая төгрөгийг тус тус зарцуулахаар баталсан.

Тайлант онд сангийн тусламж, үйлчилгээний зардлын олгохоор тооцсон гүйцэтгэл 2,129.8 тэрбум төгрөг, үүнээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд 1,923.3 тэрбум төгрөг, эмийн үнийн хөнгөлөлтөд 137.8 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардалд 15.0 тэрбум төгрөг, эрсдэлийн санд 53.6 тэрбум төгрөг, илүү төлсөн шимтгэлийн буцаан олголтод 25.6 сая төгрөгийг тус тус олгохоор тооцсон нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал 197.9 тэрбум төгрөгөөр, эмийн үнийн хөнгөлөлтийн зардал 478.8 сая төгрөгөөр батлагдсан төсвөөс хэтэрсэн байна. Өмнөх оны өглөг 218.3 тэрбум төгрөгийг 2024 оны төсвөөс олгосонтой холбоотой сангийн нийт зарлага 2,348.1 тэрбум төгрөг байна.

Түүнчлэн 2024 оны эрсдэлийн сангийн 53.6 тэрбум төгрөгөөс лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардалд 43.6 тэрбум, амбулаторийн тусламж, үйлчилгээний зардалд 10.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

*Хүснэгт 8. ЭМДС-ийн зарлагын гүйцэтгэл, 2021-2024 он, мян.төгрөг*

| № | Төсвийн үзүүлэлт | 2021 оны гүйцэтгэл | 2022 оны гүйцэтгэл | 2023 оны гүйцэтгэл | 2024 он | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төсөв | Олгохоор тооцсон гүйцэтгэл | Олгосон гүйцэтгэл |
| | **САНГИЙН ЗАРЛАГА** | **1,542,492.4** | **1,877,320.4** | **1,622,801.6** | **1,933,171.6** | **2,129,752.8** | **2,088,979.2** |
| 1 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт | 1,464,825.9 | 1,477,189.3 | 1,482,480.3 | 1,725,369.4 | 1,923,313.5 | 1,883,015.0 |
| | Үүнээс: Ковидын тусламж, үйлчилгээнд | 543,036.0 | 126,236.4 | - | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Эмийн үнийн хөнгөлөлт | 68,948.8 | 80,758.1 | 89,976.0 | 137,322.8 | 137,801.6 | 137,322.8 |
| 3 | Нийгмийн даатгалын байгууллагад олгох | 1,100.0 | 1,100.0 | - | - | | - |
| 4 | Үйл ажиллагааны урсгал зардал | 7,537.7 | 13,259.5 | 10,031.4 | 16,445.8 | 15,049.5 | 15,053.2 |
| 5 | Эрсдэлийн сан | | 40,000.0 | 40,000.0 | 53,562.6 | 53,562.6 | 53,562.6 |
| 6 | Илүү төлсөн шимтгэлийн буцаан олголт | 80 | 348.5 | 313.90 | 470.9 | 25.6 | 25.6 |
| **Өмнөх оны өглөг** | | | **264,664.9** | **60,565.1** | | **218,321.7** | |
| **Нийт зарлага** | | **1,542,492.4** | **1,877,320.4** | **1,848,041.9** | | **2,348,074.5** | |
| **Сангийн тэнцэл** | | **-264,665.0** | **-60,565.9** | **-218,321.7** | | **-316,845.3** | |

***3.4. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэл, сангийн тэнцэл:***

ЭМДС-ийн орлого, зарлага жил бүр тогтмол өсөж ирсэн ба жилийн дундаж өсөлт 19 хувь байсан бол 2021 оноос эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлтийн хүрээнд улсын төсвөөс олгодог байсан төр хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилтийг ЭМДС-д нэгтгэн нэг эх үүсвэрээс санхүүжүүлдэг болсноор 2020 онтой харьцуулахад ЭМДС-ийн 2024 оны орлого өмнөх оноос 4.1 дахин, зарлага 5.5 дахин нэмэгдсэн. Тайлант онд ЭМДС-ийн орлого 2,031.2 тэрбум, зарлага 2,348.1 тэрбум байгаа нь өмнөх оноос орлого 357.9 тэрбум төгрөгөөр, зарлага 403.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Ковидын цар тахал, эрүүл мэндийн салбарын цалингийн өсөлт, эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний суурь тариф болон тусламж, үйлчилгээний тохиолдлын тооны өсөлт зэргээс шалтгаалан эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага батлагдсан төсвөөс жил бүр хэтэрснээс сангийн тэнцэл алдагдаж, 2024 онд эрүүл мэндийн байгууллагуудад 316.8 тэрбум төгрөгийн өглөгтэй гарсан байна.

График 3. *ЭМДС-ийн орлого, зарлагын гүйцэтгэл, (тэрбум төг), 2020-2024 он,*




*Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар*

Тайлант оны жилийн эцэст ЭМДС-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 155.9 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүнээс төрийн сангийн харилцах дансанд 101.1 тэрбум төгрөг, арилжааны банкны харилцах дансанд 54.7 тэрбум төгрөг байна.

Хүснэгт 9. *ЭМДС-ийн мөнгөн хөрөнгийн 2023-2024 оны үлдэгдэл, сая.төгрөг*

| № | Банкны нэр | Данс | 2023 он | 2024 он |
|---|---|---|---|---|
| 1 | Төрийн сан | Харилцах | 66,384.91 | 101,141.69 |
| 2 | Чингис хаан банк | Харилцах | 30,895.73 | 30,575.73 |
| 3 | Хаан банк | Харилцах | 25,335.56 | 9,551.47 |
| 4 | Голомт банк | Харилцах | 13,178.93 | 8,148.95 |
| 5 | Худалдаа хөгжлийн банк | Харилцах | 11,022.23 | 3,334.51 |
| 6 | Төрийн банк | Харилцах | 9,521.86 | 1,070.34 |
| 7 | Капитрон банк | Харилцах | 3,288.07 | 17.66 |
| 8 | Хас банк | Харилцах | 1,429.78 | 2,031.14 |
| | **Нийт** | | **161,057.09** | **155,871.50** |

### *3.5. Даатгуулагчийн шимтгэлийн орлого бүрдүүлэлт, тусламж, үйлчилгээ авсан зардлын харьцаа:*

Эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлогыг даатгуулагчийн нэр төрлөөр, тухайн даатгуулагчид эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулсан зардлын эзлэх хувиар харьцуулан гаргахад:

a. Цалин түүнтэй адилтгах орлогоос шимтгэл төлж буй даатгуулагч нь нийт даатгуулагчийн 23.5 хувийг эзэлж, нийт шимтгэлийн орлогын 69.4 хувийг бүрдүүлж, сангаас зарцуулсан зардлын 12.8 хувийг эзэлж байна.
b. Төрөөс шимтгэлийг нь хариуцах иргэд нь нийт даатгуулагчийн 70 хувийг эзэлж, нийт шимтгэлийн орлогын 27.7 хувийг бүрдүүлж, сангаас зарцуулсан зардлын 77.2 хувийг эзэлж байна.
c. Шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагч нь нийт даатгуулагчийн 6.5 хувийг эзэлж, нийт шимтгэлийн орлогын 2.9 хувийг бүрдүүлж, сангаас зарцуулсан зардлын 10.0 хувийг эзэлж байна.

*График 9. ЭМДС-ийн орлогыг даатгуулагчийн нэр төрлөөр болон даатгуулагчид ЭМДС-аас зарцуулсан зардлын эзлэх хувь*



Төрөөс шимтгэлийг нь хариуцах иргэдэд 0-18 насны хүүхэд, тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэн, хүүхдээ хоёр (ихэр бол гурав) нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх (эцэг), хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч болон ял эдэлж байгаа ялтан хамаардаг бөгөөд нийт 2.3 сая гаруй даатгуулагчийн шимтгэлийг төрөөс хариуцдаг. Эдгээр иргэд нь нийт шимтгэлийн орлогын 27.7 хувийг бүрдүүлж, сангаас зарцуулсан зардлын 77.2 хувийг эзэлж байгаа нь зарлага нь орлогоос 2.8 дахин их байна.

### *3.6.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал:*

2024 оны байдлаар эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд нийт 2,110.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноос эрүүл мэндийн байгууллагын төрлөөр олгосон санхүүжилтийг авч үзвэл улсын эмнэлэгт 1,127.9 тэрбум, хувийн эмнэлэгт 266.8 тэрбум, сувилалд 27.2 тэрбум, анхан шатны эрүүл мэндийн байгууллагад 487.4 тэрбум, эмийн санд 137.8 тэрбум, урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад 31.6 тэрбум, төр хариуцах эмийн зардалд 31.6 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 10. *ЭМДС-аас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд 2023-2024 онд олгосон санхүүжилт, ЭМБ-ын төрлөөр*

| ЭМБ-ын төрөл | 2023 он | | | 2024 он | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Тохиолд-лын тоо | Мөнгөн дүн /сая.төг/ | Хувиар | Тохиолд-лын тоо | Мөнгөн дүн /сая.төг/ | Хувиар |
| Улсын эмнэлэг | 9,700,766 | 973,465.0 | 54.8% | 9,586,342 | 1,127,901.9 | 53.4% |
| Хувийн эмнэлэг | 1,139,618 | 249,442.6 | 14.1% | 1,366,583 | 266,782.5 | 12.6% |
| Сувилал | 110,022 | 39,292.5 | 2.2% | 98,338 | 27,166.4 | 1.3% |
| Өрх, сум, тосгоны ЭМТ-өөс үзүүлэх 4 төрлийн ТҮ | 1,305,558 | 84,382.4 | 4.8% | 2,097,303 | 141,943.5 | 6.7% |
| Өрх, сум, тосгоны ЭМТ /нэг иргэн/ | | 274,794.1 | 15.5% | | 345,502.6 | 16.4% |
| Төр хариуцах эмийн санхүүжилт | | 11,348.3 | 0.6% | | 31,652.5 | 1.5% |
| Урьдчилан сэргийлэх үзлэг үзүүлж буй ЭМБ | 356,749 | 42,614.7 | 2.4% | 219,206 | 31,626.3 | 1.5% |
| Эмийн сан | 4,298,381 | 99,506.5 | 5.6% | 5,269,352 | 137,801.6 | 6.5% |
| **Нийт** | **16,911,094** | **1,774,846.2** | **100.0%** | **18,637,124** | **2,110,377.3** | **100%** |

2024 оны байдлаар эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд нийт 2,110.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноос эрүүл мэндийн байгууллагын төрлөөр нийт зардалд эзлэх хувийг авч үзвэл улсын эмнэлэгт 53.4 хувь, хувийн эмнэлэгт 12.6 хувь, сувилалд 1.3 хувь, анхан шатны тусламж үйлчилгээнд 23.1 хувь, үүнээс нэг иргэний санхүүжилт 16.4 хувь, өрх, сум тосгоны ЭМТ-өөс үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээ 6.7 хувь, эмийн санд 6.5 хувь, урьдчилан сэргийлэх үзлэгт болон төр хариуцах эмийн зардалд тус бүр 1.5 хувийг тус тус зарцуулсан байна.

## ДӨРӨВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

*График 4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нийт зардалд эзлэх хувь, ЭМБ-ын төрлөөр,2024 он*




### 4.1. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар:

*Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах орон тооны бус техникийн хороог байгууллаа.*

ЭМД-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.12 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд ЭМДҮЗ-ийн 2024 оны 03 дугаар тогтоолоор “Техникийн хорооны бүрэлдэхүүн, ажиллах журам”-ыг шинэчлэн баталж, орон тооны бус техникийн хорооны гишүүнийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг нээлттэй зохион байгуулсан. Сонгон шалгаруулалтад оролцсон техникийн хорооны гишүүнд нэр дэвшигчдийг ЭМДҮЗ-ийн хуралдаанд нэр дэвшигч бүрээр танилцуулж, ЭМДҮЗ-ийн 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор орон тооны бус техникийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 2021 оноос хойш хэрэгжээгүй байсан хуулийн хэрэгжилтийг хангууллаа.

Техникийн хороо байгуулагдсанаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар хараат бус, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргах бодит нөхцөл бүрдсэн ч эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024-2025 оны үйл ажиллагааны зардлын төсөвт тус хорооны гишүүдийн урамшууллын зардал батлагдаагүйн улмаас 2024 онд техникийн хороо ажиллаагүй болно. Харин 2025 онд 4 тогтоолын төсөл дээр 14 дүгнэлт, 38 зөвлөмжийг гаргаж, ЭМДҮЗ-ийн хуралдаанд танилцуулаад байна.

*Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийг шинэчлэн батлууллаа.*

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн $14^1$.4-т “Үндэсний зөвлөлийн дүрмийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо батална.” гэж

заасан тул Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийг шинэчлэн батлах тухай тогтоолын төслийг шинэчлэн боловсруулж, 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 131 дугаартай албан тоотоор НББХ-нд дахин хүргүүлсэн. Шинэчилсэн дүрмийн төсөлд хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан 23 заалтыг өөрчлөн найруулж, 17 заалтыг шинээр нэмж, 25 заалтыг холбогдох хуульд нийцүүлэн давхцал, хийдлийг арилгаж хассан. Мөн Нийгмийн бодлогын байнгын хорооноос зохион байгуулсан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийн төслийг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдаанд шинэчилсэн дүрмийн төслийг танилцуулж, хэлэлцүүлэв.

УИХ-ын НББХ-ны 11 дүгээр сарын 19-ний өдрийн ээлжит хуралдаанаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийг шинэчлэн батлах тухай тогтоолын төслийг хэлэлцүүлж, НББХ-ны гишүүдийн саналыг тусгаж, НББХ-ны 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаар дахин хэлэлцүүлж, 2025 оны 01 дүгээр тогтоолоор ЭМДҮЗ-ийн дүрмийг шинэчлэн батлуулсан. Дүрэм батлагдсанаар Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй, хариуцлагатай болж, хууль, тогтоомжийн биелэлтэд хяналт тавих эрх, үүрэг илүү өргөжин, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах үйл явц илүү сайжирч, ажлын албаны албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэлийг УИХ-аас томилогддог ажлын албаны ангилал, зэрэглэлтэй дүйцүүлэн тогтоосон.

*Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр УИХ-д санал, хүсэлтээ уламжлан ажилллалаа.*

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 113 дугаар захирамжаар байгуулагдсан “ЭМД-ын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанд ЭМДҮЗ-ийн үйл ажиллагаа, ЭМД-ын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал, боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагын талаар Үндэсний зөвлөлийн гишүүн Б.Алтанхуяг танилцуулга хийв. Тус хуралдаанд Үндэсний зөвлөлийн гишүүд, ЭМЯ, ЭМДЕГ-ын удирдлагууд, төв, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын 100 гаруй удирдах ажилтнуудын төлөөлөл оролцож, эрүүл мэндийн даатгалын асуудлаар харилцан санал солилцсон.

*Эрүүл мэндийн даатгалын өнөөгийн байдал, бодлогын шийдвэр гаргалтад салбар хоорондын хамтын ажиллагааны уялдааг нэмэгдүүлэх зорилгоор Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын олон улсын зөвлөхүүдтэй туршлага солилцлоо.*

ЭМДҮЗ-ийн гишүүдийн санаачилгаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Женев хот дахь төв оффист ажилладаг Эрүүл мэндийн системийн ахлах зөвлөх Д.Баярсайхан, ДЭМБ-ын Зүүн Өмнөд Азийн бүсийн төвийн эдийн засагч Ц.Цолмонгэрэл нарыг Монгол Улсад ирэх үеэр урьж, 08 дугаар сарын 07-ны өдөр уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Уг уулзалт, хэлэлцүүлэгт эрүүл мэндийн даатгалын харилцаанд оролцогч талууд болох Эрүүл мэндийн яам Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны холбогдох төлөөлөл, ЭМДҮЗ-ийн даатгуулагчийг болон ажил олгогчийг төлөөлсөн 5 гишүүн, Ажлын алба, зарим эрүүл

мэндийн байгууллагын төлөөллүүд оролцож, олон улсын зөвлөхүүд "Эрүүл мэндийн даатгалын зарим асуудал" сэдвээр илтгэл танилцуулж, харилцан санал солилцсон.

Олон улсын зөвлөхүүд эрүүл мэндийн даатгалын сангийн менежментийг зөв хийхийн тулд бодлогын шийдвэр гаргалтад салбар хоорондын хамтын ажиллагааны уялдааг нэмэгдүүлэх, шийдвэр гаргалтад мэргэжлийн салбар зөвлөл, мэргэжлийн холбоодыг түлхүү татан оролцуулах, нотолгоонд суурилан тогтвортой, урт хугацаанд хэрэгжүүлэх бодлогыг боловсруулах, мэргэжлийн түвшинд хэлэлцэж, үр дүнг тогтмол үнэлэх талаар хэлэлцүүлэг өрнүүлж, нэгдсэн ойлголтод хүрсэн.

**4.2.ЭМДҮЗ-ийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, онцлох шийдвэрүүд:**

ЭМДҮЗ нь хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн даатгалын бодлого, үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн удирдлага, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн арга, өртгийг тогтоох, чанарын хяналтыг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж ирлээ.

*ЭМДҮЗ-ийн 05 дугаар тогтоолоор өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн албан хаагчдын үндсэн цалин, орон нутгийн нэмэгдлийг өсгөж, тусламж, үйлчилгээний тарифыг шинэчиллээ.*

- ✓ Орон нутгийн өрхийн эрүүл мэндийн төвүүд болон сум, тосгоны эрүүл мэндийн төвийн албан хаагчдын үндсэн цалинг 10 хувиар өсгөж, орон нутгийн нэмэгдлийг 40 хувьд хүргэх холбогдох тооцооллыг цалингийн тохируулга хэсэгт тусгалаа.
- ✓ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу байгуулагдсан 1500-аас доош хүн амтай 23 сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс нэг иргэнээр тооцох санхүүжилтэд хүн амаас хамаарсан тэгш байдлын индексийн коэффициентийг 2 дахин, оношилгоо, шинжилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, зарим сэргээн засах, өдрийн эмчилгээний тарифыг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлсэн.
- ✓ Өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээг өргөжүүлж хүүхдийн өдрийн эмчилгээний багц, хүүхдийн халдварт бус суулгалт өвчний багцуудыг шинээр үүсгэснээр лавлагаа шатлалын ачааллыг бууруулах, анхан шатандаа хүртээмжтэй тусламж, үйлчилгээг авах нөхцөлийг бүрдүүлсэн.
- ✓ Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээний багцыг өргөжүүлж, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ болон хүүхэд, тулгуур хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмнэлэгт ирэх боломжгүй ахмад настанд зайлшгүй үзүүлэх тусламж, үйлчилгээг шинээр нэмсэн.

*ЭМДҮЗ-ийн 06 дугаар тогтоолоор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад үндсэн тусламж, үйлчилгээг нутагшуулахаар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн багийн үйл ажиллагааг бодлогоор дэмжлээ.*

- ✓ Алслагдмал, хүн ам цөөтэй аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагыг дэмжих, эрүүл мэндийн салбарын ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлэх зорилгоор эрүүл мэндийн даатгалын сангаас олгож буй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд бүсчлэлийн коэффициентийг тогтоож өглөө. Тухайлбал, баруун бүсэд 1.15, нийслэлд 1.0 байхаар тохируулга хийснээр баруун бүсийн эрүүл мэндийн байгууллагууд нийслэлийнхээс 15 хувиар илүү тарифаар санхүүжих болсноор иргэн амьдарч буй газраа санхүүгийн эрсдэлгүйгээр шаардлагатай тусламж, үйлчилгээг авах боломжийг бүрдүүллээ.
- ✓ Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдэд төвлөрсөн хорт хавдар, зүрх судас, хүүхдийн шүд амны хөндий, ерөнхий мэс заслын тусламж, үйлчилгээг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад үндсэн тусламж, үйлчилгээг нутагшуулах зорилгоор төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн багийг орон нутагт ажиллуулсан тохиолдолд нэмэгдэл урамшуулал олгох зохицуулалтыг хийлээ.

*Даатгуулагч эрүүл мэндийн зарим тусламж, үйлчилгээг эмнэлэгт хэвтэлгүйгээр амбулаториор, өдрийн эмчилгээгээр авах боломжийг өргөжүүллээ.*

Эрүүл мэндийн даатгалын сангийн үр ашгийг сайжруулах, шаардлагагүй өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний тоо хэмжээг бууруулах үүднээс бодлогоор амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний шинэ багцыг бий болгож, амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүллээ.

*Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний ЭМДС-ийн тусламж, үйлчилгээний зардалд эзлэх хувийг нэмэгдүүллээ.*

Нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнээр даатгуулагчийн амь насанд гэнэтийн эрсдэл учруулж болзошгүй төрөх, жирэмсэн, нярайн тусламж, үйлчилгээ, халдварт өвчин, хавдар, түргэн тусламж, яаралтай тусламж зэрэг нэн шаардлагатай тусламж, үйлчилгээнд зарцуулах зардлын хэмжээг тогтмол нэмэгдүүлснээр 2024 онд 84.2 хувьд хүрч, 2020 онтой харьцуулахад 2 дахин өссөн байна.

***График 5. ЭМДС-аас нэн шаардлагатай тусламж, үйлчилгээнд 2020-2024 онд зарцуулсан зардал (хувиар)***



*Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлснээр хорт хавдрын болон яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагын тоо өсөж, төрөлжсөн төв эмнэлгийн төвлөрлийг сааруулллаа.*

Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний зардлыг нэмэгдүүлснээр тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагын тоог 2021 онтой харьцуулахад хорт хавдрын мэс засал үзүүлэх ЭМБ-ын тоо 7.8 дахин, хорт хавдрын хими, бай эмчилгээ үзүүлэх ЭМБ-ын тоо 2.8 дахин нэмэгдсэн бол яаралтай тусламж үзүүлэх ЭМБ-ын тоо 13.0 хувиар нэмэгдсэн байна.

*Хүснэгт 11. Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагуудын тоо*

| № | Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний төрөл | 2021 он | 2022 он | 2023 он | 2024 он | Өсөлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хорт хавдар хими, бай | 13 | 16 | 30 | 37 | 184.6% |
| 2 | Хорт хавдар хөнгөвчлөх | 26 | 37 | 41 | 46 | 76.9% |
| 3 | Хорт хавдар мэс засал | 5 | 20 | 38 | 39 | 680.9% |
| 4 | Яаралтай тусламж | 54 | 62 | 61 | 61 | 13.0% |

*Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд иргэдийн халааснаас төлөх хэмжээг бууруулллаа.*

ДЭМБ-аас хийсэн судалгаагаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг авч буй иргэнээс төлөх төлбөрийн хэмжээг хувиар тогтоох нь иргэд санхүүгийн хувьд ядуурал д илүү өртдөг тул хамтын төлбөрийн бодлогод өөрчлөлт оруулж, хамтын төлбөрийн хэмжээг хувиар биш тогтмол мөнгөн дүнгээр төлөх хэлбэрт шилжүүлснээр өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээнд иргэдийн төлөх төлбөрийн хэмжээ буурсан. Тухайлбал, элэг шилжүүлэн суулгах мэс заслын төлбөрийн хэмжээ 113.6 сая, даатгуулагч хувиасаа 28.4 сая төгрөг төлдөг байсныг 5.0 сая төгрөг болгон бууруулснаар халааснаас төлөх төлбөрийн хэмжээ өмнөхөөс 5.7 дахин буурсан.

*Эмзэг бүлгийн иргэдийг санхүүгийн эрсдэлээс хамгаалж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төлөх хамтын төлбөрөөс чөлөөллөө.*

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төрөөс хариуцдаг иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд иргэний хариуцан төлөх хамтын төлбөрөөс бүрэн чөлөөлснөөр 2021 онд 39 тэрбум, 2022 онд 47 тэрбум төгрөг, 2023 онд 62.8 тэрбум төгрөгийг, 2024 онд 76.8 тэрбум төгрөгийг хамтын төлбөрөөс чөлөөлсөн нь 2021 онтой харьцуулахад бараг 2 дахин өссөн байна.

*Хүснэгт 12. Эмзэг бүлгийн хүн амыг хамтын төлбөрөөс чөлөөлсөн байдал 2022-2024 он /тэрбум төгрөгөөр/*

| № | Хамтын төлбөрөөс чөлөөлөх бүлэг | Хамтын төлбөрөөс чөлөөлсөн дүн | | |
|---|---|---|---|---|
| | | 2022 он | 2023 он | 2024 он |
| 1 | Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн | 3.26 | 7.34 | 8.67 |
| 2 | Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн | 30.69 | 42.71 | 49.62 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | Ял эдэлж байгаа ялтан | 0.05 | 0.04 | 0.04 |
| 4 | 0-18 насны хүүхэд | 10.12 | 13.51 | 16.18 |
| 5 | Хугацаат цэргийн албан хаагч | 0.04 | 0.06 | 0.06 |
| 6 | Хүүхдээ хоёр /ихэр бол гурав/ нас хүртэл өсгөн бойжуулж буй эх, эцэг | 2.97 | 1.85 | 2.18 |
| | **Нийт** | **47.16** | **62.81** | **76.75** |

### 4.3. ЭМДҮЗ-ийн тогтоолын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийсэн талаар:

*Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын хэрэгжилтийн явцад хяналт, үнэлгээ хийсэн талаар:*

***Эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн нэхэмжлэлийн талаар:***

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийн хяналтын мэдээлэлд 2024 оны эхний 10 сарын байдлаар судалгааг хийхэд эхний 10 сарын байдлаар төв орон нутгийн 300 эрүүл мэндийн байгууллагаас 10.1 сая тохиолдлын 1.3 их наяд төгрөгийн нэхэмжлэл ирүүлснийг хянасан байна.

А. Эрүүл мэндийн байгууллагын төрлөөр авч үзвэл:

- ✓ төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад 8.5 сая тохиолдлын 992.7 (86.2%) тэрбум төгрөг,
- ✓ хувийн хэвшлийн эмнэлэгт 1.3 сая тохиолдлын 246.8 (12.8%) тэрбум төгрөг,
- ✓ рашаан сувилалд 9.1 мянган тохиолдолд 24.9 (0.9%) тэрбум төгрөгийг олгосон дүнтэй байна.

Б. Тусламж, үйлчилгээний төрлөөр авч үзвэл нийт олгохоор тооцсон 1.3 наяд төгрөгийн:

- ✓ 55.9 хувь буюу 706.2 тэрбум төгрөг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд,
- ✓ 20.9 хувь буюу 264.6 тэрбум төгрөг амбулаторийн тусламж, үйлчилгээнд,
- ✓ 4 хувь буюу 50.8 тэрбум төгрөг өдрийн эмчилгээнд,
- ✓ бусад тусламж, үйлчилгээнд 0.6-3.9 хувь буюу 7.5 тэрбум төгрөгөөс 49.6 тэрбум төгрөг зарцуулагдсан дүнтэй байна.

В. Тохиолдлын тоог авч үзвэл нийт 9.8 мянган тохиолдлын:

- ✓ 67.0 хувь буюу 6.6 сая тохиолдол нь амбулаторийн тусламж, үйлчилгээ
- ✓ 8.1 хувь буюу 797.0 мянган тохиолдол яаралтай тусламж, үйлчилгээ,
- ✓ 6.5 хувь буюу 640.5 мянган тохиолдлыг хэвтэн эмчлүүлэх тусламж,үйлчилгээний тохиолдлын тоо ээзлж байна.

***Нэхэмжлэлийн хяналтын хасагдлын талаар:***

А. Цахим хасагдлаар 18.6 тэрбум төгрөгийн хасалт хийж, 629.2 мянган тохиолдлын (6.2 хувь) 465.4 тэрбум (38.4 хувь) төгрөгийг тусламж, үйлчилгээг

түүвэрлэн шалгаснаас нарийвчилсан хяналтаар 100.9 мянган тохиолдлын 40.9 тэрбум төгрөгийг хассанд эх олонлогоор 42.9 мянган тохиолдолд 13.1 тэрбум төгрөгийн хасагдал тооцсон дүнтэй байна.

Б. Хасагдлыг эрүүл мэндийн байгууллагын төрлөөр авч үзвэл нарийвчилсан хяналт болон эх олонлогоор хасагдсан нийт 54.1 тэрбум төгрөгийн

- ✓ 86.9 хувь буюу 47.0 тэрбум төгрөг улсын эмнэлгүүдийн нэхэмжлэлээс:
- ✓ 12.8 хувь буюу 6.9 тэрбум төгрөг хувийн эмнэлгүүдийн нэхэмжлэлээс,
- ✓ 0.3 хувь буюу 0.1 тэрбум төгрөг рашаан сувиллын нэхэмжлэлээс тус тус хасагдсан байна.

В. Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналт болон эх олонлогийн хасалтаар хасагдсаныг тусламж, үйлчилгээний төрлөөр авч үзвэл:

- ✓ нийт хасалтын 70.4 хувь буюу 38.0 тэрбум төгрөг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнээс,
- ✓ 19.0 хувь буюу 10.3 тэрбум төгрөг яаралтай тусламжаас хасагдсан дүнтэй байна.

Хэвтүүлэн эмчлэх 1 тохиолдолд зарцуулагдаж буй зардал дунджаар 1.1 сая төгрөг, хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд 963.8 мянган төгрөг, өдрийн эмчилгээнд 370.1 мянган төгрөг зарцуулсан байна.

***Хөнгөлөлттэй эмийн жагсаалтыг баталсан тогтоолын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийсэн талаар:***

ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоол /хамрах хүрээ 2022.01.01-2024.08.31-ний байдлаар/-ын хүрээнд хөнгөлттэй эмийн жор бичилт болон эмийн үнийн хөнгөлөлтийн зардлын гүйцэтгэлийн тоо, мэдээллийг, даатгуулагчийн регистрийг patient_id буюу давтагдахгүй дугаараар орлуулан, эм бичсэн эрүүл мэндийн байгууллага болон эм олгосон эмийн сангийн нэр, байршил, эмийн сангийн нэхэмжлэлийн тоо, мөнгөн дүн, даатгалын байгууллагын олгосон тоо, мөнгөн дүнг нэгтгэн судалгаа хийж, дараах дүгнэлтийг гаргав.

- ✓ ЭМДС-аас эмийн үнийн хөнгөлөлтийн зардалд 2022 онд 3.9 сая тохиолдолд 79.4 тэрбум төгрөгийг олгохоор тооцсон бол 2023 онд 4.2 сая тохиолдолд 89.9 тэрбум төгрөгийг олгохоор тооцсон байна. Өмнөх онтой харьцуулахад 2023 онд тохиолдлын тоо 409.5 мянга, санхүүжилт 10.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.
- ✓ 2024 оны 1-8 сард 3.6 сая тохиолдолд 93.3 тэрбум төгрөгийг олгохоор тооцсон нь 2023 оны 1-12 сараас 3.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, 2023 оны 1-8 сартай харьцуулахад 35.7 тэрбум төгрөг (62%)-өөр нэмэгдсэн дүнтэй байна.
- ✓ Эмийн үнийн хөнгөлөлтөд хамрагдсан даатгуулагчийн тоо давхардалгүйгээр 2022 онд 568.8 мянга, 2023 онд 645.6 мянган даатгуулагч байна. Монгол Улсын хүн амын тоо 2022 онд 3,368,632 бөгөөд эмийн үнийн хөнгөлөлтөд хамрагдсан даатгуулагч нийт хүн амын 2022 онд 17.9 хувийг 2023 онд 20.5 хувийг эзэлж ЭҮХ-т хамрагдсан

даатгуулагчийн тоо 2023 онд урьд оноос 76.8 мянган хүнээр буюу 2.6 хувиар нэмэгдсэн байна.

- ✓ Эмийн үнийн хөнгөлөлтөд хамрагдсан даатгуулагчийн мэдээллийг аймаг тус бүрээр салгаж, тус аймгийн хүн амын хэдэн хувь эмийн үнийн хөнгөлөлтөд хамрагдаж байгааг гаргавал хамгийн өндөр нь 2022 онд Орхон аймаг 21.7 хувь, Ховд аймаг 21.6 хувь байгаа бол хамгийн бага нь Хөвсгөл аймаг 12.1 хувь, Сэлэнгэ аймаг 14.5 хувь байна. 2023 онд Орхон аймаг 24.6 хувь хамгийн өндөр бол Улаанбаатар хот, Булган аймгууд 23.2 хувь болж нэмэгдсэн байна. Хамгийн бага нь Баян-Өлгий аймаг хүн амын 7.8 хувь хамрагдсан нь ЭМДЕГ-аас 2023 онд тус аймагт хийсэн хяналт шалгалтаар зарим эмийн сангийн гэрээг цуцалсантай холбоотой байна.
- ✓ Эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг нийслэлд дунджаар нэг даатгуулагч жилдээ 2022 онд 6.4 удаа, 2023 онд 6.2 удаа авсан бол 2023 онд нийслэлд 6.6 удаа, орон нутагт 5.7 удаа авсан байна.
- ✓ Нэг эмийн жорд ногдох дундаж зардал 2022 онд 20.4 мянган төгрөг, 2023 онд 20.9 мянган төгрөг бол 2024 онд 25.5 мянган төгрөг болж өссөн дүнтэй байна.

### 4.4. Хууль тогтоомжийн биелэлтийн талаар:

Тайлант оны жилийн эцсийн байдлаар нийт 29 хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн 120 заалтыг хяналтад авснаас, биелэлтийн хувь 98.6 хувьтай байна.

*Хүснэгт 13 Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт*

| № | Хяналтад авсан | Хууль, тогтоомжийн тоо | Заалтын тоо | Хэрэгжилт /хувиар/ |
|---|---|---|---|---|
| 1 | Монгол Улсын хууль | 1 | 39 | 98.7 |
| 2 | Монгол Улсын Их Хурлын тогтоол | 4 | 8 | 100.0 |
| 3 | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол | 24 | 73 | 98.0 |
| | **Нийт** | **29** | **120** | **98.9** |

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.3-т заасан аргачлалын дагуу үнэлэхэд Монгол Улсын хуулиар үүрэг чиглэл болгосон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 39 заалтын хэрэгжилт 98.7 хувь, Улсын Их Хурлын 4 тогтоолын 8 заалтын хэрэгжилт 100.0 хувь, ЭМДҮЗ-ийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 24 тогтоолын 73 заалтын хэрэгжилт 98.0 хувь буюу нийт 29 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 120 заалтын хэрэгжилт 98.9 хувьтай байна.

*Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дараах 2 заалтын хэрэгжилт бүрэн биелээгүй байна. Үүнд:*

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т "Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагч мэргэшлийн зэрэгтэй байх бөгөөд мэргэшлийн зэрэг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журмыг Үндэсний зөвлөл батална." Гэж

заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэрэг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журмыг ЭМДҮЗ-ийн 2024 оны 02 дугаар хуралдаанаар хэлэлцээд улсын байцаагчийн шалгалтыг тогтмол зохион байгуулах, мэргэшлийн зэрэгт тавигдах шаардлагыг нэмэгдүүлэхийг үүрэг болгож, төслийг сайжруулахаар ЭМДЕГ-т буцаасан тул хэрэгжилтийг 50 хувийн биелэлттэй тайлагнасан.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.12-т заасны дагуу 2024 онд орон тооны бус техникийн хороог байгуулсан хэдий ч тус хорооны гишүүдийн урамшууллын зардал нь ЭМДҮЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсөвт батлагдаагүйн улмаас техникийн хороо дүгнэлт, зөвлөмж гаргаагүй болно.

**4.5. Бусад**

Ажлын алба Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, баримт бичгийн улсын стандартын дагуу 136 албан бичиг, 11 өргөдөл хүлээн авч, бүртгэл хяналтын карт хөтөлж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, холбогдох байгууллага, иргэдэд 151 албан бичиг явуулсан байна.

2024 онд ЭМДҮЗ-ийн батлагдсан төсөв 744.9 сая төгрөгийг Төсвийн тухай хуулийн дагуу зарцуулан ажиллаж, санхүүгийн өр төлбөр, авлагагүй ажилласан байна.

## ТАВ. ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

**5.1.УИХ-ын Тамгын газраас ЭМДҮЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээний дүгнэлт, зөвлөмж, түүний хэрэгжилтийн талаар:**

Улсын Их Хурлын Тамгын газраас “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээ”-г 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр ЭМДҮЗ-д ирүүлсэн.

Тус шинжилгээнд ЭМДҮЗ нь 2023 онд өөрийн бүрэн эрхийн хүрээнд холбогдох шийдвэр гаргахаас гадна эрүүл мэндийн даатгалын сангийн голлох тоон үзүүлэлтэд сүүлийн 3-5 жилээр харьцуулсан шинжилгээ хийж, тогтоолын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийж, үр дүнг тооцож, алдаа зөрчлийг арилгуулахтай холбоотой тодорхой санал гаргаж, НББХ-ны хуралдаанаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар анх удаа тайлагнаж, Үндэсний зөвлөлийн батлан хэрэгжүүлсэн шийдвэрүүдийн ололттой талыг гаргаж тавьснаар “байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж, өөрийн тавьсан зорилгод ямар хэмжээнд хүрснийг тодорхойлоход чиглэнэ” гэсэн үнэлгээний зорилгодоо хүрч, тайлан ач холбогдолтой болсон гэж дүгнэж ирүүлжээ.

Мөн анхаарах шаардлагатай 10 асуудалд холбогдох зөвлөмжийг ирүүлсэн бөгөөд зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх хамтарсан ажлын төлөвлөгөөг боловсруулан, ЭМДҮЗ-ийн ажлын албаны дарга, ЭМДЕГ-ын даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажилласнаас дараах зөвлөмжийн хэрэгжилт бүрэн биелэгдсэн байна.

- ✓ *Зөвлөмж 1 биелэлт:* 2024 онд эрүүл мэндийн даатгалд 3,274.2 мянган даатгуулагч хамрагдаж, хамрагдалт 93.4 хувьтай байгаа нь өмнөх оноос хамралтын хувь 0.9 хувиар өссөн.
- ✓ *Зөвлөмж 2 биелэлт:* ЭМДС-ийн 2024 оны төсвийн тухай хуулиар эрсдэлийн санг 53,6 тэрбум төгрөгөөр баталсан нь ЭМДС-ийн нийт орлогын 2.8 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 0.3 хувиар, мөнгөн дүнгээр 13,6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.
- ✓ *Зөвлөмж 4, 6 биелэлт:* УИХ-ын НББХ-ны 2025 оны 01 дүгээр тогтоолоор баталсан ЭМДҮЗ-ийн шинэчилсэн дүрэмд “ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал нь төрийн захиргааны албан тушаалд хамаарах бөгөөд цалингийн сүлжээ, албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэвийг Улсын Их Хурлаас томилогддог байгууллагын ажлын албатай дүйцүүлэн тогтооно.” гэж тусгаснаар ажлын албаны албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэвийг Улсын Их Хурлаас томилогддог байгууллагын ажлын албатай дүйцүүлэн тогтоох эрх зүйн нөхцөл бүрдсэн.
- ✓ *Зөвлөмж 5,10 биелэлт:* Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор өгсөн үүрэг, чиглэлийн хэрэгжилт болон тайланд хуулиар олгосон бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний эерэг болон сөрөг нөлөөлөл, үр дүнг дэлгэрэнгүй байдлаар тайлагнасан. */Хууль тогтоомжийн биелэлт /22 хуудас/-ийг заалт бүрээр дэлгэрэнгүй гаргаж, 2023 оны үйл ажиллагааны тайлангийн хамт НББХ-нд хүргүүлсэн болно./*

Зөвлөмжид тусгагдсан эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хэмжээг нэмэгдүүлэх, сангийн чөлөөт үлдэгдэлд хүү тооцох асуудлыг шийдвэрлэх, Капитал, Чингис хаан банкнаас хүлээн авсан өр, авлагын хэмжээг бууруулах, аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, эрсдэлд суурилсан дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааг тогтмолжуулах зөвлөмжийн биелэлтийг эрчимжүүлж, холбогдох төлөвлөгөөг гаргуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Тайлант оны жилийн эцсийн байдлаар нийт 29 хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн 120 заалтыг хяналтад авснаас, биелэлтийн хувь 98.6 хувьтай байна.

**5.2.Үндэсний аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудит болон санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар:**

Үндэсний аудитын газраас эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж, аудитаар сангийн төсвийн гүйцэтгэлтэй холбоотойгоор нийт 250,439.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 250,252.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 186.1 сая төгрөгийн зөвлөмжийг ЭМДЕГ-т хүргүүлсэн байна.

***Албан шаардлага 953/АО121241 СНЭГ-2024/34/НА- СТА-ТЕЗ биелэлт:***

ШШГЕГ-аас 2024 онд Чингис хаан банканд байрших, эрсдэл үүссэн 30,895.7 сая төгрөгөөс 320.0 сая төгрөгийг ЭМДС-ийн Төрийн сан банкны дансанд төвлөрүүлж, 30,575.7 сая төгрөгийн авлагатай байна.

***Албан шаардлага 954/АО121241 СНЭГ-2024/34/НА- СТА-ТЕЗ биелэлт:***

Хаппи веритас ХХК-ийн Интерферон альфа эмнлэгээс 876.8 сая төгрөгийн авлага нь Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх хурлаар нэхэмжлэгч талын нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн бөгөөд хариуцагч ЭМДЕГ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч Нийслэлийн захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж, Давж заалдах шатны шүүхийн магадлал албажиж гараагүй хүлээгдэж байна. Харин Аюурвэйд ХХК-ий 5.9 сая төгрөгийн авлагыг ЭМДС-ийн Төрийн сан банкны дансанд бүрэн төвлөрүүлсэн.

***Албан шаардлага 955/АО121241 СНЭГ-2024/34/НА- СТА-ТЕЗ биелэлт:***

Капитал банкны эрх хүлээн авагчаас шилжүүлэн авсан "Энхтайван найрамдлын ордон"-г 2021 онд "М" ХХК-тай түрээслэх гэрээ байгуулан ажиллаж байсан бөгөөд 2022 оны 12-р сард "М" ХХК-ны эзэн "Б" нь нас барсан тул Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2024 оны 7-р сарын 6-ны 182/ШЗ2023/08888 тоот захирамжаар Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгосон тул Шүүхийн захирамжийн дагуу авлагаас хасаж бүртгэсэн болно.

***Албан шаардлага 956/АО121241 СНЭГ-2024/34/НА-СТА-ТЕЗ биелэлт:***

Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад төлөх 2023 оны 218.3 тэрбум төгрөгийн өглөгийг эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвөөс бүрэн олгосон бөгөөд улирлын томуу, томуу төст өвчний дэгдэлттэй холбоотой эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалан 2024 онд 316.8 тэрбум төгрөгийн өглөгтэй гарсан.

*Хүснэгт 14. Эрүүл мэндийн байгууллагуудад ЭМДС-аас олгох өглөг, сая төгрөг, 2021-2024 он*

| № | ЭМБ-ын төрөл | 2021 оны өглөг | 2022 оны өглөг | 2023 оны өглөг | 2024 оны өглөг | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Төрийн өмчийн эмнэлэг | 163,790.93 | 60,506.16 | 181,304.49 | 184,660.46 | 58.3 |
| 2 | Хувийн эмнэлэг | 22,183.33 | - | 19,176.20 | 46,698.85 | 14.7 |
| 3 | Рашаан сувилал | 3,324.68 | - | 474.26 | 6,204.98 | 2.0 |
| 4 | Эмийн сан | 7,782.13 | 0.27 | 5,708.62 | 19,329.03 | 6.1 |
| 5 | Өрхийн эмнэлэг | 52,424.96 | 0.36 | 5,946.17 | 11,025.04 | 3.5 |
| 6 | Сумын ЭМТ | 0.66 | 49.11 | 5,390.99 | 48,822.74 | 15.4 |
| 7 | Бусад | 15,158.29 | 9.17 | 320.93 | 97.47 | 0 |
| | **НИЙТ ДҮН** | **264,664.99** | **60,565.07** | **218,321.67** | **316,838.57** | **100** |

***Аудитын зөвлөмжийн биелэлтийн талаар:***

Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх хүрээнд авлага барагдуулах ажлын хэсэг байгуулан ажиллаж, Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 136.1 тэрбум төгрөгийн авлагаас тус банкны эрх хүлээн авагч 13.4 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгөөр төлсөн. 46.7 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгө хүлээн авснаас 11.1 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн орлогыг ЭМДС-ийн дансанд төвлөрүүлж, 2024 оны жилийн эцсийн байдлаар Капитал банкны авлага 76.0 тэрбум төгрөг байна. Капитал банкнаас хүлээн авсан үл хөдлөх хөрөнгөөс Улаанбаатар хотод 20, орон нутагт 12 аж ахуйн нэгж, нийт 32 аж ахуйн нэгж, хувь хүнтэй түрээсийн гэрээ байгуулан ажиллаж, 2024 онд 896,4 сая төгрөгийн түрээсийн орлогыг ЭМДС-д төвлөрүүлсэн. Харин Чингис хаан банканд 30.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

## ЗУРГАА. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЯНАЛТ, ЦАХИМЖИЛТ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

### 6.1. Эрүүл мэндийн даатгалын хяналт

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д “гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрүүл мэнд нь хохирсон даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг холбогдох хууль хяналтын байгууллага хариуцан буруутай этгээдээр эрүүл мэндийн даатгалын байгууллагад нөхөн төлүүлнэ.” гэж заасан. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2024 онд 2,407.5 сая төгрөгийн зардлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос 263 дахин өссөн байна.

*Хүснэгт 15. Гэмт хэргийн зөрчлийн улмаас ЭМДС-д төлүүлсэн зардал, 2022-2024 он*

| Он | Гэм буруутай иргэдийн тоо | Нөхөн төлүүлсэн дүн /мян.төг/ |
|---|---|---|
| 2022 | 610 | 281,233.9 |
| 2023 | 1646 | 1,066,668.6 |
| 2024 | 3421 | 2,407,566.5 |
| **Нийт** | **5677** | **3,755,469.0** |

Даатгуулагчийн гомдлын мөрөөр 2024 онд ЭМДЕГ-аас 6 эрүүл мэндийн байгууллагад газар дээрх хяналт шалгалтыг хийж, 16 иргэн даатгуулагчийн нэмэлт төлбөр төлсөн мэдээллийг баримт нотолгоонд тулгуурлан бодитой эсэхийг нягтлан шалгаж, тусламж, үйлчилгээ авах үедээ гэрээнд заагаагүй нэмэлт төлбөр авсан 6 иргэний төлбөрийн баримтыг үндэслэн 455.0 мянган төгрөгийг буцаан олгуулж, даатгуулагчдыг хохиролгүй болгосон.

*Хүснэгт 16. Иргэн даатгуулагчдад олгосон буцаан олголт (мян.төг)*

| Буцаан олголт | 2022 он | | 2023 он | | 2024 он | |
|---|---|---|---|---|---|---|
| | **Хүний тоо** | **Мөнгөн дүн** | **Хүний тоо** | **Мөнгөн дүн** | **Хүний тоо** | **Мөнгөн дүн** |
| Эрүүл мэндийн байгууллага нь эмтариа гаднаас авахуулсан | - | - | 5 | 11,285.4 | | |
| Гэрээнд тусгагдаагүй нэмэлт төлбөр авсан | 12 | 13,996.4 | 3 | 2,323.3 | 6 | 455.0 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Өөр байгууллагад оношилгоо, шинжилгээнд илгээсэн | - | - | 3 | 1,996.2 | - | - |
| Мессеж мэдээллийн дагуу газар дээрх хяналтаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх хугацаанд нь гаднаас авахуулсан эм тарианы мөнгийг буцаан олгуулсан байдал | - | - | 9 | 1,078.9 | - | - |
| **Нийт** | **12** | **13,996.4** | **20** | **16,683.7** | **6** | **455.0** |

**6.2. Цахимжилт**

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын төлбөр, тооцоо, даатгуулагчид болон ажил үйлчилгээ худалдан авах байгууллагуудтай харилцах, даатгалын санд хяналт тавих ажиллагаа цахим хэлбэрт бүрэн шилжсэн. Үндэсний зөвлөл, ЭМДЕГ-аас орчин үеийн мэдээллийн технологийн боломж, нөөцийг ашиглан, гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудыг эрүүл мэндийн даатгалын системтэй цахимаар холбох, цахим баримтын системтэй уялдуулан мэдээллийг хянах тогтолцоог хөгжүүлэхээр зорьсон нь тодорхой үр дүнд хүрсэн.

Эрүүл мэндийн даатгалын цахим системд даатгалын гэрээтэй 2350 байгууллага холбогдсон бөгөөд бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын иргэд, даатгуулагчдад үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, үр дүнд үндэслэн санхүүжүүлэх, хяналт тавих зорилготой эрүүл мэндийн даатгалын цахим тогтолцоог хөгжүүлэн ажилласан.

E-Mongolia академи улсын үйлдвэрийн газартай ХУР системээр дамжуулан мэдээлэл солилцох 16 сервис, Монгол Улсын донорын хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд донорын нэгдсэн сангийн 6 сервис, жирэмсний хяналтын дэвтрийн мэдээллийг E-Mongolia платформ руу дамжуулах 4 сервисийг хөгжүүлсэн.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн үйлчилгээг иргэдэд хялбар болгох зорилгоор Төрийн үйлчилгээний төлбөрийн нэгдсэн системд **E-Mongolia** болон **“ebarimt”** аппликейшн ашиглан хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, оюутан, малчин, гадаадын иргэн харьяалалгүй хүн зэрэг нийт 321,3 мянган хүн эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлж, 29,9 тэрбум төгрөгийг даатгалын санд төвлөрүүлсэн нь нийт бүрдүүлсэн бусад орлогын 87.4 хувийг эзэлж байна. **E-Mongolia** болон **“ebarimt”** аппликейшн ашиглан шимтгэлээ төлсөн даатгуулагчийн тоо өмнөх оноос 46.1 мянган даатгуулагчаар, бусад орлогод эзлэх хувь 14.2 хувиар тус тус өссөн сайн үзүүлэлттэй байна.

Эрүүл мэндийн даатгалын цахим системд цугларсан их өгөгдөл мэдээллийг боловсруулж хяналт хийх, шийдвэр гаргах процесст ашиглах зорилгоор дата боловсруулах хяналтын цахим системийг нэвтрүүлж, нийтдээ 18 тайлан судалгааны зорилгоор “**Tableau систем**”-ийг даатгалын байгууллагын хүрээнд нэвтрүүлэн мэдээллийг ил тод, түргэн шуурхай боловсруулж өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж, иргэдийн тусламж үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгаа, шинжилгээний мэдээлэл бүртгэх дашбоард хөгжүүлсэн.

Эрүүл мэндийн даатгалын цахим программыг санхүүгийн **Fiscus** программтай холбох үүднээс даатгалын гэрээтэй аймаг, нийслэлийн 2350 эрүүл мэндийн байгууллагуудын fincode (санхүүгийн код)-ыг ЭМД-ын цахим программ (ID-

КОД)-тай нэг бүрчлэн тулгаж нэгтгэн мэдээллийн баазыг баяжуулж, 40,646 датаг **Fiscus** системд илгээж, санхүүгийн мэдээлэл солилцох хөгжүүлэлтийг дуусгасан.

ЭМДҮЗ-ийн 2024 оны 05, 06, 14 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд нийт 141 өөрчлөлт, хөгжүүлэлт хийгдэж, гэрээний мэдээллийг шинэчлэн, кодчиллын өөрчлөлтүүдийг нэвтрүүлсэн.Цахим жор үүсгэх сервисүүд (7 сервис) болон ЭМБ-аас мэдээллийг бүртгэх 5 сервис хөгжүүлсэн.

Цахим системийн аюулгүй байдлыг хангахын тулд өгөгдлийн сангийн TEMP, UNDO tablespace-ийн хэмжээг тус бүр 96GB-аар нэмэгдүүлж, серверийн аюулгүй байдлыг сайжруулсан.

### 6.3. Сургалт, сурталчилгаа

Даатгуулагч-иргэдийг тогтмол мэдээллээр хангах чиглэлээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний жилийн эцсийн байдлаар нийт 1,075 контент бэлтгэн түгээсэн нь давхардсан тоогоор 7,518 мянга гаруй хүнд хүрч, 38,758 удаа хуваалцжээ.

График 6. *Бэлтгэсэн контентын тоо, 2022-2024 он*




Сүүлийн 3 жилд давхардсан тоогоор 17,689.4 мянган хүн мэдээлэл авахаар ЭМДЕГ-ын цахим хуудсанд хандсан байна.

*График 7. . Контент хуваалцсан тоо, 2022-2024 он*




Сүүлийн 3 жилд давхардсан тоогоор 120.9 мянган хүн ЭМДЕГ-ын цахим хуудсанд хандаж, контент хуваалцсан байна.

*График 8. Контент хандалтын давхардсан тоо, 2022-2024 он*




ЭМД-тай холбоотой мэдээ мэдээлэлд мониторинг хийж, цаг алдалгүй хариу арга хэмжээг авч түргэн шуурхай ажилласны үр дүнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр эрүүл мэндийн даатгалтай холбоотой 2089 мэдээ, мэдээлэл гарсан.

*График 10. ЭМД-тай холбоотой мэдээ, мэдээллийн үзүүлэлт*




*График 9. Нийгмийн сүлжээгээр цацагдсан байдал байдал*




ЭМДЕГ-т мэдээлэл авахаар хуулийн этгээд, иргэнээс хандсан асуудлыг авч үзэхэд санхүүжилттэй холбоотой 26 хувь, даатгалын гэрээ байгуулах, сунгах асуудлаар 13 хувь, мэдээллийн технологи 12.5 хувь, нэхэмжлэлийн хяналтын асуудлаар 9.4 хувь, шимтгэл төлөлт 7.9 хувь, өргөдөл гомдол 0.5 хувийг тус тус эзэлж байна.

*График 11. ЭМДЕГ-т хандсан асуудлуудын талаар:*



# ДОЛОО. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ, ХАРЬЦУУЛАЛТ

## 7.1. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлгийн тусламж, үйлчилгээний 12 багцад 2024 онд 11.1 сая тохиолдолд 1.4 их наяд төгрөгийн санхүүжилт олгосон нь 2023 онтой харьцуулахад тохиолдлын тоо 0.9 хувь, санхүүжилт 13.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт 11.1 сая тохиолдлын 83.9 хувь буюу 5.8 сая нь төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас, 15.6 хувь буюу 1.0 сая нь хувийн хэвшлийн эмнэлгээс, 0.5 хувь буюу 33.3 мянга тохиолдлыг сувиллаас үзүүлсэн байна.

Нийт санхүүжилт болох 1.421,8 тэрбум төгрөгийн 1.127,5 тэрбум (79.3%) төгрөгийг төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад, 266.7 тэрбум (18.8%) төгрөгийг хувийн хэвшлийн эмнэлэгт, 27.1 тэрбум (1.9%) төгрөгийг сувиллаас үзүүлсэн тусламж, үйлчилгээнд олгосон байна.

*Хүснэгт 17. Тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, тусламж, үйлчилгээний багц, нэр төрлөөр, 2023-2024 он*

| № | Тусламж, үйлчилгээний нэр төрөл | 2023 он | | 2024 он | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тохиолдлын тоо | Санхүүжилт | Тохиолдлын тоо | Санхүүжилт | Тохиолдлын тооны өөрчлөлт | | Санхүүжилтийн өөрчлөлт | |
| | | | | | | Тоогоор | Хувиар | Мөнгөн дүнгээр | Хувиар |
| 1 | **Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ** | **715,084** | **686,016.6** | **722,238** | **796,955.6** | **7,154** | **1.0%** | **110,939** | **16.2%** |
| | 1.1.Мэс засал | 154,577 | 281,336.5 | 171,550 | 331,563.6 | 16,973 | 11.0% | 50,227 | 17.9% |
| | 1.2.Эмийн эмчилгээ | 531,951 | 317,731.3 | 519,283 | 366,326.9 | -12,668 | -2.4% | 48,596 | 15.3% |
| | 1.3.Эрчимт эмчилгээ | 16,114 | 46,200.7 | 17,509 | 62,654.4 | 1,395 | 8.7% | 16,454 | 35.6% |
| | 1.4.Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх хими, туяа эмчилгээ | 12,294 | 27,739.9 | 13,736 | 22,231.6 | 1,442 | 11.7% | -5,508 | -19.9% |
| | 1.5. Эрхтэн шилжүүлэх мэс засал | 148 | 13,008.2 | 160 | 14,178.9 | 12 | 8.1% | 1,171 | 9.0% |
| 2 | **Амбулаторийн тусламж, үйлчилгээ** | **7,327,934** | **226,923.5** | **7,417,854** | **300,086.9** | **89,920** | **1.2%** | **73,163** | **32.2%** |
| | 2.1. Амбулаторийн үзлэг | 3,933,818 | 66,913.2 | 3,633,276 | 83,459.7 | -300,542 | -7.6% | 16,547 | 24.7% |
| | 2.2. Амбулаторийн үзлэг оношилгоо шинжилгээний багц | 2,010,379 | 110,066.3 | 2,151,156 | 142,854.2 | 140,777 | 7.0% | 32,788 | 29.8% |
| | 2.3. Амбулаторийн хяналтын үзлэг | 808,766 | 16,594.9 | 1,046,411 | 38,930.9 | 237,645 | 29.4% | 22,336 | 134.6% |
| | 2.4. Амбулаториор хийгдэх мэс ажилбар | 72,237 | 2,118.2 | 66,167 | 2,598.3 | -6,070 | -8.4% | 480 | 22.7% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.5. Шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээ | 343,167 | 17,845.8 | 368,887 | 23,693.2 | 25,720 | 7.5% | 5,847 | 32.8% |
| | 2.6. Жирэмсний хяналт | 159,567 | 13,385.1 | 151,957 | 8,550.5 | -7,610 | -4.8% | -4,835 | -36.1% |
| 3 | **Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ** | **609,214** | **52,046.1** | **323,533** | **28,126.8** | **-285,681** | **-46.9%** | **-23,919** | **-46.0%** |
| 4 | **Өдрийн эмчилгээ** | **124,373** | **51,001.3** | **156,290** | **56,979.0** | **31,917** | **25.7%** | **5,978** | **11.7%** |
| | 4.1.Өдрийн мэс засал | 12,320 | 3,100.8 | 12,970 | 4,492.6 | 650 | 5.3% | 1,392 | 44.9% |
| | 4.2.Өдрийн эмийн эмчилгээ | 81,168 | 19,334.0 | 112,895 | 30,032.1 | 31,727 | 39.1% | 10,698 | 55.3% |
| | 4.3.Хорт хавдрын туяаны өдрийн эмчилгээ | 21,312 | 7,565.2 | 20,652 | 9,369.3 | -660 | -3.1% | 1,804 | 23.8% |
| | 4.4. Хорт хавдрын химийн өдрийн эмчилгээ | 9,573 | 21,001.4 | 9,773 | 13,084.9 | 200 | 2.1% | -7,917 | -37.7% |
| 5 | **Диализын тусламж, үйлчилгээ** | **221,276** | **31,446.7** | **251,032** | **38,703.0** | **29,756** | **13.4%** | **7,256** | **23.1%** |
| 6 | **Сэргээн засах тусламж, үйлчилгээ** | **298,309** | **52,467.6** | **300,701** | **36,519.3** | **2,392** | **0.8%** | **-15,948** | **-30.4%** |
| | 6.1.Амбулаторийн үзлэг | 186,584 | 3,729.7 | 237,392 | 5,036.5 | 50,808 | 27.2% | 1,307 | 35.0% |
| | 6.2.Өдрийн эмчилгээ | 14,820 | 2,221.1 | 20,561 | 5,865.3 | 5,741 | 38.7% | 3,644 | 164.1% |
| | 6.3.Хэвтүүлэн эмчлэх | 96,905 | 46,516.8 | 42,748 | 25,617.5 | -54,157 | -55.9% | -20,899 | -44.9% |
| 7 | **Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ** | **317,069** | **56,132.8** | **321,516** | **45,688.1** | **4,447** | **1.4%** | **-10,445** | **-18.6%** |
| | 7.1.Амбулаторийн үзлэг | 198,641 | 3,967.5 | 227,848 | 4,884 | 29,207 | 14.7% | 917 | 23.1% |
| | 7.2. Өдрийн эмчилгээ | 18,574 | 2,682.1 | 24,230 | 4,052 | 5,656 | 30.5% | 1,370 | 51.1% |
| | 7.3.Хэвтүүлэн эмчлэх | 99,854 | 49,483.3 | 69,438 | 36,752.8 | -30,416 | -30.5% | -12,735 | -25.7% |
| 8 | **Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ** | **7,963** | **6,994.7** | **8,849** | **8,564.1** | **886** | 11.1% | **1,569** | 22.4% |
| 9 | **Яаралтай тусламж** | **805,826** | **66,331.2** | **920,547** | **56,358.7** | **114,721** | 14.2% | **-9,972** | -15.0% |
| 10 | **Түргэн тусламж** | **522,639** | **27,966.2** | **552,601** | **32,576.8** | **29,962** | 5.7% | **4,611** | 16.5% |
| 11 | **Телемедицийн тусламж, үйлчилгээ** | **719** | **38.8** | **712** | **38.4** | **-7** | -1.0% | **-0.4** | -1.0% |
| 12 | **Сувиллын тусламж, үйлчилгээ** | - | - | **75390** | **21254.2** | **75390** | - | **21254.2** | - |
| | **Нийт дүн** | **10,950,406** | **1,257,365.5** | **11,051,263** | **1,421,850.8** | **100,857** | **0.9%** | **164,485** | **13.1%** |

Тусламж, үйлчилгээний тохиолдлын тоонд эзлэх хувийг харахад хамгийн өндөр нь амбулаторийн ТҮ 67.1 хувийг эзэлж байгаа нь 2024 онд ЭМДҮЗ-ийн 06 дугаар тогтоолоор "Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ"-ний 8 багцыг шинээр үүсгэж, амбулаторийн тусламж, үйлчилгээний тарифыг 20 хувиар нэмэгдүүлсэн бодлогын өөрчлөлттэй холбоотой.

График 12. *Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо,*




*Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ:* Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд 2024 онд 722.2 мянган тохиолдолд 796.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон нь өмнөх оноос тоо хэмжээ 1.0 хувиар, санхүүжилт 16.2 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд нийт санхүүжилтийн 56.0 хувийг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд зарцуулсан байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний 5 төрлөөс өндөр өсөлт гарсан нь эрчимт эмчилгээний санхүүжилт 35.6 хувиар нэмэгдсэн нь эрчимт эмчилгээний тарифын өсөлттэй, хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх хими, туяа эмчилгээний тохиолдлын тоо 11.7 хувиар өссөн ч санхүүжилтийн хэмжээ 19.9 хувиар буурсан нь хими эмчилгээний үйлдлийн зардал болон эмийн зардлыг тус тусад нь санхүүжүүлэхээр бодлогын тохируулга хийж, тарифыг бууруулан санхүүжүүлсэнтэй тус тус холбоотой байна.

*Амбулаторийн тусламж, үйлчилгээ:* 2024 онд 7.4 сая тохиолдолд 300.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх оноос тохиолдлын тоо 1.2 хувиар, санхүүжилт 32.2 хувиар тус тус өссөн байна. ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоолоор амбулаторийн үзлэг, хяналтын багцад өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээг нэгтгэн “Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ”-ний 8 багцыг шинээр үүсгэж, амбулаторийн тусламж, үйлчилгээний тарифыг 20 хувиар нэмэгдүүлсэн нь санхүүжилтийн өсөлтөд нөлөөлж байна.

*Шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээ:* 2024 онд 368.9 мянган тохиолдолд 23.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх оноос тохиолдлын тоо 7.5 хувиар, санхүүжилт 32.8 хувиар тус тус өссөн байна. Энэ нь 2021 онд Монгол Улсын хүн амын дунд хийгдсэн судалгаанаас харахад шүдний цоорлын тархалт 3-6 настай хүүхдүүдийн дунд 88%, жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд 96% байгаа тул хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдийн шүд, амны хөндийн тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, шүдний цоорол өвчнөөс шалтгаалсан өвчлөлийн бууруулах зорилгоор ЭМДҮЗ-ийн 2024 оны 14 дүгээр тогтоолоор даатгалын сангаас санхүүжүүлэх шүдний тохиолдлын тоог нэмэгдүүлж, тарифыг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй холбоотой.

*Жирэмсний хяналтын тусламж, үйлчилгээ:* 2024 онд жирэмсний хяналтын тусламж, үйлчилгээнд 152.0 мянган тохиолдолд 8.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх оноос тохиолдлын тоо 4.8 хувиар, санхүүжилт 36.1 хувиар буурсан. ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоолоор хэвийн жирэмсний хяналтыг анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд үзүүлэхээр, эрсдэлтэй жирэмсний хяналтыг харьяа лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад үзүүлсэн тохиолдлын тоогоор санхүүжүүлэх өөрчлөлтийг хийсэнтэй холбоотой байна.

*Өдрийн эмчилгээ:* 2024 онд давхардсан тоогоор 156.3 мянган тохиолдолд 57.0 тэрбум төгрөгийг олгосон нь өмнөх оноос тохиолдлын тоо 25.7 хувь, санхүүжилтийн хэмжээ 11.7 хувиар өссөн байна.

*Өдрийн эмийн эмчилгээ:* Өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээнээс 2024 онд хамгийн өсөлттэй өдрийн эмийн эмчилгээг өмнөх онтой харьцуулахад тохиолдлын тоо 39.1 хувиар, санхүүжилт 55.3 хувиар өссөн нь хэвтүүлэн эмчлүүлэх шаардлагагүй 6 оношийн хамааралтай бүлгийг хасаж, тухайн бүлгийг өдрийн эмийн эмчилгээ рүү шилжүүлсэн бодлогын тохируулгаас шалтгаалсан байна.

*Хорт хавдрын химийн өдрийн эмчилгээ:* 2024 онд давхардсан тоогоор 9.8 мянган тохиолдолд 13.1 тэрбум төгрөгийг олгосон. Өмнөх тогтоолын хүрээнд хорт хавдрын системийн хими эмчилгээ, химийн бай эмчилгээний тохиолдлыг 1,151.0-4,500.0 мянган төгрөгийн хооронд ялгаатай санхүүжүүлж байсан бөгөөд өртгийн судалгаагаар химийн эмчилгээнд ашиглаж буй 16-20 төрлийн эмийн зардал харилцан адилгүйн улмаас хими эмчилгээний үйлдлийн зардал болон эмийн зардлыг тус тусад нь санхүүжүүлэх хэрэгцээ бий болсон. ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоолоор өдрөөр үзүүлэх хорт хавдрын системийн хими, химийн бай эмчилгээний тарифыг бууруулсантай холбоотой нь өмнөх оноос санхүүжилтийн хэмжээ 37.7 хувиар буурсан байна.

*Өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээ:* 2024 онд өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээнд 323.5 мянган тохиолдолд 28.1 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг олгосон байна.

Гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд шилжиж, MRI, CT гэсэн өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээг ЭМДС-аас санхүүжүүлж эхэлснээр нэг талаас иргэн даатгуулагчид эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс бүрэн хамгаалагдсан сайн талтай боловч нөгөө талаас эрүүл мэндийн байгууллагууд шаардлагагүй оношилгоо, шинжилгээ хийж, даатгалын сангийн санхүүжилт эрс нэмэгдсэн. Тухайлбал: MRI шинжилгээний гүйцэтгэл 2021 онд 14,296 байсан бол 2023 онд 44,816 болж 3,1 дахин, КТ шинжилгээний гүйцэтгэл 2021 онд 35,266 байсан бол 2023 онд 97,753 болж 2,7 дахин, дурангийн оношилгооны гүйцэтгэл 2021 онд 26,079 байсан бол 2023 онд 54,326 болж 2 дахин тус тус нэмэгдсэн сөрөг үр дагавар гарсан.

Шаардлагагүй өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээг хязгаарлах, амбулаторийн тусламж, үйлчилгээг цогц, хүртээмжтэй, чанартай үзүүлэх зорилгоор ЭМДҮЗ-ийн тогтоолоор өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээг амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, хяналтын багцад нэгтгэсэнтэй холбоотой өндөр

өртөгтэй оношилгоо шинжилгээний тохиолдлын тоо өмнөх оноос 46.9 хувиар, санхүүжилтийн хэмжээ 46.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

*Диализийн тусламж, үйлчилгээ:* 2024 онд 251.0 мянган тохиолдолд 38.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх оноос тохиолдлын тоо 13.4 хувиар, санхүүжилт 23.1 хувиар өссөн байна.

*Сэргээн засахын тусламж, үйлчилгээ:* 2024 онд онд сэргээн засах тусламж, үйлчилгээний 300.7 мянган тохиолдолд 36.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх оноос тохиолдлын тоо 0.8 хувиар, өсөж, санхүүжилтийн хэмжээ 30.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

- ✓ *Сэргээн засахын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ:* 2024 онд сэргээн засахын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний 42.7 мянган тохиолдолд 25.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх оноос тохиолдлын тоо 55.9 хувиар, санхүүжилтийн хэмжээ 44.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тогтоолын өөрчлөлтөөр сэргээн засах тусламж үйлчилгээг дахин багцалж, сувилалд эмчлэгдэх боломжтой архаг өвчнийг сувиллын тусламж, үйлчилгээний багц руу шилжүүлж, мөн хурц өвчний дараа үед үзүүлэх сэргээн засах тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн багцыг шинэчилж, эмчилгээний үр дүнг үнэлж, санхүүжилтийг үргэлжлүүлдэг тогтолцоо руу шилжүүлж, тарифыг бууруулснаас шалтгаалан санхүүжилтийн хэмжээ буурсан байна.
- ✓ *Сэргээн засахын өдрийн эмчилгээ:* 2024 онд онд сэргээн засахын өдрийн эмчилгээний 20.6 мянган тохиолдолд 5.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх оноос тохиолдлын тоо 38.7 хувиар, санхүүжилтийн хэмжээ 164.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь тогтоолын өөрчлөлтөөр сэргээн засахын өдрийн эмчилгээний 3 төрлийн шинэ багц /үе мөч, тулгуур эрхтний эмгэг, тархи мэдрэлийн эмгэг, хорт хавдрын дараах сэргээн засах/-ыг үүсгэж, өмнө мөрдөгдөж байсан тарифыг дунджаар 2.2 дахин нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

*Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ:* 2024 онд 321.5 мянган тохиолдолд 45.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх оноос тохиолдлын тоо 1.4 хувиар нэмэгдэж, санхүүжилт нь 18.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тогтоолын өөрчлөлтөөр сувиллаас үзүүлэх уламжлалтын тусламж, үйлчилгээний багцыг шинээр үүсгэсэнтэй холбоотой уламжлалтын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний санхүүжилт 25.7 хувиар буурсан байна.

*Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ:* 2024 онд хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд 8.8 мянган даатгуулагч хамрагдаж, 8.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон нь өмнөх онтой харьцуулахад тохиолдлын тоо 11.1 хувиар, санхүүжилт 22.4 хувиар нэмэгдсэн байна. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд 97.0 хувь, хувийн хэвшлийн эмнэлэг 3.0 хувь байна.

*Яаралтай тусламж*: 2024 онд яаралтай тусламж, үйлчилгээнд 920.5 мянган даатгуулагч хамрагдаж, 56.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон нь өмнөх онтой харьцуулахад тохиолдлын тоо 14.2 хувиар өссөн ч мөнгөн дүн 15.0 хувиар буурсан байна.

Яаралтай тусламж, үйлчилгээг гүйцэтгэлээр санхүүжүүлж эхэлснээр нэг талаас иргэн даатгуулагчид эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс бүрэн хамгаалагдсан, тусламж, үйлчилгээг цаг алдалгүй авах сайн талтай боловч нөгөө талаас эрүүл мэндийн байгууллагууд бага зардлаар яаралтай тусламж, үйлчилгээг үзүүлсэн ч тоо хэмжээний хэт өсөлтийн улмаас даатгалын сангийн санхүүжилт эрс нэмэгдсэн. Өртгийн судалгаанд үндэслэн яаралтай тусламж, үйлчилгээний зардлаас өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээг салгаж, эрэмбэлэн ангилалтыг оновчтой болгосноор яаралтай тусламжийн санхүүжилт буурсан.

*Сувиллын тусламж, үйлчилгээ:* 2024 онд сувиллын тусламж, үйлчилгээнд 75.4 мянган даатгуулагч хамрагдаж, 21.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон нь тогтоолын өөрчлөлтөөр сувиллын тусламж, үйлчилгээ, сувиллаас үзүүлэх уламжлалтын болон сэргээн засах тусламж, үйлчилгээ гэсэн 3 багцыг шинээр үүсгэсэнтэй холбоотой байна.

### 7.2. Анхан шатлалын /ӨСТЭМТ/ тусламж, үйлчилгээ

ЭМДҮЗ-ийн 2024 оны 05 дугаар тогтоолоор сум, тосгоны эрүүл мэндийн төвийн газарзүйн индексийг нэмэгдүүлэх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд ажиллаж буй эмч, ажилчдын үндсэн цалин, орон нутгийн нэмэгдлийг олгох бодлогыг баримталж, тусламж, үйлчилгээний жагсаалтыг өргөжүүлж, тарифыг нэмэгдүүлсэн.

Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 дүгээр сарын 01-ээс нэмэгдүүлсэн цалингийн өсөлт, орон нутгийн нэмэгдэл, анхан шатны тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлсэнтэй холбоотой 2024 онд анхан шатны эрүүл мэндийн байгууллагад нийтдээ 487.4 тэрбум төгрөг зарцуулсан нь өмнөх онтой харьцуулахад 35.7 хувиар буюу 128.1 тэрбум төгрөгөөр, нэг иргэнээр тооцсон санхүүжилт өмнөх оноос 25.7 хувь буюу 70.6 тэрбум төгрөгөөр, 4 төрлийн тусламж, үйлчилгээ 133.8 хувь буюу 57.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Хүснэгт 18. ӨСТЭМТ-өөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, 2022-2024 он*

| № | Анхан шатны тусламж, үйлчилгээ | 2022 он | 2023 он | 2024 он | Өөрчлөлт /2024-2023/ | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Тоогоор | Хувиар |
| 1 | **Сум, тосгоны ЭМТ-өөс үзүүлэх ТҮ** | **84,561.5** | **50,290.4** | **87,417.3** | **37,126.9** | **73.8%** |
| 1.1 | Хэвтүүлэн эмчлэх | 75,469.9 | 30,073.4 | 48,572.6 | 18,499.2 | 61.5% |
| 1.2 | Түргэн тусламж | 6,771.1 | 11,231.7 | 21,465.1 | 10,233.4 | 91.1% |
| 1.3 | Яаралтай тусламж | 1,320.9 | 5,109.8 | 10,336.2 | 5,226.4 | 102.3% |
| 1.4 | Шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээ | 999.6 | 3,875.5 | 7,043.4 | 3,167.9 | 81.7% |
| 2 | **Өрх, сум тосгоны ЭМТ-с үзүүлэх 4 төрлийн ТҮ** | **14,329.8** | **34,083.7** | **54,526.2** | **20,442.5** | **60.0%** |
| 2.1 | Сэргээн засах | 3,685.1 | 9,489.8 | 14,040.5 | 4,550.7 | 48.0% |
| 2.2 | Өдрийн эмчилгээ | 5,189.3 | 11,343.3 | 17,506.9 | 6,163.6 | 54.3% |
| 2.3 | Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ | 2,134.9 | 3,762.5 | 6,023.1 | 2,260.6 | 60.1% |
| 2.4 | Оношилгоо, шинжилгээ | 3,320.3 | 9,488.0 | 16,955.7 | 7,467.7 | 78.7% |
| 3 | **Нэг иргэнээр тооцсон ТҮ-ний санхүүжилт** | **197,122.7** | **274,924.4** | **345,502.5** | **70,578.1** | **25.7%** |
| **Нийт анхан шатны тусламж, үйлчилгээний зардал** | | **296,014.2** | **359,298.6** | **487,446.0** | **128,147.4** | **35.7%** |

Анхан шатны нэг иргэнээр тооцсон багц тусламж, үйлчилгээний 2024 оны гүйцэтгэлээс харахад тусламж, үйлчилгээний тэргүүлэх чиглэл болох халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг, өвчнөөс урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээний гүйцэтгэл жил бүр сайжирч байгаа хэдий ч эмчлэхэд илүү анхаарч эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх, эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, тусламж, үйлчилгээ хангалтгүй байна.

Нэг иргэнээр тооцсон багц тусламж, үйлчилгээний 2024 оны гүйцэтгэлийг авч үзвэл 20.5%-ийг эмчлэхэд, 31.7%-ийг Халдварт бус өвчний эрт илрүүлэгт, 33.0%-ийг эрүүл мэндийг хянахад, 6.7%-ийг эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөхөд, 4.1%-ийг өвчнөөс урьдчилан сэргийлэхэд, 0.001%-ийг эрүүл мэндийн дэмжихэд, 3.3%-ийг халдварт өвчний эрт илрүүлэгт, 0.7%-ийг сэргээн засах тусламж, үйлчилгээнд, 0.02%-ийг хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд тус тус хийсэн байна.

ӨСТЭМТ-өөс үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээний 1,564.9 мянган тохиолдолд 52.2 тэрбум төгрөгийн, сум, тосгоны ЭМТ-өөс үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээнд 91.4 мянган тохиолдолд 2.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

*Хүснэгт 19. ӨСТЭМТ-өөс үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээний 2024 оны тохиолдлын тоо, олгохоор тооцсон санхүүжилт, сая төгрөгөөр*

| № | Тусламж, үйлчилгээний төрөл | ӨЭМТ | | СТЭМТ | |
|---|---|---|---|---|---|
| | | Тохиолдлын тоо | Санхүүжилт | Тохиолдлын тоо | Санхүүжилт |
| 1 | Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ | 62,420 | 5,712.20 | 3,727 | 310.9 |
| 2 | Оношилгоо, шинжилгээ | 1,189,229 | 15,950.00 | 76,774 | 1,005.70 |
| 3 | Өдрийн эмчилгээ | 144,076 | 16,959.50 | 4,578 | 547.4 |
| 4 | Сэргээн засах тусламж, үйлчилгээ | 169,224 | 13,537.30 | 6,290 | 503.2 |
| | **Нийт дүн** | **1,564,949** | **52,159.00** | **91,369** | **2,367.30** |

СТЭМТ-өөс үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээний тохиолдлын тоог харьцуулан үзэхэд хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ 27.4 хувийг эзэлж байгаа ч бусад тусламж, үйлчилгээний эзлэх хувь ойролцоо байна. Харин санхүүжилтийг харьцуулахад хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ 55.4 хувь буюу хамгийн өндөр хувийг, шүдний тусламж, үйлчилгээ 8.1 хувийг эзэлж байгаа нь хамгийн бага хувьтай байна.

*Хүснэгт 20. СТЭМТ-өөс үзүүлэх 4 төрлийн тусламж үйлчилгээний 2024 оны тохиолдлын тоо, олгохоор тооцсон санхүүжилт, сая төгрөгөөр*

| № | Тусламж, үйлчилгээний төрөл | Тохиолдлын тоо | Хувиар | Санхүүжилт | Хувиар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ | 122,624 | 27.8% | 48,572.6 | 55.6% |
| 2 | Түргэн тусламж | 106,575 | 24.2% | 21,465.1 | 24.6% |
| 3 | Яаралтай тусламж, үйлчилгээ | 105,499 | 23.9% | 10,336.2 | 11.8% |
| 4 | Шүд амны хөндий | 106,287 | 24.1% | 7,043.4 | 8.1% |
| | **Нийт** | **440,985** | **100.0%** | **87,417.2** | **100%** |

### 7.3. Эмийн үнийн хөнгөлөлт

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 11 дүгээр тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хувь хэмжээ"-г мөрдөж байна.

Хүн амын дунд зонхилон тохиолддог, нас баралтын хувь өндөртэй зүрх судас, чихрийн шижин, уушгины эмгэг болон хавдрын үеийн эм зүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор "Новартис эмийн хүртээмжийг сайжруулах" хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлэхээр Швейцарын Холбооны Улсын "Новартис Глобал" эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу 15 ерөнхий нэршлийн 24 тун, хэмжээ бүхий эмийг 100 хувь Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөхөөр тусгасан.

2024 онд 1513 эмийн сангаар дамжуулан эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг 815.7 мянган даатгуулагчид үзүүлж, даатгалын сангаас 134.6 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 139.5 мянган хүнээр нэмэгдэж, санхүүжилт 21.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт 21. Эмийн үнийн хөнгөлөлтийн төсөв, гүйцэтгэл, хамралт 2022-2024 он, сая төгрөгөөр*

| Төсөв, гүйцэтгэл | 2022 он | 2023 он | 2024 он | Өөрчлөлт /2024-2023/ | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Тоогоор | Хувиар |
| Төсөв /сая.төг/ | 67,306.2 | 89,982.5 | 137,801.6 | 47,819.1 | 53.1% |
| Гүйцэтгэл /сая.төг/ | 84,251.7 | 99,506.5 | 134,549.6 | 35,043.1 | 35.2% |
| Хамрагдсан хүний тоо | 572,568 | 645,360 | 815,732 | 139,467 | 21.6% |

2024 онд нийслэлийн эмийн сангуудад нийт санхүүжилтийн 61.0 хувь буюу 81 тэрбум төгрөг, орон нутгийн эмийн сангуудад 39.0 хувь буюу 53.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Даатгуулагчийн төрлөөр нь авч үзэхэд 2024 онд тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд хөнгөлөлттэй эмийн нийт санхүүжилтийн 68.2 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр байна.

График 13. *Эмийн үнийн хөнгөлөлтийн зардлын төсөв, гүйцэтгэл, хамралт, 2022-2024 он, сая төгрөгөөр*




### 7.4. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1-т "Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ" гэсэн зорилтын хүрээнд даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулж байна.

Судалгаагаар 2023 онд хэрэглээний үнийн индекс 14.8 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний зардал 10.6 хувь өссөн, инфляцын түвшин болон бусад үнийн өсөлттэй уялдуулан ЭМДҮЗ-ийн 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 10 дугаар тогтоолоор "Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, төлбөрийг нь санхүүжүүлэх журам, багц, төлбөрийн хэмжээ"-г шинэчлэн баталж, төлбөрийн хэмжээг дунджаар 40 хувиар нэмэгдүүлэн 2024 оны эхнээс мөрдсөн.

Хүснэгт 22. *Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний төлбөрийн хэмжээ*

| Насны багц | ЭМДҮЗ-ийн 2022 оны 06-р тогтоолын төлбөрийн хэмжээ | ЭМДҮЗ-ийн 2023 оны 10-р тогтоолын төлбөрийн хэмжээ | Өсөлтийн хувь | Өсөлт мөнгөн дүнгээр |
|---|---|---|---|---|
| 18-30 насны багц 1 | 60,000 | 90,000 | 50% | 30,000 |
| 31-45 насны багц 2 | 130,000 | 190,000 | 46% | 60,000 |
| 46-60 насны багц 3 | 150,000 | 200,000 | 33% | 50,000 |
| 61- дээш насны багц 4 | 140,000 | 180,000 | 29% | 40,000 |
| **Дундаж өсөлтийн хувь** | | | **40%** | **45,000** |

2024 онд улсын хэмжээнд 219.2 мянган хүн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагдаж 31.6 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулсан байна.

Хүснэгт 23. *Урьдчилсан сэргийлэх үзлэгийн хамралт, тохиолдол, санхүүжилт, насны багцаар 2023-2024 он*

| Багц | 2023 он | | 2024 он | | | | Өөрчлөлт /2024-2023/ | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тохиол-дол | Санхүү-жилт /сая төг/ | Тохиолдол | | Санхүүжилт | | Тохиол-дол | Санхүү-жилт /сая төг/ |
| | | | Тоо | Хувь | Мөнгөн дүн | Хувь | | |
| 18-30 насны багц | 60,656 | 3,625.9 | 37,468 | 17.1% | 3,104.4 | 9.8% | -23,188 | -521.5 |
| 31-45 насны багц | 130,514 | 16,067.7 | 89,200 | 40.7% | 13,105.0 | 41.4% | -41,314 | -2,962.7 |
| 46-60 насны багц | 113,701 | 16,044.3 | 62,880 | 28.7% | 10,865.3 | 34.4% | -50,821 | -5,179.0 |
| 61+дээш насны багц | 52,516 | 6,905.0 | 29,658 | 13.5% | 4,551.7 | 14.4% | -22,858 | -2,353.3 |
| **Нийт** | **357,387** | **42,642.9** | **219,206** | **100.0%** | **31,626.3** | **100.0%** | **-138,181** | **-11,016.6** |

Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралтын тохиолдлын тоо өмнөх оноос 138,2 мянган тохиолдлоор, санхүүжилт 11.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд 31-45 насны даатгуулагчид хамгийн өндөр хамрагдсан нь нийт тохиолдлын 40.7 хувь, санхүүжилтийн 41.4 хувийг тус тус эзэлж байна. Харин урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд 18-30 насны залуучууд хамгийн бага хамрагдсан нь нийт тохиолдлын 17.1 хувь, санхүүжилтийн 9.8 хувийг тус тус эзэлж байна.

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийг 81 эрүүл мэндийн байгууллага үзүүлснээс өмчийн хэлбэрээр авч үзвэл 47 (58.0%) нь төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага, 34 (42.0%) нь хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байна.

## НАЙМ. ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, САНАЛ

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2024 онд 1,964.8 тэрбум төгрөгөөр батлагдсанаас 1,921.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөний биелэлт 97.8 хувьтай байна. Батлагдсан төсвийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан нийт 109.3 тэрбум төгрөгийг нэмэлт эх үүсвэрээр төвлөрүүлж, нийт орлого 2,031.2 тэрбум төгрөг болсон байна.

2. Ковидын цар тахал, эрүүл мэндийн салбарын цалингийн өсөлт, эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний суурь тариф болон тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчийн тохиолдлын тооны өсөлт зэргээс шалтгаалан эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага батлагдсан төсвөөс жил бүр хэтэрснээс сангийн тэнцэл алдагдаж, 2024 онд эрүүл мэндийн байгууллагуудад 316.8 тэрбум төгрөгийн өглөгтэй гарсан байна;

3. Засгийн газрын нийт зардалд эрүүл мэндийн зардлын эзлэх хувь 2023 онд 9.1 хувь байсан бол 2024 онд 8.4 хувь болж буурсан нь Тогтвортой хөгжлийн бодлогын зорилтоос 3.6 пунктээр доогуур байна.

4. Тайлант онд эрүүл мэндийн улсын зардалд эзлэх эрүүл мэндийн даатгалын сангийн зардал 75.7 хувь, эрүүл мэндийн улсын зардалд эзлэх улсын төсвийн шилжүүлгийн хэмжээ 23 хувьтай байна;

5. Эрүүл мэндийн зардалд анхан шатны тусламж, үйлчилгээний зардлын эзлэх хувь 2021 онд хамгийн өндөр буюу 23 хувь байсан бол 2022 оноос жил бүр 1.0 хувиар буурч 2024 онд 21.0 хувьтай гарсан байна;

6. Эрүүл мэндийн даатгалд нийт хүн амын 93.4 хувийг хамруулсан нь өмнөх оноос 0.9 хувиар нэмэгдсэн нь "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин"-ийн 2.1.2-т заасан зорилтот түвшин (92.7%)-ээс 0.7 хувиар давсан ч Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын шалгуур үзүүлэлт"-ийн зорилтот түвшин (94.0%)-ээс 0.6 хувиар бага байна;

7. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон

тооны бус техникийн хороог байгуулсан нь хараат бус, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн нотолгоонд суурилсан шийдвэр гаргах бодит нөхцөл бүрдсэн байна;

8. Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 01 дүгээр тогтоолоор баталсан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн шинэчилсэн дүрэмд ажлын албаны албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэлийг УИХ-аас томилогддог ажлын албаны ангилал, зэрэглэлтэй дүйцүүлэн тогтоохоор шийдвэрлэснээр ЭМДҮЗ-ийн үйл ажиллагааны жил бүрийн тайланд дурдагддаг зөрчил арилж, ажлын албаны албан хаагчдын нийгмийн баталгаа хангагдсан байна;

9. E-Mongolia болон “ebarimt” аппликейшн ашиглан нийт 321.3 мянган хүн даатгуулагч эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлж, 29.9 тэрбум төгрөгийг даатгалын санд төвлөрүүлсэн нь нийт бүрдүүлсэн бусад орлогын 87.4 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оноос даатгуулагчийн тоо 46.1 мянгаар, бусад орлогод эзлэх хувь 14.2 хувиар тус тус өссөн нь эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн үйлчилгээг иргэдэд ойртуулан, цахим хэлбэрээр, хялбар болгосонтой холбоотой эерэг үр дүн гарсан байна.

**Цаашид анхаарах асуудал, санал**

1. Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэд нь нийт даатгуулагчийн 70.0 хувийг эзэлж, нийт шимтгэлийн орлогын 27.7 хувийг бүрдүүлж, сангаас зарцуулсан зардлын 77.2 хувийг эзэлж байгаа тул төрөөс эрүүл мэндийн даатгалыг хариуцах иргэдийн шимтгэлийн хувь, хэмжээг нэмэгдүүлэх;

2. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн шимтгэлийн хувь хэмжээг татвар төлж буй орлогын хэмжээтэй уялдуулан тогтоох замаар эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх;

3. Нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнээр даатгуулагчийн амь насанд гэнэтийн эрсдэл учруулж болзошгүй төрөх, жирэмсэн, нярайн тусламж, үйлчилгээ, халдварт өвчин, хавдар, түргэн тусламж, яаралтай тусламж зэрэг нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэгч эрүүл мэндийн байгууллагын тоо, түүнд зарцуулах зардлын хэмжээг тогтмол нэмэгдүүлснээр 2024 онд нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний зардал 84.2 хувьд хүрч, 2020 оноос 2 дахин өссөн тул төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх;

4. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн орлогын 10 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулна” гэж заасан бөгөөд 2024 онд эрсдэлийн санг 53.6 тэрбум төгрөгөөр байгуулсан нь нь эрүүл мэндийн даатгалын сангийн нийт орлогын 2.7 хувийг, шимтгэлийн орлогын 4.4 хувийг эзэлж байгааг нэмэгдүүлэх;

5. Эрүүл мэндэд хор хөнөөлтэй бүтээгдэхүүн болох согтууруулах ундаа, тамхины онцгой татвараас эрүүл мэндийн даатгалын сан руу оруулах замаар сангийн орлогыг өсгөх хууль эрх зүйн орчныг судалж шийдвэрлэх

6. Засгийн газрын нийт зардалд эрүүл мэндийн зардлын эзлэх хувь 2023 онд 9.1 хувь байсан бол 2024 онд 8.4 хувь болж буурсан нь Тогтвортой хөгжлийн бодлогын зорилтоос 3.6 пунктээр доогуур байгаа тул Засгийн газрын нийт зардалд эзлэх эрүүл мэндийн улсын салбарын зардлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна;

---oOo--

Хавсралт. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны ээлжит хуралдааны ирц

/Төлөөлөл бүрээр/

| № | ЭМДҮЗ-ийн бүрэлдэхүүн | 2024 он | | |
|---|---|---|---|---|
| | | **Хуралдсан тоо** | **Оролцсон тоо** | **Дундаж хувь** |
| **Нэг.Засгийн газрын төлөөлөл, дундаж ирц** | | **8** | **17** | **70.9%** |
| 1 | **Эрүүл мэндийн сайд, ЭМДҮЗ-ийн дарга** | **8** | **8** | **100.0%** |
| | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд | 8 | 8 | **100.0%** |
| 3 | Сангийн сайд | 8 | 1 | **12.5%** |
| **Хоёр. Даатгуулагчийн төлөөлөл, дундаж ирц** | | **8** | **20** | **83.3%** |
| 4 | Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхийлөгч | 8 | 4 | **50.0%** |
| 5 | Монголын төмөр замчдын үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга | 8 | 8 | **100.0%** |
| 6 | ШУА-ийн харъяа Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан | 8 | 8 | **100.0%** |
| **Гурав. Ажил олгогчийн төлөөлөл, дундаж ирц** | | **8** | **23** | **95.8%** |
| 7 | Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбооны ерөнхийлөгч | 8 | 8 | **100.0%** |
| 8 | Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооны УЗ-ийн гишүүн | 8 | 8 | **100.0%** |
| 9 | Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимын гишүүн | 8 | 7 | **87.5%** |
| **Нийт ирц** | | **8** | **60** | **83.3%** |

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА**

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

# 2024 ОНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2025 он

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Журмын 5 дугаар хавсралт

## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2024.04.30 Улаанбаатар хот

| д/д | Зүйл, заалтын дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Шийдвэрийн агуулга | Хэрэгжилтийн явц | Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах санал) | Тасарсан болон удааширч байгаа шалтгаан | Хэрэгжил-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | | | |
| **Нэг. Монгол Улсын хууль** | | | | | | | |
| 1. | 8.1 | Эрүүл мэндийн даатгалын тухай хууль | Энэ хуулийн 6.1-д заасан даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл /цаашид "шимтгэл" гэх/-ийн хувь хэмжээг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар дараах байдлаар тогтооно:<br>8.1.2.энэ хуулийн 6.1.2, 6.1.3, 6.1.5, 6.1.9, 6.1.12-д заасан даатгуулагчийн сард төлөх шимтгэлийн хувь хэмжээг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1-ээс доошгүй хувиар жил бүр; | Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар Монгол Улсын бүх иргэн эрүүл мэндийн даатгалд албан журмаар даатгуулах үүрэгтэй бөгөөд даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар жил бүр тогтоодог. Үндэсний зөвлөл нь шимтгэлийн хувь хэмжээг тогтоох саналаа жил бүр Монгол Улсын Засгийн газарт хүргүүлж ажиллаж байна. Тухайлбал, 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 101 тоот, 2021 оны 12 дугаар сарын 22-ны 94 тоот, 2022 оны 12 дугаар сарын 09-ний 87 тоот, 2023 оны 11 дүгээр сарын 28-ны 110 тоот, 2024 оны 11 сарын 13-ны өдрийн 137 тоот албан бичгээр тус тус санал өгсөн. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 2. | 9.4 | | Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, халдварт өвчний эсрэг дархлаажуулалтад түүний нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн тогтоосон товлосон хугацаанд хамруулан, эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь санхүүжүүлэх бөгөөд холбогдох журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Үндэсний зөвлөл батална. | -Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны "Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай" 06 тогтоолоор "Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, төлбөрийг санхүүжүүлэх журам", "Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн багц, төлбөрийн хэмжээ"-г батлуулан мөрдөж, 2023 оны 04 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж, 2023 оны 10 дугаар тогтоолоор "Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, төлбөрийг санхүүжүүлэх журам", "Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн багц, төлбөрийн хэмжээ"-г шинэчлэн баталсан.<br>- 2024 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд 18-аас дээш насны хүн амын 35.4 хувь буюу 219,206 | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгууллагын саналыг үндэслэн Үндэсний зөвлөл батална. | хүн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагдаж 31.6 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулсан байна.<br>- Хамралтыг насны ангиллаар авч үзвэл 18-30 насны залуучуудын 30.5 хувь, 31-45 насны хүн амын 42.1 хувь, 46-60 насны 33.5 хувь, 61-ээс дээш насны хүн амын 30.6 хувь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан дүнтэй байна.<br>- Эрт илрүүлгийн үзлэгийг Улаанбаатар хот болон орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа нийт 81 эрүүл мэндийн байгууллага зохион байгуулан ажиллаж байна. Үүнээс 51 хувь буюу 41 эмнэлэг нийслэл хотод, 49 хувь буюу 40 эмнэлэг хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. | | | |
| 3. | 10.3 | | Гэрээний үлгэрчилсэн загварыг Үндэсний зөвлөл батална. | ЭМДҮЗ-ийн 2021 оны 13 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний үлгэрчилсэн загвар”, “Анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний үлгэрчилсэн загвар”, “Даатгуулагчид эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээний үлгэрчилсэн загвар”-ыг тус тус баталсан.<br>2023 оны 07 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний үлгэрчилсэн загвар”-т нэмэлт, өөрчлөлт оруулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 4. | 11.2 | | Энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын эрүүл мэндийн даатгалын сангаас болон даатгуулагчаас төлөх төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журмыг эрүүл мэндийн даатгалын байгууллага болон санхүү, төсвийн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг тус тус үндэслэн Үндэсний зөвлөл тогтооно. | -ЭМДҮЗ-ийн 2019 оны 28, 2021 оны 03, 2022 оны 01, 2023 оны 08, 2024 оны 06 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, өртгийн жин, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журмыг /лавлагаа шат/ тус тус шинэчлэн баталсан.<br>Дээрх тогтоолуудыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн санд тухай бүр бүртгүүлэн, одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 2024 оны 06 дугаар тогтоолыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн санд 6801 дугаарт бүртгүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>ЭМДҮЗ-ийн 06-р тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж, ЭМДҮЗ-ийн 2024.10.03-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн санд 6801 дугаарт нэмэлт хөдөлгөөн хийлгэж, тогтоолыг ЭМДЕГ-т хүргүүлэн | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажиллаж байна.<br>-ЭМДҮЗ-ийн 2019 оны 23, 2021 оны 04, 2022 оны 05, 2023 оны 06, 2024 оны 05 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журмыг /анхан шат/ тус тус шинэчлэн баталсан.<br>Дээрх тогтоолуудыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн санд тухай бүр бүртгүүлэн, одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 2024 оны 05 дугаар тогтоолыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн санд 6800 дугаарт бүртгүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | | | |
| 5. | 14.8.1. | | Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, дүрмийг батлах; | ЭМДҮЗ-ийн 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 03 дугаар тогтоолоор анх Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, дүрмийг баталсан байна.<br>Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 176 дугаар тогтоолоор агентлагийн орон тооны дээд хязгаарыг 170 байхаар шинэчлэн тогтоосон. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл Эрүүл м эндийн даатгалын тухай хуульд заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын бие даасан тогтолцоог бүрдүүлэх, бодлогын болон үйл ажиллагааны зөв менежмент, маркетингийг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч, 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын бүтцийг шинэчлэн баталсан. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 6. | 14.8.2. | | Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хөрөнгийг тооцох, төрийн санд байршуулах, зарцуулах журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах; | Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хөрөнгийг тооцох, төрийн санд байршуулах, зарцуулах журмыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудын саналыг үндэслэн 2021 оны 09 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 7. | 14.8.3. | | Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг төрийн санд байршуулах, зарцуулах журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн | Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг төрийн санд байршуулах, зарцуулах журмыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудын саналыг үндэслэн 2021 оны 09 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах; | | | | |
| 8. | 14.8.4. | | Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар холбогдох байгууллагаас ирүүлсэн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, санал боловсруулах, эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх; | Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас ирүүлсэн асуудлыг тухай бүр хэлэлцэн, холбогдох шийдвэрүүдийг гаргаж ирсэн. Үүнд:<br>- Капитал банкнаас авах авлагыг барагдуулах чиглэлээр 4 удаагийн шийдвэр;<br>- ЭМД-ын сангийн арилжааны банкнуудад байршиж байсан мөнгөн хөрөнгийг төрийн санд шилжүүлэх тухай;<br>- Олон улсын байгууллагуудын боловсруулсан эмнэлзүйн удирдамжуудыг нэгтгэсэн энэхүү цахим платформыг Монгол Улсын Засгийн газраас манай улсын бүх шатны эмч мэргэжилтнүүд ашиглахыг зорилт болгосны дагуу хэрэгжилтийг хангах талаар шийдвэр гаргав.<br>- Томуу, томуу төст өвчний үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зарим зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай;<br>-ЭМДҮЗ-ийн гишүүд, ажлын алба нь нийслэл дэх 20 эрүүл мэндийн байгууллага, орон нутгийн 42 нийт 62 эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, тогтоолын хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийж, Үндэсний зөвлөлд танилцуулсан. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 9. | 14.8.5. | | Эрүүл мэндийн даатгалтай холбоотой асуудлаар мэргэжлийн нийгэмлэг, холбоо, шинжээч, даатгуулагч, хамтрагч талуудыг оролцуулсан байнгын болон түр ажиллагаатай ажлын хэсэг байгуулах, ажлын үр дүнг хэлэлцэх; | ЭМДҮЗ-ийн гишүүдээр ахлуулсан ажлын хэсэг 2024 онд орон нутгийн 24, нийслэлийн 22, нийт 46 эрүүл мэндийн байгууллагад албан томилолтоор ажиллаж, нийт 1000 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй уулзаж, ЭМДҮЗ-ийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэж, ЭМДҮЗ-ийн баталсан тогтоол шийдвэрийн хэрэгжилттэй газар дээр нь танилцаж, тулгамдсан асуудлыг сонсож, харилцан санал солилцож ажилласан. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 10. | 14.8.6. | | Эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар өөрийн бүрэн эрхийн хүрээнд холбогдох журам, тогтоол, зөвлөмж гаргах; | ЭМДҮЗ нь өөрийн бүрэн эрх, үүргийн хүрээнд байгуулагдсанаас хойш 2017 онд 3, 2018 онд 26, 2019 онд 30, 2020 онд 22, 2021 онд 13, 2022 онд 18, 2023 онд 12, 2024 онд 16 тогтоол, нийт 140 тогтоол батлан гаргасан байна. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11. | 14.8.7 | | Даатгалын гэрээний дагуу худалдан авсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг олон улсын эмнэлзүйн удирдамжийг ашиглан батлах; | -2020 онд УИХ-аас Эрүүл мэндийн салбарын тухай багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотой "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын журам"-ыг ЭМДҮЗ-ийн 2022 оны 07 дугаар тогтоолоор анх удаа баталсан.<br>-2022 оны 07 дугаар тогтоолыг ХЗДХЯ хянан үзээд 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 2/3853 дугаартай "Дүгнэлт хүргүүлэх тухай" албан бичгийг ирүүлсний дагуу төслийг дахин боловсруулж, ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолоор батлуулан, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн санд 5929 дугаарт бүртгүүлэн одоог хүртэл мөрдөж байна. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 12. | 14.9.1. | | Эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлын төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг актуар тооцоололд үндэслэн боловсруулах, батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих; | ЭМДҮЗ-ийн 2019 оны 30 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны орлого 506.5 тэрбум төгрөг, зарлага 494.5 тэрбум төгрөгийн төсвийн нарийвчилсан хуваарилалт;<br>2021 оны 01 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуулиар батлагдсан орлого 951.3 тэрбум төгрөг, зарлага 1,210.7 тэрбум төгрөгийн төсвийн нарийвчилсан хуваарилалт;<br>2021 оны 08 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 1450.7 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагыг 1481.4 тэрбум төгрөгөөр батлагдсаныг хуваарилалт тус тус хийсэн.<br>ЭМДҮЗ-ийн 2022 оны 17 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулиар /тодотгол/ эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 1481.3 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагыг 1481.3 тэрбум төгрөгөөр батлагдсаныг хуваарилалт;<br>ЭМДҮЗ-ийн 2023 оны 11 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулиар /тодотгол/ эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 1603.4 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 1603.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн тул төсвийн нарийвчилсан хуваарийг шинэчлэн баталсан.<br>2024 оны 01 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 1964.7 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зарлагыг 1933.6 тэрбум төгрөгөөр батлагдсаныг хуваарилалт тус тус хийсэн.<br>2024 оны 10 дугаар тогтоолоор эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын нарийвчилсан хуваарьт өөрчлөлт оруулсан.<br>2024 оны 8 сард 2025 оны төсвийн төсөл 2026-2027 оны төсвийн төсөөллийг боловсруулсан холбогдох яамдад хүргүүлсэн. | | | |
| 13. | 14.9.2. | | Эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, үйл ажиллагааны болон удирдлагын зардлыг хянах, үнэлэлт, дүгнэлт өгөх; | ЭМДС-ийн санхүүгийн сарын мэдээ, улирлын тайланг ЭМДҮЗ-ийн гишүүдэд тухай бүр, НББХ-нд улирал бүр хүргүүлсэн. - ЭМДҮЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон тус тайланд хийсэн системчилсэн үнэлгээний тайлан, хууль тогтоомжийн биелэлтийг УИХ-ын НББХ-нд 04 дүгээр сарын 30-ны өдрийн 51 дугаартай албан тоотоор хүргүүлсэн. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 14. | 14.9.7. | | Эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх; | Эрүүл мэндийн даатгалын холбогдолтой асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж, 2024 онд 11 өргөдөл, гомдлыг бүртгэн авч, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлэж, ажиллалаа. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 15. | 14.9.8. | | Энэ хуулийн 9.1-д заасан Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орох тусламж, үйлчилгээний жагсаалтыг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах; | ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалтыг шинэчлэн баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5037 дугаарт бүртгүүлсэн.<br>2022 оны 01 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалтыг шинэчлэн баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5715 дугаарт бүртгүүлсэн.<br>2023 оны 08 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалтыг шинэчлэн баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6301 дугаарт бүртгүүлсэн.<br>2024 оны 06 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хамааралтай бүлгийн жагсаалтыг шинэчлэн баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6801 дугаарт бүртгүүлсэн.<br>2024 оны 06-р тогтоолд ЭМДҮЗ-ийн 14 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6801 дугаарт хөдөлгөөн хийлгэж бүртгүүлсэн. | | | |
| 16. | 14.9.10. | | Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох; | 2020 оны 11, 13 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг шинэчлэн тогтоосон.<br>2022 оны 11 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг шинэчлэн баталж, одоог хүртэл мөрдөж байна.<br>2018 оноос хойш эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг нийт 5 удаа шинэчлэн тогтоосон байна. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 17. | 14.9.11 | | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг батлах | ЭМДҮЗ-ийн 2018 оны 09 дүгээр тогтоолоор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн баталж, 2022 оны 02 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5716 дугаарт бүртгүүлсэн. 2023 оны 05 дугаар тогтоол, 2024 оны 02 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулан, хөдөлгөөн хийлгэсэн. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 18. | 14.9.12 | | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт зөвлөмж гаргах орон тооны бус техникийн хороог байгуулах, ажиллах журмыг батлах | ЭМДҮЗ-ийн 2024 оны 03 дугаар тогтоолоор "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус техникийн хорооны бүрэлдэхүүн, ажиллах журам"-ыг шинэчлэн баталсан. Уг журмын дагуу техникийн хорооны орон тооны бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 2024 оны 08 дугаар тогтоолоор "Техникийн хорооны бүрэлдэхүүн"-ийг баталсан. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 19. | 14.10. | | Үндэсний зөвлөл нь улирал хоёроос доошгүй удаа, шаардлагатай тохиолдолд дарга буюу гишүүдийн олонхын саналаар хуралдах бөгөөд хурлыг бүх талын оролцоог хангасан саналын эрхтэй гишүүдийн гуравны хоёроос доошгүйн ирцтэйгээр хуралдуулна. | ЭМДҮЗ-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.10-т "Үндэсний зөвлөл нь улирал хоёроос доошгүй удаа, шаардлагатай тохиолдолд дарга буюу гишүүдийн олонхын саналаар хуралдах бөгөөд хурлыг бүх талын оролцоог хангасан саналын эрхтэй гишүүдийн гуравны хоёроос доошгүйн ирцтэйгээр хуралдуулна." гэж зааснаар 2024 онд 8 удаагийн ээлжит хуралдааныг танхимаар зохион байгуулж, хуралдааны ирц дунджаар 83.2 хувь байна. ЭМДҮЗ нь 2024 онд 8 удаа, нийт 23 цаг буюу 1384 минут хуралдаж, 25 асуудал хэлэлцэж, 16 тогтоол батлан гаргасан байна. Одоогийн байдлаар ЭМДҮЗ-ийн 23 тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 20. | 14.11. | | Дараах үндэслэлээр Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг чөлөөлнө: | Улсын Их Хурлын 2017 оны 40 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийг байгуулж, бүрэлдэхүүнийг баталсан.<br>Засгийн газрыг төлөөлсөн гишүүд Засгийн газрын бүрэлдэхүүнд өөрчлөлт орох тухай бүр нэрээр солигдож ирснийг өөрчлөн албан тушаалаар ЭМДҮЗ-ийн бүрэлдэхүүнд орж ажилладаг болгон өөрчилсөн.<br>Өмнөх гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан УИХ-ын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 27 дугаар тогтоолоор шинэ бүрэлдэхүүнийг баталсан.<br>Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр даатгуулагчийн олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагыг төлөөлсөн Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны ерөнхийлөгч, ЭМДҮЗ-ийн гишүүн С.Эрдэнэбат нь Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдож, ЭМДҮЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ НББХ-нд гаргасан тул ЭМДҮЗ нь 2024 оны сүүлийн хагас жилд 8 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явууллаа. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 21. | 14.12. | | Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг Үндэсний зөвлөлийн гуравны хоёроос доошгүй гишүүний бичгээр гаргасан, тодорхой шалтгаан бүхий хүсэлтийг үндэслэн Улсын Их Хурал үүрэгт ажлаас нь чөлөөлж болно. | | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 74. | 2.5 . | | Тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд эмийн үнийн хөнгөлөлтийн санхүүжилтийг тэгш, хүртээмжтэй хуваарилж, төсвийн үр ашгийг дээшлүүлэх хяналтын тогтолцоог бүрдүүлж, тухай бүр тайлагнаж, арга хэмжээ авч ажиллах | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 11 дүгээр тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хувь хэмжээ"-г мөрдөж байна.<br><br>Даатгалын гэрээ бүхий эмийн сангууд нь өөрсдийн ашигладаг цахим программаар дамжуулан Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын хөгжүүлсэн цахим системд байршуулсан хөнгөлөлттэй эмийн жагсаалтаас эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, даатгалын сангаас хөнгөлөх хувь хэмжээ, эмийг хэрэглэх үеийн онош, эм бичих эмчийн төрөл зэрэг мэдээллийг авч, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлтийн тусламж, үйлчилгээг тасралтгүй үзүүлж байна.<br><br>Даатгуулагч иргэд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ бүхий эмийн сангаар үйлчлүүлэх үед эмийн сангийн зүгээс зөрчил гаргасан тохиолдолд 1800-1363 лавлах утсанд мэдэгдэх зурагт хуудсыг хүргүүлж, үйлчлүүлэгчийн нүдэнд ил харагдах газар байршуулан ажилласан.<br>2024 онд 1513 эмийн сангаар дамжуулан эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг 815.7 мянган даатгуулагчид үзүүлж, даатгалын сангаас 134.6 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 139.5 мянган хүнээр нэмэгдэж, санхүүжилт 21.6 хувиар өссөн байна.<br>2024 онд нийслэлийн эмийн сангуудад нийт санхүүжилтийн 61.0 хувь буюу 81 тэрбум төгрөг, орон нутгийн эмийн сангуудад 39.0 хувь буюу 53.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Даатгуулагчийн төрлөөр нь авч үзэхэд 2024 онд тэттэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд хөнгөлөлттэй эмийн нийт санхүүжилтийн 68.2 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр байна. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 75. | 2.6 | | Тогтоолын хавсралт дахь эмийн жагсаалтад * тэмдэглэгээгээр тэмдэглэсэн эмүүдийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс жагсаалтаас хасаж, Эрүүл | -Тогтоолын хавсралт дахь эмийн жагсаалтад * тэмдэглэгээгээр тэмдэглэсэн эмүүдийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс жагсаалтаас хасаж, Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлэхийг зогсоох зохицуулалтыг програм хангамжийн түвшинд хийлээ. Тус эмүүдийн оронд Новартис эмийн | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлэхийг зогсоох арга хэмжээ авч ажиллах | хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд 15 ерөнхий нэршлийн 24 түн, хэмжээ бүхий эмийг 100 хувийн хөнгөлөлттэй үнээр даатгуулагчдад олгож байна. | | | |
| 76. | 2.7 | | Төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор эмчлэх өвчний жагсаалтад тусгагдсан тархины саажилт, уналт таталттай хүүхдийн уналт, таталтын эсрэг эмийн үнийн хөнгөлөлтийг хүүхдэд /0-19 нас хүртэлх/ Эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувиар хөнгөлөлт олгосугай. | -Төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор эмчлэх өвчний жагсаалтад тусгагдсан тархины саажилт, уналт таталттай хүүхдийн уналт, таталтын эсрэг эмийн үнийн хөнгөлөлтийг хүүхдэд /0-19 нас хүртэлх/ Эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувиар хөнгөлөлт олгох зохицуулалтыг Эрүүл мэндийн даатгалын цахим системд хийсэн.<br>2024 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд 0-19 хүртэлх насны 5700 гаруй хүүхэд сар бүр уналт таталтын эсрэг эмийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувийн хөнгөлөлттэй үнээр авч байна. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 77. | 2.1 | Журам шинэчлэн батлах тухай. 2022-08-11. №12 | Чанар, төлбөрийн хяналтын журамд заасан нэхэмжлэлийн хяналт хийх, газар дээр нь очиж хяналт шалгалт хийх, эмнэл зүйн аудит, чанарын үнэлгээ хийх журам боловсруулж, хэрэгжүүлэх; | ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/60 дугаар тушаалаар "Эрүүл мэндийн байгууллага дээр очиж хийх хяналт, шалгалтын журам", 2023 оны "Журам батлах тухай" А/140 дүгээр тушаалаар "Эмнэл зүйн аудит хийх журам", 2022 оны А/139 дүгээр тушаалаар "Нэхэмжлэлийг хянах журам"- ыг боловсруулан батлуулсан бөгөөд тус тус мөрдөн ажиллаж байна. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 78. | 2.2 | | Олон улсын эмнэл зүйн удирдамжийг ашиглан тогтоосон шалгуурт хамаарах эзлэх хувийн жингийн хэмжээг тогтоох; | -ЭМДЕГ-ын даргын А\139 дүгээр тушаалд дэлгэрэнгүй шалгуур тус бүрийн эзлэх хувийн жин нь тухайн ОХБ-ийн үндсэн шалгуурт хамаарах эмнэл зүйн ач холбогдлыг нь харгалзан тогтоосон. Бүх шалгуурыг хангах бол 1, аль нэг шалгуурыг хангах бол 2, нэг төрлийн үндсэн шалгуурын 50 хувийг хангах бол 3 гэсэн кодоор цахим системд тооцоолол хийхээр тохируулга хийгдлээ. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 79. | 2.3 | | Чанар, төлбөрийн хяналт хийхэд шаардлагатай програм хангамжийн хөгжүүлэлтийг хийж, хэвийн ажиллагааг хангаж ажиллах; | -ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоол батлагдсантай холбоотойгоор нэхэмжлэлийн хяналтын шалгуурыг тохируулах, холбох ажлыг хийж 30,000 мөр шалгуурын файлыг шинэчлэн туршилт хийн, холбосон. Лавлагаа шатлалын 312 ЭМБ-ын 32 тусламж үйлчилгээний 11383853 гүйцэтгэлээс 19801 гүйцэтгэлийг түүвэрлэсэн. Үнээс цахим хасалт 828424, эмчийн хасагдал-495706, зардлыг байцаагчийн хасагдал-1081726, шинжээч эмчийн хасагдал 89041, эх олонлогийн хасагдлаар-130665 бодолтуудыг тооцоолсон байна. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 80. | 4 | | Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийн хяналтын мэдээлэлд 2024 оны эхний 10 сарын | | | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ажлын албанд даалгасугай. | байдлаар судалгааг хийхэд эхний 10 сарын байдлаар төв орон нутгийн 300 эрүүл мэндийн байгууллагаас 10.1 сая тохиолдлын 1.3 их наяд төгрөгийн нэхэмжлэл ирүүлснийг хянасан байна. | | | 100 хувь |
| 81. | 11.2.2 | Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2023.06.28 №05 | Хэрэв тухайн нэмэлт өөрчлөлтийн дагуу шинээр "зайлшгүй болон нэмэлт шаардлага" бий болгох тохиолдолд нийт гэрээ байгуулагдсан эрүүл мэндийн байгууллагуудад нэмэлт сонгон шалгаруулалт зарлана. Нэмэлт сонгон шалгаруулалтыг зөвхөн хоёрдугаар үе шатнаас зохион байгуулна. Хүртээмж нь хангагдаагүй тусламж үйлчилгээг бүс нутгаар нь судалгаа хийж 2023 онд сонгон шалгаруулалтыг 2 дугаар шатнаас нь эхлэн зохион байгуулсан. | Хүртээмж нь хангагдаагүй тусламж үйлчилгээг бүс нутгаар нь судалгаа хийж 2023 онд сонгон шалгаруулалтыг 2 дугаар шатнаас нь эхлэн зохион байгуулсан. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 82. | 11.3.1 | | Нэн тэргүүнд нэмэлт сонгон шалгаруулалтыг гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагуудын дунд хоёрдугаар үе шатнаас зохион байгуулж, тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авна. | Дээрх сонгон шалгаруулалтад 75 эрүүл мэндийн байгууллага, 1548 ОХБ-т тусгай шаардлагын материал ирүүлсний дагуу үнэлгээ хийгээд 60 эрүүл мэндийн байгууллага тэнцэж, 59 эрүүл мэндийн байгууллага нь сонгон шалгаруулалтад тэнцсэн ОХБээр нэмэлт гэрээ байгуулсан. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 83. | 11.3.2 | | Хэрэв журмын 11.3.1-т заасан нэмэлт сонгон шалгаруулалтаар уг тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллага сонгогдоогүй тохиолдолд тухайн тусламж, үйлчилгээний хүрээнд нэгдсэн сонгон шалгаруулалтыг тухайн бүс нутагт дахин зохион | 2024 онд Хүртээмж нь хангагдаагүй тусламж, үйлчилгээгээр тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээгүй лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудыг нэмэлт сонгон шалгаруулалтаар зарласан уг тусламж үйлчилгээг үзүүлэх ЭМБ сонгогдоогүй тохиолдол гараагүй. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгуулна. | | | | |
| 84. | 3.1 | Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2023.06.28 №07 | ЭМДЕГ-т: Даатгуулагчид урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавх бүхий эрүүл мэндийн байгууллагыг сонгож, даатгалын гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих; | -Урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн багцаар тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын нэрсийг Эрүүл мэндийн яамнаас ирүүлсний дагуу нийслэл болон орон нутгийн нэр бүхий нийт 119 эрүүл мэндийн байгууллагын гэрээний хавсралтад урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн шинжилгээг гэрээний хавсралтад нэмж тусгасан. Гэрээнд тусгагдсаны дагуу уг тусламж үйлчилгээг үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагын гэрээний хэрэгжилтийг жилд 1 удаа дүгнэн ажиллаж байна. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 85. | 3.2 | | Иргэд, даатгуулагч, эрүүл мэндийн байгууллагуудад мэдээлэл хүргэх, сурталчилах ажлыг шуурхай зохион байгуулах; | -Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолыг танилцуулах сургалтыг цахим хэлбэрээр 02 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулж, сургалтад нийт 49 эрүүл мэндийн байгууллагын 130 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдлаа. Тогтоолд орсон гол өөрчлөлтүүд болох багцийн төлбөрийн хэмжээний өсөлт, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/379 дугаар тушаалаар баталсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний товлол, давтамжид орсон өөрчлөлт, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхэд баримтлах журам болон холбогдох бусад зохицуулалтын талаар сургалтыг зохион байгуулсан. Иргэд, даатгуулагчид мэдээлэл хүргэх чиглэлээр сурталчилгааны хамгийн сүүлийн үеийн платформ, техник технологийг ашиглан 1 цахим ном, 21 зурган постер, 1 видео контент, 2 цаг үе үйл явдлын мэдээг тус тус боловсруулж түгээж ажилласан нь 204746 хандалт авч, 1024 удаа хуваалцсан байна. Өнгөрсөн хугацаанд 1800-1363 лавлах утаснаас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хэрхэн хамрагдах, насны багц, гэрээт эрүүл мэндийн байгууллагууд зэрэг зөвлөгөө, мэдээллийг 60 иргэнд өгч ажилласан. АШУҮИС-ийн оюутан залууст Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, шимтгэлийн мэдээлэл, ач холбогдол, урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн талаар танилцуулга, мэдээлэл өгөх сургалтыг зохион байгуулсан. Олон улсын хөдөлмөрчдийн эрхийн өдрийг тохиолдуулан МҮЭХ-оос зохион байгуулсан "Нээлттэй хаалганы өдөрлөг"-т "ЭМДЕГ-ын албан хаагчид оролцож, 80 | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | гаруй иргэдэд эрт илрүүлгийн ач холбогдол, насны бацгын талаарх мэдээллийг хүргэж ажилласан. | | | |
| 86. | 3.3 | Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай 2023.11.27 №10 | Эрүүл мэндийн даатгалын цахим программ хангамжинд холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулах; | ЭМДҮЗ-ийн 2023 оны 10 дугаар тогтоолын холбогдох нэмэлт, өөрчлөлтийг эрүүл мэндийн даатгалын цахим системд нэвтрүүлэх цахим хөгжүүлэлтийн бодлогын даалгавар боловсруулан, уг хөгжүүлэлтийг цахим системд бүрэн хийж дуусгасан. 2024 оны 02 дугаар сараас эхлэн энэхүү тогтоолын дагуу нэхэмжлэлийг хүлээн авч, хяналт хийсний үр дүнд санхүүжилтийг олгон ажиллаж байна. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн мэдээлэл HIEP цахим системээр дамжин даатгалын цахим систем хүлээн авдаг тул ЭМХТ-ийн HIEP системийг хөгжүүлэх бодлогын даалгаврыг боловсруулж, 2024 оны 01/127 дугаарт албан бичгээр ЭМЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлж ажилласан. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 87. | 3.4 | | Эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлж буй урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг холбогдох эрх зүйн хүрээнд худалдан авах, нэхэмжлэлийг бодит цагийн горимоор хүлээн авч, чанарын болон төлбөрийн хяналтыг үндэслэн санхүүжилтийг олгох; | -Эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлж буй урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнийн нэхэмжлэлийг бодит цагийн горимоор хүлээн авч 1-4 сарын байдлаар даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулсан тусламж, үйлчилгээнд нийслэлийн 126 эрүүл мэндийн байгууллага 51.0 мянган хүний 7,959.8 сая төгрөгийн, орон нутгийн 147 эрүүл мэндийн байгууллага 36.9 мянган хүний 5,698.5 сая төгрөгийн, улсын хэмжээнд давхардсан тоогоор 273 эрүүл мэндийн байгууллага 87.9 мянган хүний 13,658.3 сая төгрөгийн нэхэмжлэл ирүүлсэн.<br>-Нэхэмжлэлийн цахим хяналтаар нийслэлд 6.4 мянган хүний 1,393.0 сая төгрөгийн, орон нутагт 4.5 мянган хүний 1,013.0 сая төгрөгийн, улсын хэмжээнд нийт 10.9 мянган хүний 2,406.0 сая төгрөгийн хасагдлыг хийж, нэхэмжилсэн дүнгээс тус тус хасаж тооцсон. Нэхэмжлэлийн хяналтын үр дүнд дээрх хасагдсан дүнг нэхэмжилсэн дүнгээс хасаж тооцон, нийслэлийн 126 байгууллагын 44.6 мянган хүнд 6,566.8 сая төгрөг, орон нутгийн 147 байгууллагын 32.4 мянган хүнд 4,685.5 сая төгрөг, улсын хэмжээнд 273 байгууллагын 77.0 мянган хүнд 11,252.2 сая төгрөгийн зардлыг олгохоор тооцсон.<br>-Цахим системийн хасалт нь дараах шалтгаантай байна. Үүнд: ЭМД-ын шимтгэл төлөөгүй, регистр алдаатай, багцад хийгдэх оношилгоо, шинжилгээ, үзлэг дутуу, хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээтэй | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | давхацсан, тогтоолд заасан хугацаанд хийж хэрэгжүүлээгүй. | | | |
| 88. | 3.5 | | Даатгуулагчид урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр үнэлгээ хийж, үр дүнг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд танилцуулах; | -2024 оны жилийн эцсийн байдлаар эрүүл мэндийн даатгалын сангаас 31.6 тэрбум төгрөг зарцуулсан байна. Эрт илрүүлгийн үзлэгийн 31-45 насны багцад хамгийн их буюу 89,2 мянган хүн хамрагдсан нь нийт хамралтын 40.7 хувь, хамгийн бага нь 61-ээс дээш насны багцад 29,6 мянга буюу нийт хамрагдалтын 13.5 хувийг эзэлж байна. Нийт олгосон санхүүжилтийн 41.4 хувийг 31-45 нас, 34.4 хувийг 46-60 нас, 14.4 хувийг 61-ээс дээш нас, 9.8 хувийг 18-30 насны эрт илрүүлгийн багцад олгосон байна.<br>-Улсын хэмжээнд нийт 80 эрүүл мэндийн байгууллагын 49.0% (40) нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулдаг, үлдсэн 51.0% (41) нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулдаг эрүүл мэндийн байгууллагууд байна. Эдгээр 81 эрүүл мэндийн байгууллагыг өмчийн хэлбэрийн төрлөөр авч үзвэл 47 (58.0%) нь төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага, 34 (42.0%) нь хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байна.<br>-Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн хамралтын хамгийн их буюу 28,8 хувийг тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд, 24,2 хувийг Цалин, түүнтэй адилтгах орлогоос шимтгэл төлдөг иргэд, 16,8 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэд, 12,1 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, эзэлж байна гэсэн тооцоо судалгаа гарсан. | | | Тодорхой үр дүнд хүрсэн 90 хувь |
| 89. | 2.1.1 | "2024 оны төсвийн хуваарийг батлах тухай" 2024.01.08 №01 | 2024 оны төсвийн орлогын хуваарийн дагуу орлого бүрдүүлэлт, мөнгөн урсгалын тасралтгүй байдлыг хангаж, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагч болон бусад даатгуулагчдын шимтгэлийг цуглуулах зорилгоор холбогдох программ хангамжийг хөгжүүлэх. | -2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэлийн орлого 135 тэрбум төгрөг бүрдүүлэхээс 135 тэрбум төгрөг бүрдүүлж 100 хувийн гүйцэтгэлтэй, төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилтийн орлого 314 тэрбум төгрөг бүрдүүлэхээс 354 тэрбум төгрөг бүрдүүлж 112 хувийн гүйцэтгэлтэй, бусад даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлого 14.4 тэрбум төгрөг бүрдүүлэхээс 16.6 тэрбум төгрөг бүрдүүлж 115 хувийн гүйцэтгэлтэй, ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлого 357.9 тэрбум төгрөг бүрдүүлэхээс 288.2 тэрбум төгрөг бүрдүүлж 80 хувийн гүйцэтгэлтэй мөн бусад 1.2 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлэн нийт 821.4 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэхээс 795.2 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 96 хувийн гүйцэтгэлтэй байна. E-Mongolia, И-баримт хөтөлбөрөөр дамжуулан E-Mongolia академи УҮГ-тай хамтран ажиллаж E-Mongolia, И баримтаар ЭМД-ын шимтгэл төлөлтийг төлөх үйлчилгээг нэвтрүүлсэн. Үүний үр дүнд хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагч болон бусад даатгуулагчдын хувьд эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг e-barimt болон e-mongolia цахим системээр шимтгэл төлөлтийн мэдээллийг шалгаж, шимтгэл төлөлтийг хийж байна. | | | |
| 90. | 2.1.2 | | Эрүүл мэндийн байгууллага бүрээр тусламж, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээг оновчтой тогтоож, эрүүл мэндийн байгууллагуудтай хэлэлцээр хийж, 2024 оны төсвийн зарлагын хуваарийн дагуу “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ”-нд тусгасан чанартай тусламж үйлчилгээг худалдан авах. | -2024 оны төсвийн зарлагын хуваарийн дагуу 312 лавлагаа шатлал, 552 анхан шатны эрүүл мэндийн байгууллага бүртэй гэрээний хэлцэл хийж тусламж үйлчилгээний нэр төрөл бүрээр тоо хэмжээг тогтоон, уг хэлцлийн дагуу тусламж үйлчилгээг худалдан авах нэмэлт гэрээ байгуулсан. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 91. | 2.1.3 | | 2023 оны төсвийн жилд үүссэн эрүүл мэндийн байгууллагад олгох өр төлбөрийг 2024 оны эхний улиралд багтаан бууруулах арга хэмжээ авч ажиллах. | Эрүүл мэндийн даатгалын сангаас 2023 онд эрүүл мэндийн даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагуудад нийт 1602.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд тусламж, үйлчилгээний зардалд 217.9 тэрбум төгрөгийн өглөгтэй гарсан. Эрүүл мэндийн даатгалын сангаас 2024 онд урьд оны өглөг болох 150.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг батлагдсан төсвийн хүрээнд олгосон.<br>2024 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд урьд оны 67.0 тэрбум төгрөг, тайлант оны 229.0 тэрбум төгрөг нийт-296.0 тэрбум төгрөгийн өглөгтэй гарсан бөгөөд өмнөх оноос өглөг 78.1 сая төгрөгөөр өссөн байна. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 92. | 2 | Техникийн хорооны бүрэлдэхүүн, журам шинэчлэн | Орон тооны бус техникийн хорооны гишүүдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, шалгуур хангасан нэр дэвшигчдийг 2024 оны 03 | ЭМДҮЗ-ийн 2024 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Техникийн хорооны бүрэлдэхүүн, ажиллах журам”-ын “3.1. Ажлын алба нь орон тооны бус техникийн хорооны гишүүнийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг нээлттэй зарлаж, зохион байгуулна.” гэж заасны дагуу | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | батлах тухай 2024.03.01 №03 | дугаар сарын 22-ны өдрийн дотор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулах | 03 дугаар сарын 04-18-ны өдрүүдэд Техникийн хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, сонгон шалгаруулалтын зарыг https://emd.gov.mn/news/509 вэб сайт болон ЭМДҮЗ, ЭМДЕГ-ын фэйсбүүк хуудсанд нээлттэй байршуулж, нэр дэвшигчдийн материалыг emduzalba@gmail.com хаягаар 03 сарын 18-ны өдрийн 17 цаг хүртэл цахимаар болон цаасаар хүлээн авсан. Сонгон шалгаруулалтад 10 нэр дэвшигч материал ирүүлснээс 1 хүн магистрын зэрэггүй шалтгаанаар, нэр бүхий 6 нэр дэвшигч журмын "2.4.8.... даатгалын гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагад ажилладаггүй байх;" шаардлагыг хангаагүй тул ЭМДҮЗ-ийн 03 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит 03 дугаар хуралдаанд танилцуулсан. ЭМДҮЗ-ийн 2024 оны 03 дугаар тогтоолоор баталсан "Техникийн хорооны бүрэлдэхүүн, ажиллах журам"-ын хавсралтад нэмэлт, өөрчлөлтийг оруулан ЭМДҮЗ-ийн 2024 оны 07 дугаар тогтоолоор албажуулсан. | | | |
| 93. | 3 | | Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албанд даалгах; | Уг журмын "3.2. Техникийн хорооны нарийн бичгийн даргыг ажлын албаны дарга томилж, чөлөөлнө." гэж заасан тул уг заалтын дагуу Ажлын албаны даргын 2024 оны А/07 дугаар тушаалаар Техникийн хорооны нарийн бичгийн даргыг томилсон. Ажлын албанаас Техникийн хорооны гишүүдийн анхдугаар хурлыг 05 дугаар сарын 17-ны өдөр гишүүдийн 100 хувийн ирцтэйгээр зохион байгуулсан. Тус хорооны хурлаар гишүүдийн 100 хувийн саналаар Техникийн хорооны даргаар Ө.Анирыг томилж, гишүүдэд техникийн хорооны чиг үүрэг, гишүүдийн эрх, үүрэг болон ЭМДҮЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны товч тайланг танилцуулж, техникийн хорооны үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөнд гишүүдийн саналыг тусган, гишүүдийн 100 хувийн саналаар төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 94. | 2.2.1 | Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай 2024.03.29 №05 | **Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт:** Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлж буй тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд тавигдах чанар, төлбөрийн хяналтын тшалгуурыг шинэчлэгдсэн | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх Сэргээн засах тусламж, үйлчилгээ (Архаг үеийн сэргээн засах тусламж, үйлчилгээ)-ний 1, Өдрийн эмчилгээ (Өдрөөр үзүүлэх эмийн эмчилгээ, Хүүхдийн амьсгалын замын үрэвсэлт өвчин /J02-04, J09-J11, J12-J18, J20, J31/), хүүхдийн халдварт бус суулгалт /K52,9/)-ний 14, Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ (Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ /Z51.5/, эмнэлэгт ирэх боломжгүй | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | багц, журмуудтай уялдуулан бий болгож нэхэмжлэлийн хяналтыг хийх; | ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд болон хүүхдэд зайлшгүй үзүүлэх тусламж, үйлчилгээ, Бусад гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ)-ний 3, оношилгоо шинжилгээний 1, нийт 4 төрлийн тусламж, үйлчилгээний 19 шалгуурыг ЭМДҮЗ-ийн 2024 оны "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 05 дугаар тогтоолын дагуу дахин шинэчлэн боловсруулж олон улсын байгууллагын зөвлөхөөр хянуулан эцэслэж байна. Үүний дараа Эрүүл мэндийн яаманд хүргүүлэн санал авч, ирүүлсэн саналыг тусган Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд хүргүүлэхээр төлөвлөж байна. | | | |
| 95. | 2.2.2 | | Эрүүл мэндийн даатгалын цахим програм хангамжид холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулах; | -ЭМДҮЗ-ийн 2024 оны 05 дугаар тогтоолын холбогдох нэмэлт, өөрчлөлтийг эрүүл мэндийн даатгалын цахим системд нэвтрүүлэх цахим хөгжүүлэлтийн бодлогын даалгавар боловсруулан, уг хөгжүүлэлтийг цахим системд бүрэн хийж дуусгасан. Тухайлбал: 2024 оны 05 дугаар тогтоолын хүрээнд нийт 39 өөрчлөлт болон шинэ хөгжүүлэлт шалгуур, цахим системийн тооцооллыг хийж нэвтрүүлсэн. Мөн тогтоолын шинэчлэлийн дагуу анхан шатны 331 сум, тосгоны ЭМТ-ийн гэрээний мэдээлэл, амбулаторийн хяналтын тусламж, үйлчилгээг нэхэмжлэх боломжтойгоор оруулсан. Систем хөгжүүлэлтийн явцын хяналтыг тогтмол хийж ажиллаж байна. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 96. | 2.2.3 | | Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийн тоо мэдээлэл болон нэхэмжлэлийг бодит цагийн горимоор хүлээн авч холбогдох хууль, журмын дагуу тусламж, үйлчилгээг худалдан авах; | -Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг бодит цагийн горимоор хүлээн авч, нэхэмжлэлийн хяналтыг хийж байна. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 97. | 2.2.4 | | Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад тогтоол, журмын талаар сургалт зохион байгуулах; | -ЭМДҮЗ-ийн 2024 оны 05 дугаар тогтоолын танилцуулга сургалтыг цахим хэлбэрээр 5 удаа зохион байгуулж, нийт 320 гаруй сумын эрүүл мэндийн төв, 200 гаруй өрхийн эрүүл мэндийн төвийн 1385 эмч, мэргэжилтнүүд хамрагдсан байна. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 98. | 2.2.5 | | Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвтэй байгуулах гэрээний шалгуур үзүүлэлтэд | -ЭМДҮЗ-ийн 2024 оны Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай 05 дугаар тогтоолоор батлагдсан эрүүл мэндийн тусламж | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулах, хэрэгжүүлэх; | үйлчилгээ авах боломжгүй, хэвтрийн болон хүнд өвчтэй хөгжлийн бэрхшээлтэй болон хөнгөвчлөх тусламж үйлчилгээ шаардлагатай бусад эмзэг бүлгийн даатгуулагчдад гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээний хувь болон 0-18 насны хүүхдийн амьсгалын замын үрэвсэлт өвчин, халдварт бус суулгалт өвчнөөр өдрийн эмчилгээ авснаас хойш 7 хоногийн дотор хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ авсан хүүхдийн хувийг тооцох 2 шалгуур үзүүлэлтийг боловсруулсан. 2021 оны 13 дугаар тогтоолд 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 07 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан. | | | |
| 99. | 2.2.6 | | Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн лабораторийн тусламж, үйлчилгээг үзүүлэх чадамж, хүртээмжид үнэлгээ хийж, үнэлгээний үр дүнгээр оношилгоо, шинжилгээний тусламж, үйлчилгээг үзүүлэх гэрээг байгуулах; | -ЭМДҮЗ-ийн 2024 оны 05 дугаар тогтоолын хүрээнд Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн лабораторийн тусламж, үйлчилгээг үзүүлэх чадамж, хүртээмжид үнэлгээ хийж, үнэлгээний үр дүнгээр оношилгоо, шинжилгээний тусламж, үйлчилгээг үзүүлэх гэрээг байгуулсан. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 100. | 5 | | Тогтоолын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллахыг ажлын албанд даалгах. | Тогтоолын хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийгдсэн. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 101. | 2.2.1 | Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай 2024.03.29 №06 | ЭМДЕГ-т: Эрүүл мэндийн даатгалын цахим (HICS) систем болон холбогдох программ хангамжид шаардлагатай нэмэлт, өөрчлөлт хийх; | -ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоолын холбогдох нэмэлт, өөрчлөлтийг эрүүл мэндийн даатгалын цахим системд нэвтрүүлэх цахим хөгжүүлэлтийн бодлогын даалгавар боловсруулан, уг хөгжүүлэлтийг цахим системд бүрэн хийж дуусгасан. Тухайлбал: -ЭМДҮЗ-н 2024 оны 03 дугаар сарын 28 ны өдрийн 06 дугаар тогтоолын хүрээнд тогтоол дээр тусгагдсан өөрчлөлтүүдийг бодлогын даалгаврын дагуу сервис талд хийгдэх нийт 44 өөрчлөлт болон шинэ хөгжүүлэлт шалгуур, цахим системийн тооцооллыг хийж нэвтрүүлсэн. Лавлагаа шатлалын 322 ЭМБ-ын гэрээний мэдээллийг шинэчлэгдсэн тогтоолын ОХБ-ийн кодоор шинэчлэн 27076 мөр гэрээний мэдээлэл, 706 ОХБ-ийн 287008 мөр оношийн мэдээллийг ЭМД-ын цахим системд шинэчлэн оруулсан. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 102. | 2.2.2 | | Эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан | -Эрүүл мэндийн даатгалын 2024 оны төсвийн зарлага 1,933.1 тэрбум төгрөгөөр батлагдсан. Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас 2024 оны батлагдсан төсөвт | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах, сангийн тэнцлийг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | багтаан (өмнөх оны өглөг ороогүй) худалдан авах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тоо, хэмжээг 2023 оны гүйцэтгэлийн тоо, хэмжээнээс нэмэгдүүлэлгүй, зарим тусламж, үйлчилгээний тоо хэмжээг бууруулан, даатгалын гэрээ байгуулан ажиллаж байна. Ийнхүү Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны батлагдсан төсөвт багтаан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээний хэлцлийг хийж нэмэлт гэрээ байгуулан ажиллаж байна. | | | . |
| 103. | 2.2.3 | | Эрүүл мэндийн байгууллага холбогдох журамд заасныг зөрчиж, даатгуулагчаас нэмэлт төлбөр авсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар эрүүл мэндийн даатгалын байгууллага, эрүүл мэндийн байгууллага хооронд байгуулах гэрээнд тодорхой тусгах; | Эрүүл мэндийн байгууллага холбогдох журамд заасныг зөрчиж, даатгуулагчаас нэмэлт төлбөр авсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар эрүүл мэндийн даатгалын байгууллага, эрүүл мэндийн байгууллага хооронд байгуулах гэрээнд тусгасан болно. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 104. | 2.2.4 | | Оношийн хамааралтай бүлгийн жагсаалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулсан гэрээг шинэчлэх, тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан эрүүл мэндийн байгууллагуудаас худалдан авах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тоо хэмжээг тогтоох, гэрээнд тусгах; | Оношийн хамааралтай бүлгийн жагсаалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулсан гэрээг шинэчлэн байгуулах ажлыг 2024 оны батлагдсан төсвийн хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудаас худалдан авах нэмэлт гэрээ хийгдэж байна. уг гэрээнд тусламж үйлчилгээ бүрээр тоо хэмжээг тогтоосон болно. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 105. | 2.2.5 | | Тогтоолын төслийн 2.2 дахь заалтын 4-т Оношийн хамааралтай бүлгийн жагсаалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулсан гэрээг 2024 оны 04 дүгээр сард багтаан | -Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 08 дугаар тогтоолын хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулсан гэрээний хавсралтад тусгагдсан ОХБ-үүдийн 2024 онд гэрээнд тусгагдсан тоо хэмжээг цахим системд шинэчилсэн. ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоолын хүрээнд оношийн хамааралтай бүлгүүдийг хөрвүүлэн Мэдээллийн технологийн хэлтэс цахим системд өөрчлөлт оруулсан. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шинэчлэх, тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан эрүүл мэндийн байгууллагуудаас худалдан авах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тоо хэмжээг тогтоох, гэрээнд тусгах гэж өөрчлөх; | 2024 оны 02 дугаар сард 289, 09 дүгээр сард 58, 10 дугаар сард 56, давхардсан тоогоор нийт 403 эрүүл мэндийн байгууллагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдах, худалдан авах гэрээний хүрээнд тоо хэмжээг тогтоон, гэрээ байгуулсан. | | | |
| 106. | 2.2.6 | | Энэхүү тогтоолын хавсралтаар баталсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний жагсаалт, төлбөрийн хэмжээ, холбогдох журмын талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлэх, даатгуулагчийг болон эрүүл мэндийн байгууллагыг мэдээллээр хангах; | -ЭМДҮЗ-өөс шинэчлэн баталсан тогтоолуудыг иргэд олон нийт, эрүүл мэндийн байгууллагуудад сурталчлан таниулах ажлын хүрээнд ОНХХ-ээс мэдээлэл сурталчилгааны үйл ажиллагааг идвэхжүүлж байгаа бөгөөд нийт 39 мэдээлэл бэлтгэн ЭМДЕГ-ын албан ёсны хаяг /emd.gov.mn, Фэйсбүүк, Инстаграмм, Твиттер/-т байршуулсан. Дээрх мэдээллийн 11 видео, постер 12, цаг үеийн мэдээ- 26, мэдээлэл байна. Эдгээр мэдээлэл давхардсан тоогоор 400 мянга гаруй иргэнд хүрч 2208 удаа хуваалцсан хандалттай байна. Эрүүл мэндийн байгууллагыг мэдээ, мэдээллээр хангах хүрээнд ЭМДЕГ-тай гэрээтэй нийслэл болон орон нутгийн лавлагаа шатлал, анхан шат болон гэрээт эмийн сангуудийн төлөөллүүдийг хамруулсан сургалтын мэдээлэл, Улаанбаатар хотын анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээ, мэдээллээр хангах сургалтын мэдээллүүдийг олон нийтэд мэдээлж, хэвлэл мэдээллийн 10 гаруй чат группд шэйрлэж ажиллалаа. Тогтоолуудад орсон өөрчлөлтүүдийн талаар БТГ-ын ахлах мэргэжилтэн Б.Янжиндолгор Eagle Телевиз, Булгантамир Tv8 телевизийн зочны цаг нэвтрүүлэгт оролцож мэдээлэл өгсөн. Мөн ТВ25, ТВ9, NTV, Тэнгэр ТВ, MNB, Mongol HD, C1, ТВ5, ТВ8 телевизүүд болон gerelnews.mn. arslan.mn, eguur.mn, erennews.mn, zarig.mn, zindaa.mn, negun.mn, news.mn, ikon.mn, Төр.мн, Монголын үнэн сонин зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд холбогдох газар хэлтсүүдээс тодруулга ярилцлага мэдээлэл өглөө. Байгууллагын www.emd.gov.mn сайтад ЭМДҮЗ-ийн 06 дугаар тогтоолуудыг бүрэн эхээр нь байршуулж, олон нийт болон ЭМБ-уудыг унших, судлах боломжоор хангасан. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 107. | 2.2.7 | | Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад тогтоолын талаар сургалт зохион | -ЭМДҮЗ-ийн 2022 оны 08 дугаар тогтоолыг шинэчлэх, шинэчлэн батлагдсан ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоолын талаарх сургалт, мэдээллийг ЭМДЕГ-ын | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгуулах; | даргын баталсан хөтөлбөр, удирдамжийн дагуу гэрээ бүхий лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад зохион байгуулсан. Цахим хэлбэрээр зохион байгуулагдсан 7 удаагийн хэлэлцүүлэг, сургалтад 250 хүн, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар дээр танхимаар зохион байгуулсан 9 удаагийн хэлэлцүүлэг, сургалтад 127 хүн буюу нийт 16 удаагийн сургалтад 380 гаруй эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтан, эмч, статистикч, эдийн засагч, даатгал хариуцсан болон эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан байна. Мөн гэрээ бүхий лавлагаа шатлалын 15 эрүүл мэндийн байгууллага дээр очиж тогтоолын талаарх аргазүйн зөвлөгөө, сургалтыг зохион байгуулсан. | | | |
| 108. | 2.2.8 | | Тогтоолын хэрэгжилтийн жил бүрийн тайланг Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлд жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан хүргүүлэх; | ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоол нь 04 сарын 05-ны өдрөөс хэрэгжиж байна. 2024 оны хэрэгжилтийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд 2025 оны 04 дүгээр сарын 21 ны өдөр хүргүүлсэн. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 109. | 2.2.9 | | Эрүүл мэндийн байгууллагуудаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэхэмжлэл, анхан шатны маягтын дагуух мэдээллийг бодит цагийн горимоор хүлээн авч, холбогдох эрх зүйн хүрээнд тусламж, үйлчилгээг худалдан авах. | -Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг бодит цагийн горимоор, анхан шатны маягтыг history@emd.gov.mn цахим хаягаар сард 2 удаа хүлээн авч нэхэмжлэлийн хяналтыг хийж байна. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 110. | 2.3.7 | | Тогтоолыг холбогдох хууль, журамд заасны дагуу Хууль зүйн яаманд бүртгүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын албанд даалгах; | Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай ЭМДҮЗ-ийн 05 дугаар тогтоолыг ЗХХАУНБ-ийн санд 6800 дугаарт шинэчлэн бүртгүүлсэн. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 111. | 1 | Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2024.03.29 №07 | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 03 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн тусламж, | ЭМДҮЗ-ийн 2024 оны 03 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг, чиглэлийн дагуу ЭМДҮЗ-ийн 2024 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Техникийн хорооны бүрэлдэхүүн, ажиллах журам”-ын “2.4.8.... даатгалын гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагад | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус техникийн хорооны бүрэлдэхүүн, ажиллах журам"-ын 2.4.8 дахь заалтын "даатгалын гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагад ажилладаггүй байх" гэснийг хассугай. | ажилладаггүй байх; заалтыг хасах нэмэлт, өөрчлөлтийг оруулан ЭМДҮЗ-ийн 07 дугаар тогтоолоор баталсан. Уг тогтоолын дагуу даатгалын гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагад ажилладаг 5 нэр дэвшигч техникийн хорооны гишүүнд тавигдах сонгон шалгаруулалтын шаардлагыг хангаж, гишүүнээр томилогдсон. | | | |
| 112. | 2 | | Тогтоолд өөрчлөлт орсонтой холбогдуулан орон тооны бус техникийн хорооны гишүүнд нэр дэвшигчдийг 2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанд нэр дэвшигч бүрээр танилцуулах | ЭМДҮЗ-ийн 2024 оны 03, 07 дугаар тогтоолыг үндэслэн Техникийн хорооны орон тооны бус гишүүнд материалаа ирүүлсэн, сонгон шалгаруулалтын шаардлага хангасан 9 хүнийг ЭМДҮЗ-ийн 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит 04 дүгээр хуралдаанд нэр дэвшигч бүрээр танилцуулан, ЭМДҮЗ-ийн 08 дугаар тогтоолоор Техникийн хорооны бүрэлдэхүүнийг батлуулсан. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 113. | 3 | | Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албанд даалгах; | Уг журмын "3.2. Техникийн хорооны нарийн бичгийн даргыг ажлын албаны дарга томилж, чөлөөлнө." гэж заасан тул уг заалтын дагуу Ажлын албаны даргын 2024 оны А/07 дугаар тушаалаар Техникийн хорооны нарийн бичгийн даргыг томилсон. Ажлын албанаас Техникийн хорооны гишүүдийн анхдугаар хурлыг 05 дугаар сарын 17-ны өдөр 100 хувийн ирцтэйгээр зохион байгуулж, гишүүдийн 100 хувийн саналаар Техникийн хорооны даргаар Ө.Анирыг томилсон. Мөн техникийн хорооны чиг үүрэг, гишүүдийн эрх, үүрэг болон ЭМДҮЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны товч тайланг танилцуулж, техникийн хорооны үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг гишүүдийн 100 хувийн саналаар баталж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 114. | 2 | Техникийн хорооны бүрэлдэхүүн батлах тухай 2024.04.30 №08 | Энэ тогтоолыг батлсантай холбогдуулан техникийн хорооны нарийн бичгийн даргыг томилох, техникийн хорооны үйл ажиллагааг удирдлага, зохион | ЭМДҮЗ-ийн 2024 оны 03 дугаар тогтоолоор баталсан "Техникийн хорооны бүрэлдэхүүн, ажиллах журам"-ын "3.2. Техникийн хорооны нарийн бичгийн даргыг ажлын албаны дарга томилж, чөлөөлнө." гэж заасан тул уг заалтын дагуу Ажлын албаны даргын 2024 оны А/07 дугаар тушаалаар Техникийн хорооны нарийн бичгийн | | | Тодорхой үр дүнд хүрсэн 70 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгууллалтаар хангаж, хяналт тавьж ажиллах, техникийн хорооны орон тооны бус гишүүдэд холбогдох журмын дагуу урамшууллыг тооцож олгохыг Ажлын албанд үүрэг болгох. | даргыг томилсон.<br>Техникийн хорооны гишүүдийн урамшууллын зардал 2024 оны үйл ажиллагааны зардлын төсөвт батлагдаагүйн улмаас Техникийн хороо 2024 онд ажиллаагүй болно. | | | |
| 115. | 3 | | Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан холбогдох хууль, тогтоол, журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлж, хариуцлагатай ажиллахыг техникийн хорооны орон тооны бус гишүүдэд даалгах. | Ажлын албанаас техникийн хорооны анхдугаар хурлыг 5 сарын 17-ны өдөр зохион байгуулж, хорооны гишүүдэд техникийн хорооны чиг үүрэг, гишүүдийн эрх, үүрэг болон ЭМДҮЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны товч тайланг танилцуулж, техникийн хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 116. | 4 | | Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан техникийн хорооны үйл ажиллагаанд шаардлагатай тооцоо судалгаа, нэмэлт баримт, мэдээ, мэдээллийг тухай бүр холбогдох хугацаанд нь ирүүлж ажиллахыг ЭМДЕГ-т даалгах. | ЭМДҮЗ-ийн 2024 оны 08 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар ЭМДЕГ-т 2024.06.03-ны өдрийн 58 албан тоотыг тогтоолын хамт хүргүүлсэн. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 117. | 2.1.1 | Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2024.07.22 №10 | 2024 оны төсвийн орлогын хуваарийн дагуу орлого бүрдүүлэлт, сангийн урсгалын тасралтгүй байдлыг хангаж, хяналт тавьж ажиллах; | *Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого:* Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 1,964.7 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд ЭМДҮЗ-ийн 2024 оны 01, 10, 15 дугаар тогтоолоор эрүүл мэндийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны 2024 оны төсвийн нарийвчилсан хуваарь болон хуваарийн өөрчлөлтийг тус тус баталж, хэрэгжилтийг хангуулсан.<br>Орлогын гүйцэтгэл 1,921.7 тэрбум төгрөг, үүнээс ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл 812.6 тэрбум төгрөг, төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл 324.1 тэрбум төгрөг, төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт 746.8 тэрбум төгрөг, бусад даатгуулагчаас төлөх шимтгэл 34.2 тэрбум төгрөг, бусад орлогоос 3.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 97.8 хувийн биелэлттэй байна. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ЭМДС-ийн орлогыг бүрдүүлж буй орлогын эх үүсвэрийн эзлэх хувийг авч үзвэл 42.3 хувийг ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл, 38.9 хувийг төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт, 16.9 хувийг төрөөс ЭМД-ыг хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл, 1.8 хувийг бусад орлого тус тус эзэлж байна. ЭМДС-ийн орлого өмнөх онтой харьцуулахад ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл 2.9 хувиар, төрөөс ЭМД-ыг хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл 2.3 хувиар өссөн бол төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт 5.1 хувиар, бусад орлого 0.1 хувиар тус тус буурсан байна. | | | |
| 118. | 2.1.2 | | Батлагдсан төсвийн зарлагын хуваарьт багтааж "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ"-нд тусгасан чанартай тусламж, үйлчилгээг худалдан авах, санхүүжүүлэх; | Батлагдсан төсвийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан 2024 онд бусад эх үүсвэрээс буюу Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 69.1 тэрбум төгрөг, ЭМЯ-аас 35.0 тэрбум төгрөг, нийт 104.1 тэрбум төгрөгийг нэмэлт санхүүжилтээр, мөн дансны үлдэгдлээс санхүүжих 5.2 тэрбум төгрөгийг нэмэлтээр төвлөрүүлж, нийт 109.3 тэрбум төгрөгийг нэмэлт эх үүсвэрээр төвлөрүүлжээ. | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |
| 119. | 1.1 | Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2024.10.03 №14 | "Тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд төрөлжсөн мэргэшлийн эмнэлгээс үзүүлж буй зарим тусламж, үйлчилгээг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт нутагшуулах цогц төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах" | ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 14 тогтоолыг батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>2024 онд шинэчлэн баталсан тогтоолыг хэрэгжүүлэх үеийн сургалт, уулзалт, хэлэлцүүлгийн явцад эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд, эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон иргэн, даатгуулагч нарт шинэчилсэн тогтоолын талаар нэгдсэн мэдээллээр хангасан бөгөөд эрүүл мэндийн байгууллагууд, иргэдийн зүгээс зарим зохицуулалтыг эргэн харах, өөрчлөх тодорхой саналуудыг ирүүлсэн. Мөн Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр УИХ-аар батлагдсантай холбоотойгоор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах зорилтын хүрээнд Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах, зарим тусламж, үйлчилгээг орон нутагт нутагшуулахад Эрүүл мэндийн сайдын холбогдох тушаалууд болон ЭМДҮЗ-ийн тогтоолын зарим зохицуулалтад бодлогын өөрчлөлт оруулах саналыг Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн бөгөөд тогтоолд нэмэлт, өөрчлөлтүүдийг | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | оруулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | | | |
| 120. | 3 | Эрүүл мэндийн даатгалын 2024 оны эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулах тухай 2024.11.07 №16 | ЭМДЕГ: Эрсдэлийн сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг 2024 оны 12 дугаар сарын 25-ны дотор гаргаж тайлагнах | 2024 оны эрсдэлийн сангийн 53.6 тэрбум төгрөгөөс лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардалд 43.6 тэрбум, амбулаторийн тусламж, үйлчилгээний зардалд 10.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна. | | | **Бүрэн хэрэгжсэн 100 хувь** |
| ***Хэсгийн дундаж хувь*** | | | | | | | ***98*** |
| **Нийт хэрэгжилтийн дундаж хувь** | | | | | | | **98.9** |

---ооОоо---